



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



ДЭЛХИЙН БАНКНЫ  
“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

# ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

**Зөвлөх:**

Доктор профессор Б.Тэмүүлэн

**Боловсруулсан:**

Ш.Ариунбилэг (Ph.D)

Б.Буянхишиг (LL.M)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй  
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”  
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот  
2013 он

**DDC  
323  
И-788**

## **ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ**

*Гарын авлага*

---

### **ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:**

**Зөвлөх:** Б.Тэмүүлэн (Доктор профессор)

**Зохиогчид:** Ш.Ариунбилэг (Ph.D)  
Б.Буянхишиг (LL.M)

**Хэвлэлийн хуудас:** 11.6

**Цаасны хэмжээ:** B5

**Хэвлэсэн тоо:** 1200

**Хэвлэсэн газар:** “BCI” Хэвлэлийн компани

**ISBN 978-99962-56-86-8**

© Энэхүү гарын авлага нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.



## ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН, БАГШ НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг

шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн Зохицуулагч  
Большорлоогийн Сарантуяа*

## ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг.

1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх Ухнаагийн Туяа (Ph.D)*

## БАТААГИЙН ТЭМҮҮЛЭН

*МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхлгийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, профессор.*



Иргэний эрх зүйн сурах бичиг, нэг сэдэвт судалгааны ном, гарын авлага, бодлогын судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг 30 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл хэвлүүлсэн. Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн.

## ШАРАВДОРЖИЙН АРИУНБИЛЭГ

*Хууль сахиулахын их сургуулийн иргэний эрх зүйн тэнхлгийн эрхлэгч, доктор /Ph/, дэд профессор цагдаагийн дэд хурандаа*



2011 оны МУИС-ын дэргэдэх Хууль зүйн докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр “ЭБША-г хэрэгжүүлэгчээс иргэнд учирсан хохирлыг арилгах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдвээр докторын зэрэг хамгаалсан.

Иргэний болон иргэний процессын чиглэлээр судалгаа хийдэг. Дангаараа болон бусадтай хамтран 5 бүтээл гаргасны зэрэгцээ 21 илтгэл, өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.



## БАТ-ЭРДЭНИЙН БУЯНХИШИГ



1999 онд Хүмүүнлэгийн Их Сургуулийн орос-герман хэл судлал, 2000-2005 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Алберт-Людвигийн нэрэмжит Их Сургуулийн Хуулийн факультетэд хууль, эрх зүйн бакалаврын сургалтад хамрагдаж хуулийн реферэндар болсон. 2003-2005 онд дээрх сургуулийн Европын болон гадаад орнуудын эрх зүйн нэмэлт сургалтад хамрагдаж, 2005-2007 онд тус улсын Оффенбург хотын Орон нутгийн шүүхэд дадлагажигчаар ажиллан 2007 онд Бадэн-Вюртэмбэрг муж улсын Хууль зүйн

Яамнаас зохион явуулдаг Хуульчдын Хоёрдугаар Улсын Шалгалтад хамрагдаж, хуулийн ассессор цол хүртсэн. 2009 онд МУИС-ийн ХЗС-ийн магистрын сургалтыг амжилттай дүүргэж, МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Иргэний эрх зүйн тэнхмийн багшаар ажиллахын зэрэгцээ хувийн эрх зүйн чиглэлээр докторын судалгааны ажил эрхэлдэг.

Оюутан суралцагсад зориулан 2009 онд Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 2010 онд Иргэний эрх зүйн ерөнхий анги, /Хамтын бүтээл/, Иргэний эрх зүйн тусгай анги, Иргэний эрх зүйн бодлогын хураамж, I дэвтэр; 2011 онд Үнэт цаасны эрх зүйн үндэс, Иргэний эрх зүйн тусгай анги /2-р хэвлэл/, Иргэний эрх зүйн бодлогын хураамж, II дэвтэр, 2012 онд Иргэний эрх зүйн удиртгал /Ерөнхий анги/, 2013 онд Үүргийн эрх зүйн ерөнхий анги зэрэг сурах бичиг, гарын авлагыг бэлтгэж гаргасан. Түүнчлэн мэргэжлийн чиглэлээр хэд хэдэн өгүүлэл бэлтгэж, илтгэл хэлэлцүүлж байсан ба сургалтын гарын авлага, хичээлийн хөтөлбөр боловсруулахад оролцсон болно.

## ӨМНӨТГӨЛ

Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд иргэний эрх зүйн салбарын үндсэн ойлголт, ухагдахуун, суурь асуудлыг хамарсан “Иргэний эрх зүйн ерөнхий анги” хичээлийн гарын авлагыг оюутан суралцагсад төдийгүй энэ салбарын багш нарт зориулан бэлтгэлээ. Энэхүү гарын авлагаар Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байсан “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд 2008 онд боловсруулагдсан иргэний эрх зүйн ерөнхий ангийн хичээлийн жишиг хөтөлбөрт тулгуурлан тус салбарын гол чухал хэрэглэгдэхүүнийг лекц, семинарын 40 цагт багтаан хүргэхийг зорилоо.

Иргэний эрх зүйн ерөнхий анги хичээл нь эрх зүйн чиглэлээр мэргэшсэн сургалт олгох аливаа их, дээд сургуулийн суурь мэдлэг эзэмшүүлэх болоод энэ чиглэлээр гүнзгийрэн суралцах эхлэлийг тавьдаг эрх зүйн салбарын үндсэн судлагдахуун байдаг. Энэ утгаараа тус гарын авлагыг боловсруулахад МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд процессор Б.Тэмүүлэн, мөн сургуулийн багш Б.Буянхишиг (Ass.juri), Хууль сахиулахын их сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph), дэд профессор цагдаагийн дэд хурандаа Ш.Ариунбилэг нар оролцсон бөгөөд энэ чиглэлээр мэргэшсэн, мэргэжилтэн бэлтгэх сургалтад хичээл заадаг, түүнчлэн хэд хэдэн бүтээл нийтлүүлж, илтгэл хэлэлцүүлэг явуулах ажилд оролцож байсан багш нарын туршлага чанартай гарын авлага боловсруулахад голлох үүрэгтэй байв.

Иргэний эрх зүйн салбар нь зах зээлийн эдийн засаг хөгжиж буй манай улсын хувь этгээд хоорондын бараа, үйлчилгээ солилцооны үндсэн горимыг зохицуулахад чиглэх тул энэ салбарт мэргэшин эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн дүгнэлт гаргах, сургалт судалгаа явуулах асар том боломж, хэрэгцээ шаардлага бийг дурьдахын сацуу энэ хичээлээр чиглүүлэх сургалт олгох, иргэний эрх зүйн салбарт нийтлэг хуулийн зохицуулалттай танилцуулах гарын авлагыг нийтэд хүргэж байгаадаа их баяртай байгаагаа, мөн уг төслийг хэрэгжүүлж буй Дэлхийн банкны хамт олондоо гүнээ талархсанаа илэрхийлье.

**Зохиогчид**



## ГАРЧИГ

### I ХЭСЭГ. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн тодорхойлолт

I.1. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн танилцуулга.....	8
I.2. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага ...	9
I.3. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн зорилго .....	9
I.4. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн зорилт .....	9
I.5. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт .....	10
I.6. Багшид тавигдах шаардлага.....	11

### II ХЭСЭГ. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн агуулга

Нэгдүгээр бүлэг. Иргэний эрх зүйн ойлголт .....	13
Хоёрдугаар бүлэг. Иргэний эрх зүйн харилцаа.....	27
Гуравдугаар бүлэг. Хэлцэл .....	50
Дөрөвдүгээр бүлэг. Төлөөлөл.....	78
Тавдугаар бүлэг. Иргэний эрх зүй дэх хугацаа.....	82
Зургадугаар бүлэг. Эдийн болон эдийн бус баялгийн эрх .....	89
Долдугаар бүлэг. Үүргийн эрх зүй .....	94
Наймдугаар бүлэг. Иргэний эрх зүйн хариуцлага .....	113

## I ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ /ЕРӨНХИЙ АНГИ/ ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### I.1 Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр:	Иргэний эрх зүй /ерөнхий анги/
Индекс:	
Нийт цаг:	40 цаг /24 цаг лекц, 16 цаг семинар/
Кредит:	2
Судлах семестр :	III

Залгамж холбоо: Энэ хичээлийг Эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй зэрэг хичээлийн дараа эсхүл зэрэгцүүлэн судлавал зохино.

Д/д	Заавал судалсан байх хичээл	Үндэслэл
1.	Эрх зүйн онол	Нийгмийн харилцааг зохицуулагч хэм хэмжээнүүд, тэдгээрээс эрх зүйн хэм хэмжээний онцлог шинжийг ялган, эрх зүй, хууль хоорондын харилцан хамаарлын талаар мэдсэн байх. Эрх зүй нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулахдаа өөрийн гэсэн зохицуулах зүйл, арга, зарчимтай байх зэрэг онолын мэдлэгийг олж авсаны үндсэн дээр нэг салбар эрх зүйг бусад салбар эрх зүйгээс ялган тодорхойлох чадвартай болсон байх нь иргэний эрх зүй хичээлийг салбар эрх зүй болохынх нь хувьд гүнзгийрүүлэн судлах суурь нь болох тул энэ хичээлийг юун түрүүнд судалсан байх нь зүйтэй.
2.	Үндсэн хуулийн эрх зүй	Аливаа салбар эрх зүйн үндсэн эх сурвалж болох Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчмыг танин мэдсэнээр Иргэний эрх зүй төдийгүй бусад салбар эрх зүйг гүнзгийрүүлэн судлахад чухал тулгуур болно.
3.	Логик	Аливаа үзэгдэл, юмсын зүй тогтол, мөн чанар, тэдгээрийн харилцан хамаарлыг онолын төвшинд, категорчилсан байдлаар сэтгэлгээний олон аргаар танин мэдэх мэдлэг, чадварыг эзэмшсэн байх нь иргэний эрх зүй хичээлийн агуулга, мөн чанар, хэрэгцээг хууль зүйн шинжлэх ухааны түвшинд үнэлэх төдийгүй, иргэний хуулийн зохицуулалт, түүний үр нөлөө, хууль хоорондын харилцан хамаарал, хэрхэн систем болж буй талаарх өөрийн дүгнэлтийг өгөх, мөн иргэний эрх зүйн аливаа хэм хэмжээг амьдралд хэрхэн зүй зохистойгоор хэрэгжүүлэх талаар задаргаа, дүгнэлт гаргахад арга зүй нь болдог тул уг хичээлийг судалсан байх нь зүйтэй.
4.	Гадаад хэл	Иргэний эрх зүй хичээлийн лекцээр олсон мэдлэгийг бататган гүнзгийрүүлэх, бие даан сурацгах, семинарын хичээлд бэлтгэх зэрэгт гадаад хэл дээр хэвлэгдсэн ном, сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сонин сэтгүүл, интернэт сайтыг ашиглахад дөхөм болох тул гадаад хэлний хичээлийг судалсан байх шаардлагатай.



**Үнэлгээ:** Иргэний эрх зүй хичээлээр оюутныг үнэлэх үнэлгээний дээд хувь нь 100 хувь байх бөгөөд хичээлийн явцад оюутан үнэлгээний 60 хүртэлх хувийг идэвх оролцоо, бие даалтын ажил, явцын шалгалтаар цуглуулна. Эцсийн шалгалтаар үнэлгээний 40 хүртэлх хувийг авна.

## **1.2 Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага**

Эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдцыг даган нийгмийн харилцаа байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг агаад энэхүү өөрчлөгдөж буй харилцааг хуулиар зохицуулах шаардлага бий болдог нь ойлгомжтой. Хөгжлийн дагуу бий болох шинэ шинэ үзэгдлийг зөв загварчлан хуульчлахын тулд хууль тогтоомжийг шинээр гаргах, шинэчлэх, өөрчлөлт хийх, хэрэглэх, хэрэгжүүлэхэд эрх зүйн шинжлэх ухааны онолын мэдлэг зайлшгүй шаардлагатай байдаг.

Нийгмийн амьдралын эдийн засгийн харилцааны тулгуур зохицуулалт болох иргэний эрх зүйг судлахгүйгээр хуульч мэргэжлийн аливаа ажлыг эрхлэх боломжгүй бөгөөд энэ хичээлийг судалсанаар эрх зүйн салбар хоорондын уялдаа болон онцлог шинжүүдийг зөв танин мэдэх, эдийн засгийн харилцааны цаашдын хөгжлийн чиг хандлага, бодит зүй тогтлуудыг зөв загварчлан хуульчлах, хууль тогтоомжийг хэрэглэх, хийдэл гарсан нөхцөлд хэрхэн зохицуулах талаар шинжлэх ухааны гүн бат мэдлэг олж авах, мэдлэгээ ажил мэргэжил, амьдралд хэрэглэж, хэрэгжүүлж сурах чадвар, дадлыг эзэмшсэн байх шаардлагатай.

## **1.3. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн зорилго**

Энэхүү хичээлээр иргэний эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчмын хүрээнд иргэний эрх зүйн ерөнхий ангийн үндсэн ойлголтуудын талаар онолын мэдлэг олгох, иргэний эрх зүй хичээлийн тусгай ангийг судлах үндсэн суурийг эзэмшүүлэх, цаашид иргэний хууль тогтоомжийг хэрэглэх чадвар дадалтай болгох, оюутан олж авсан онолын мэдлэгтээ тулгуурлан иргэний эрх зүйн аливаа харилцааг иргэний эрх зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, үнэлж дүгнэх чадвар эзэмшихийн зэрэгцээ хууль зүйн мэргэжлийн ур чадвартай болох эрмэлзлэлийг бий болгоход оршино.

## **1.4. Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн зорилт**

- Эрх зүйн тогтолцоонд иргэний эрх зүйн гүйцэтгэх үүргийг тодорхойлж сурах;
- Иргэний эрх зүй, бусад салбар эрх зүйн ялгаатай болон төсөөтэй талуудыг тодорхойлох;

- Иргэний эрх зүйн түүхэн хөгжил, түүний үе шат, онцлогийг судлах, иргэний эрх зүйн аливаа асуудлыг уламжлал, шинэчлэлийн хүрээнд авч үзэх;
- Иргэний эрх зүйн онолын суурь мэдлэг эзэмших;
- Иргэний эрх зүйн талаар өөрийн мэдлэгийг бүтээх;
- Иргэний эрх зүйн үндсэн ойлголтуудыг тайлбарлаж, хэрэглэх мэдлэг, чадвар эзэмших;
- Асуудалд иргэний эрх зүйн онолын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмших;
- Олж авсан мэдлэгээ практикт бүтээлчээр хэрэглэх, хууль хэрэглэх дадал чадварыг эзэмших.

## 1.5 Иргэний эрх зүй /ерөнхий анги/ хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цагийн хуваарилалт

№	Бүлгийн нэр	Лекцийн хичээлийн сэдвийн нэр	Цаг	Семинарын хичээлийн сэдвийн нэр	Цаг
1.	Иргэний эрх зүйн ойлголт	Иргэний эрх зүй бие даасан салбар эрх зүй болох нь	2		
				Иргэний эрх зүйн эх сурвалж, Иргэний хууль тогтоомжийг хэрэглэх	2
2.	Иргэний эрх зүйн харилцаа	Иргэний эрх зүйн харилцааны ойлголт, ангилалт, элемент	2		
		Иргэн - иргэний эрх зүйн харилцааны субъект болох нь	2		
		Хуулийн этгээд - иргэний эрх зүйн харилцааны субъект болох нь	2		
				Иргэний эрх зүйн харилцааны элемент, тэдгээрийг танин мэдэхүйн практик ач холбогдол	2
				Иргэний эрх зүйн хамгаалалт	2
3.	Хэлцэл	Хэлцлийн ойлголт, ангилалт, хэлцэлд тавигдах шаардлага	2		
		Хүчин төгөлдөр бус хэлцэл, үр дагавар	2	Хүчин төгөлдөр бус байх, хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцлүүдийг зүйлчлэх нь	2



4.	Төлөөлөл	Төлөөллийн ойлголт, төрөл	2		
5.	Иргэний эрх зүй дэх хугацаа	Иргэний эрх зүй дэх хугацааны ойлголт, ангилалт, хугацаа тоолох журам	2		
6.	Эдийн болон эдийн бус баялгийн эрх	Эдийн болон эдийн бус баялгийн эрх. Эзэмшил	2	Эзэмших болон өмчлөх эрхийг хамгаалах аргууд	2
7.	Үүргийн эрх зүйн нийтлэг үндэслэл	Үүргийн ойлголт, үүргийн агуулга, төрөл, үүргийн субъект	2		
		Үүрэг гүйцэтгэх зарчим, үүргийн гүйцэтгэлийг хангах арга	2		
		Гэрээний бус үүрэг, түүний төрөл	2		
				Гэрээний болон гэрээний бус үүргийн зүйлчлэл	4
8.	Иргэний эрх зүйн хариуцлага			Иргэний эрх зүйн хариуцлагын ойлголт, хариуцлага хүлээлгэх үндэслэл, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл	2
	Нийт цаг		24		16

## 1.6 Багшид тавигдах шаардлага

### Мэргэжлийн талаар:

Хууль зүйн шинжлэх ухааны онолын гүн бат мэдлэгтэй, иргэний эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, онолын мэдлэгээ практиктай холбож ойлгох, бусдад ойлгуулах чадвартай, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүй, боловсрол судлал, заах арга зүйн зохих мэдлэг чадвар эзэмшсэн, багшийн ёс зүй төлөвшсөн мэргэжилтэн байна.

## **Заах арга зүйн хувьд:**

- Лекц унших, семинар болон оюутны бие даалтын ажлыг удирдахдаа бусад салбар эрх зүй болон тухайн хичээлийн сэдэв хоорондын уялдааг оновчтой хангаж, оюутны сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх арга зүйг эзэмшсэн байх;
- Оюутны мэдлэг болон лекцээр олж авсан мэдээлэл дээр суурилан онолын мэдлэгийг бүтээх үйл явцыг удирдаж чаддаг байх;
- Мэдээлэл түгээх болон оролцооны идэвхтэй аргуудыг ашигладаг байх.
- Бусад:
- Сургалтын материал /сурах бичиг, лекцийн тэмдэглэл, семинарын сэдэв, үлгэрчилсэн ажилбар зэрэг/-ыг шинэлэг хэлбэрээр бэлтгэх, тэдгээрийг ашиглах аргыг оюутнуудад зааж сургах,
- Оюутнуудад зориулсан гарын авлагыг товч, тодорхой, энгийн хялбаршуулсан аргаар бэлтгэх,
- Хичээлээр олсон мэдлэг, чадварыг үнэлэх зохист шалгуурыг сонгон авч, оюутан нэг бүрийг бодитойгоор дүгнэх чадвартай байх
- Орчин үеийн техник хэрэгсэл ашиглан сургалтыг зохион байгуулах чадвартай байх.



# I ХЭСЭГ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЕРӨНХИЙ АНГИ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ

**Сэдвийн зорилго:** Иргэний эрх зүйн үндсэн ухагдахууны талаар иргэний эрх зүйн шинжлэх ухааны үндэслэл бүхий онолын мэдлэг олгох, цаашид тухайн салбар эрх зүйн бусад институт хэм хэмжээ, тэдгээрийн мөн чанар, уялдаа холбоог гүнзгийрүүлэн судлах онол, арга зүйг эзэмшинэ.

### НЭГ. ТОЙМ ЛЕКЦ

#### 1.1 Иргэний эрх зүй бие даасан салбар эрх зүй болох нь

Иргэний эрх зүй гэдэг нь эдийн ба эдийн бус харилцаанд оролцогч бүрт тэгш үйлчилдэг хувийн эрх зүйн нэг хэсэг юм.<sup>1</sup>

Хувийн эрх зүй гэдэг нь тэгш эрхтэй эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн нэг салбар юм. Харин нийтийн эрх зүй нь босоо харилцаа буюу захирах, захирагдах харилцааг зохицуулдаг.

**Хувийн ба нийтийн эрх зүй нь дараах шинжүүдээр хоорондоо ялгарч байдаг.**

1. Аливаа хэрэг хувийн эрх зүйн, эсвэл нийтийн эрх зүйн дагуу шийдвэрлэгдэх нь тухайн тохиолдолд ямар эрх зүйн хэм хэмжээ хэрэглэгдэхээс хамаарна. Жишээ нь, А компани өөрийн офисын барилгын гаднах орчинг тохижуулах, мод тарьж цэцэгжүүлэх зорилгоор цэцэгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг Б компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ. /Энэ харилцаа нь хувийн эрх зүйн харилцаа/

Харин хотын захирагчийн гаргасан захирамжийн дагуу албан байгууллага бүрт орчин тойрноо цэцэрлэгжүүлэх, мод тарих үүрэг хүлээсэн бол энэ нь нийтийн эрх зүйн харилцаа болно.

2. Нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллаараа ялгаатай байдаг. Тухайлбал, нийтийн эрх зүйтэй холбоотой захиргааны маргаан гарсан бол түүнийг захиргааны шүүх шийдвэрлэдэг бол хувийн эрх зүйгээс үүдэлтэй маргааныг ердийн шүүх хянан шийдвэрлэдэг.

<sup>1</sup> Э.Байгаль "Иргэний эрх зүйн ерөнхий анги" УБ., 2009 он 3-р тал

Нийтийн эрх зүйгээр зохицуулах харилцаа	Хувийн эрх зүйгээр зохицуулах харилцаа
<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн байгууллагууд, иргэд ба төрийн хоорондын харилцааг зохицуулдаг төрийн эрх зүй</li> <li>- Нийтийн захиргааны байгууллага бусад байгууллага иргэдтэй харилцах харилцааг зохицуулдаг захиргааны эрх зүй, татварын эрх зүй, гаалийн эрх зүй</li> <li>- Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд төрөөс хүлээлгэх хариуцлагыг зааж өгдөг Эрүүгийн эрх зүй</li> <li>- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд үйлчилдэг Процессийн эрх зүй</li> </ul>	<p>Нийгмийн ашиг сонирхлын ухаалаг тэнцвэрийг тогтоох ба дэмжих, эрчимтэй хөгжиж буй нийгмийн харилцааг уян хатан болгох, хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэн хамгаалахад чухал үүргийг гүйцэтгэдэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэний эрх зүй</li> <li>- Олон улсын иргэний эр зүй</li> <li>- Хөдөлмөрийн эрх зүй</li> <li>- Өмчийн эрх зүй</li> <li>- Үүргийн эрх зүй</li> <li>- Худалдааны эрх зүй</li> <li>- Аж ахуйн эрх зүй</li> </ul>

Иргэний эрх зүй нь Монгол улс дахь эрх зүйн тогтолцооны бие даасан салбар бөгөөд харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцааг талуудын эрх тэгш байдалд үндэслэн тэдгээрийн хүсэл зориг болон эд хөрөнгийн бие даасан байдлыг ханган зохицуулж байгаа хэм хэмжээний системчлэгдсэн нийлбэр цогц юм.<sup>2</sup> Уг эрх зүй нь эрх зүйн аливаа бүлд өөрийн гэсэн эзлэх байр суурийг нэгэнт олсон томоохон салбар эрх зүй юм.

“Иргэний эрх зүй” хэмээх нэр томъёо нь эртний Ромын эрх зүйгээс гаралтай. Ромын иргэд эд хөрөнгөө өмчлөх, эзэмших эрхтэй гэсэн үзэл, сэтгэлгээ бий болж улмаар тэр нь эрх зүйгээр баталгаажин эрх зүйн системд (**JUS CIVIL**) буюу Иргэний эрх зүй гэсэн салбар болон үүсэн хөгжсөөр бидний үед хүрч ирсэн.

Иргэний эрх зүй нь хувийн эрх зүйн гол цөм болдог бөгөөд ерөнхий хувийн эрх зүйгээс тусгай хувийн эрх зүйн салбарууд үүсэн гарч байдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр олон тооны тусгай салбарууд бий болсон. Үүний улмаас өнөөдөр иргэний эрх зүй нь ерөнхий хувийн эрх зүй бөгөөд харин гагцхүү тухайн харилцаанд оролцогч этгээдэд үйлчлэх хувийн эрх зүйг тусгай хувийн эрх зүй гэж нэрлэдэг.

Аливаа салбар эрх зүй нь бие даасан салбар эрх зүй байх гол шалгуур нь зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай байх явдал юм.


<sup>2</sup> Д.Наранчимэг “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ, 1999 он 1-р тал



### Иргэний эрх зүйн зохицуулах зүйл

Иргэний эрх зүйн зохицуулах зүйл гэдэг нь тухайн салбар эрх зүйгээр зохицуулагдаж байгаа нийгмийн тодорхой төрлийн харилцаа юм.

Иргэний эрх зүйн зохицуулах зүйл нь **эрх зүйн этгээдүүдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаа юм.**



**Эдийн баялагтай (эд хөрөнгийн харилцаа) холбоотой харилцаа нь** эд юмс, түүнийг олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотойгоор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүсч байгаа харилцаа юм. Уг харилцаа нь ямагт өөртөө эдийн засгийн утгыг агуулж байдгаараа онцлог юм.<sup>3</sup>



**Эдийн бус баялагтай холбоотой харилцаа (эд хөрөнгийн бус харилцаа) нь** явцуу утгаараа оюуны үнэт зүйлс, эрхтэй холбоотойгоор субъектүүдийн хооронд үүсэх харилцаа юм. Харин өргөн утгаараа ажил үйлчилгээ, оюуны үнэт зүйл, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, амь бие эрүүл мэнд болон эд хөрөнгийн болон бусад эрхтэй холбоотой үүсэх харилцаа юм.



<sup>3</sup> Б.Баттөмөр "Монгол улсын иргэний эрх зүй" УБ, 2004 он 8-р тал

## Иргэний эрх зүйн зохицуулалтын арга

Салбар эрх зүй бүр нийгмийн харилцааг зохицуулах зохицуулалтын аргатай байх бөгөөд энэ нь түүнийг бие даасан салбар эрх зүй эсэхийг тодорхойлох нэг шалгуур болно.

Иргэний эрх зүйн зохицуулалтын арга гэдэг нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын зан төлөвт нөлөөлөх арга хэрэгсэл<sup>4</sup> юм.

Иргэний эрх зүйн үндсэн бөгөөд уламжлалт арга нь **субъектүүдийг нь иргэний эрх зүйн харилцаанд тэгш эрхтэй оролцуулах арга** байна.

2 дахь арга нь **зөвшилцөх арга** юм. Энэ нь аж ахуйн харилцааг харилцан тохиролцож үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох, төрөл бүрийн гэрээг байгуулахад хэрэглэгдэх арга юм. Иргэний эрх зүйн зохицуулалтын гурав дахь арга нь **зөвлөмжийн арга** юм. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хууль бус үйлдэл, эс үйлдэлд хүлээлгэх **хариуцлага** нь зохицуулалтын арга болно гэж үздэг.

### 1.2 Иргэний эрх зүйн тогтолцоо, зарчим

Иргэний эрх зүйн зарчим гэдэг нь иргэний эрх зүйн хэм хэмжээг тогтоох, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, эрх үүргийг хэрэгжүүлэхэд мөрдлөг болгох үзэл баримтлал буюу үндсэн чиглэмж юм.

Монгол улсын Иргэний эрх зүйн үндсэн зарчмуудыг Иргэний хуулийн 1.2-т зааж өгсөн байдаг. Энд зааснаар иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид дараах зарчмуудыг баримтлана.

#### 1. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид тэгш эрхтэй байх зарчим

Иргэн эсхүл хуулийн этгээд, эсхүл төрийн байгууллагын аль нь байхаас үл хамааран иргэний эрх зүйн харилцаанд л оролцож байгаа бол эдгээр этгээд нь бүгд тэгш эрхтэй байна.

#### 2. Оролцогчид нь бие даасан байх зарчим

Иргэний эрх зүйн харилцаанд аливаа этгээдийг оролцохыг төрөөс буюу бусад субъектээс ялгагдах боломжгүй. Гагцхүү хуульд заасан тохиолдолд, тухайлбал бусдад гэм хор учруулсан, дундын өмчлөлтэй холбоотойгоор тухайн этгээдийн эсрэг шаардлага гаргах тухай хуульд зөвшөөрсөн тохиолдолд үүрэг хүлээж буй хариуцагч субъект болж оролцох ёстой болдог.<sup>5</sup>

#### 3. Өмчийн халдашгүй байдлын зарчим

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийн нэг нь аливаа этгээдийн өмчийн халдашгүй байдал юм. Монгол улсын Үндсэн хууль болон

<sup>4</sup> Хэрэгсэл гэдэг нь аливаа юманд хэрэглэх зүйл. (Я.Цэвэл) Өөрөөр хэлбэл, зохицуулалтын арга нь эрх зүйгээр нийгмийн харилцааг зохицуулахад оролцогчдод нь нөлөөлж байгаа зүйл юм.

<sup>5</sup> Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. /ерөнхий анги./, УБ 2005 он., 9 дүгээр тал



иргэний хуульд зааснаар иргэд хуулийн этгээд, төр өмчийн аль хэлбэр төрлийг эзэмших ашиглах захиран зарцуулах бүрэн эрхтэй байна.

Хууль ёсоор олж авсан өмчийг хэн нэгэн этгээд хууль бусаар ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг хориглоно. Өмчлөгчийн эрхийг хамгаалах нь шүүх, арбитрын гол үүрэг болно. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйд ямар ч тохиолдолд өмчлөгчийн эрхийг шудрагаар хамгаалах зарчим баримтална.

#### **4. Гэрээний эрх чөлөөний зарчим**

Энэ нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь нэгд, өөрийн түншийг чөлөөтэй сонгох, хоёрт, иргэний хуулиар тогтоосон гэрээ хэлцлийн нөхцөлийг чөлөөтэй сонгож хэрэглэх бололцоог олгосон зарчим юм. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч иргэнд гэрээний эрх чөлөөний зарчмыг хэрэгжүүлэх явцад хуульд заасан үндэслэлгүйгээр саад тотгор хийх, хориг хязгаар тавих эрхгүй юм.

#### **5. Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим**

Энэ зарчим нь бусад зарчмын агуулгад ерөнхийдөө хамаарах нийтлэг шинжийг өөртөө агуулдаг. Тухайлбал: Гэрээний эрх чөлөөний, эрх тэгш бие даасан байдлын, өмчийн халдашгүй байдлын гэх мэтээр бүгдэд нь хөндлөнгөөс оролцохгүй байх утга санаа агуулагдаж байна. Энэ нь утга санаа давхардаж байна гэсэн үг биш харин уг зарчмын ач холбогдлыг илэрхийлж байна гэсэн үг юм. Манай орон зах зээлийн эдийн засгийн зарчмаар хөгжих болсонтой холбогдон нийгмийн харилцаанд төрийн диктатур харьцангуй багасч, тэр байтугай иргэний харилцаанд төр бусад оролцогчидтойгоо адил эрхтэй оролцох болсон нь иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төрийн болон орон нутгийн байгууллагаас хөндлөнгөөс хутгалдан оролцох байдлыг хязгаарласан болно. Уг зарчим нь эрх зүйн этгээдүүдээс үйл ажиллагаагаа бие даан явуулах нөхцөл боломжийг олгоход чиглэнэ.

#### **6. Иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүй биелүүлэх, хэрэгжүүлэх зарчим**

Тухайн орны нийгмийн хөгжлийн чиг баримжаанаас хүний эрхийн баталгаажилт, хэрэгжилт ихээхэн шалтгаалдаг. Энэ нь төрийн ардчилсан бус дэглэмтэй улс орнуудын эрх зүйд хүний эдлэх эрхийн боломжийг хязгаарлалтайгаар тусгаж өгдөгтэй холбоотой юм. Монгол улсын тухайд “...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон нь эрхийн хязгаарлалтыг арилгах үндэс болсон юм. Тиймээс иргэний болон бусад хууль тогтоомжоор олгогдсон боломжийг бүрэн эдлэх нь уг харилцаанд оролцогчдын хувьд чөлөөтэй. Өөрөөр хэлбэл, энэ зарчим нь “хуулиар хориглоогүй бүхэн зөвшөөрөгдөх” утга санааг давхар агуулна.

## 7. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх зарчим

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд иргэний эрх зүйн хамгаалалтыг хуулиар тогтоож өгсөн байдаг. Учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, зайлшгүй тохиолдолд эрх зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор өөртөө туслах үйлдэл хийх, эрхээ хүлээн зөвшөөрүүлэх зэрэг аргыг иргэний хуульд зааснаар хэрэглэдэг.

## 8. Шүүхээр хамгаалуулах зарчим

Зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийн тулд аливаа этгээдэд шүүх, арбитрт хандах боломжийг олгодог. Иргэний эрх зүйн харилцаанд оролцож, түүнийхээ үр дүнд хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх үүргийг Иргэний хуулийн 206.1-д заасан байдаг. Гэсэн хэдий ч практикт ийнхүү хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, улмаар нөгөө талынхаа буюу бусдын эрхийг зөрчих нь элбэг тохиолддог тул зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шаардаж шүүх, арбитрт хандах эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.14-т зааснаар олгосон байдаг.

### Иргэний эрх зүйн тогтолцоо

Аливаа салбар эрх зүй нь өөрийн зохицуулах зүйлтэй салшгүй холбоотойгоор системчлэгдсэн хэм хэмжээнүүдийн зохион байгуулалттай нийлбэр байдаг. Энэхүү нийлбэр нь зохицуулж буй харилцааныхаа төрөл, онцлог, нарийвчлан зохицуулах шаардлагатай уялдан эрх зүйн салбар, дэд салбаруудад хуваагдана.

Ерөнхий анги	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэний эрх зүйн үндсэн асуудал</li> <li>• Иргэний эрх зүйн харилцаа</li> <li>• Хэлцэл</li> <li>• Иргэний эрх зүй дэх хугацаа</li> <li>• Эдийн ба эдийн бус баялгийн эрх</li> <li>• Үүргийн эрх зүй</li> <li>• Иргэний эрх зүйн хариуцлага</li> </ul>
Тусгай анги	<ul style="list-style-type: none"> <li>• Үүргийн тусгай төрөл</li> <li>• Өв залгамжлалын эрх зүй</li> <li>• Оюуны өмчийн эрх зүй</li> <li>• Олон улсын иргэний эрх зүй</li> </ul>

### 1.3 Иргэний эрх зүйн эх сурвалж, иргэний хууль тогтоомжийг хэрэглэх

Иргэний эрх зүйн эх сурвалж гэдэг нь:

- ◆ Иргэний эрх зүйн хэм хэмжээний илрэн гарах гадаад хэлбэр юм.
- ◆ Иргэний эрх зүйн хэм хэмжээг илэрхийлэх, бэхжүүлэх албан ёсны хэлбэр юм.



Иргэний эрх зүйн сурвалж		
Үндсэн эх сурвалж	Гол эх сурвалж	Бусад эх сурвалж



### Иргэний хуулийн үйлчлэл

#### 1.4 Иргэний эрх зүйн хамгаалалт

Монгол улсын иргэн эд юмсыг хууль зүйн дагуу олж авах, өмчлөх, захиран зарцуулах, сонирхсон аж ахуйн нэгжээ байгуулах /эсвэл байгуулахгүйгээр/ замаар эрхлэн хөтлөх эрхээр хангагдсан байдаг. Монгол улсын Үндсэн хуулиар олгогдсон энэхүү эрх зөрчигдвөл түүнийг хамгаалах арга хэлбэрийг иргэний хуульд нарийвчлан заасан байна.

**Хамгаалалт гэдэг нь бүрэн эрх бүхий этгээд өөрийгөө болон бусад этгээдийг хамгаалах зорилгоор тодорхой үйлдэл хийх, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаар иргэний, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах иргэний эрх зүйн субьектив эрхийг хэлнэ.**

Энэхүү субьектив эрхийн хүрээнд эрх нь зөрчигдсөн этгээд болон бусад субьектийн зүгээс эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, аюулыг зайлуулах арга хэмжээг аваад зогсохгүй үндсэн зорилго нь эрхийг зөрчигдөхөөс өмнөх байдалд эргүүлэн сэргээх явдал юм.

Иргэний эрх зүйн хамгаалалт өөртөө дараах шинжийг агуулсан байдаг.

- ♦ Эд хөрөнгөний ба түүнтэй холбоотой эд хөрөнгөний бус эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх үүргийг хуулийн дагуу хэвшүүлэн тогтоох.
- ♦ Иргэний эрх зүйн субьектүүдийн өмчлөх эрх зөрчигдсөн бол түүнийг хэрхэн сэргээх арга хэлбэрийг өөртөө агуулсан байдаг.

- ◆ Төрийн албадлагын хэрэгсэл болдог.
- ◆ Шүүх, арбитраас зөрчигдсөн эрхийг иргэний хуульд заасан аргаар сэргээж, хариуцлага хүлээлгэж байгаа шийдвэр нь бусад субьектэд зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж болдог.

Иргэний эрх зүйн хамгаалалтын хэлбэр

- Шүүхийн журмаар хэрэгжих хэлбэр
- Шүүхийн бус журмаар хэрэгжих хэлбэр

**Иргэний эрх зүйд дараах хамгаалалтын арга байна.**

### **1. Эрхийг хүлээн зөвшөөрөх**

Эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд бий болсон тодорхой бус байдлыг арилгах тэдгээрийн эрх, үүргийг хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлыг бий болгох, үүнд саад болж байгаа гуравдагч этгээдийн үйлдлийг таслан зогсооход чиглэгдсэн арга хэрэгслийг эрхийг хүлээн зөвшөөрөх арга гэнэ.

Эрхийг хүлээн зөвшөөрөх явдал нь шүүхийн журмаар хэрэгжих иргэний эрх зүйн хамгаалалтын арга юм.

### **2. Эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх**

Албадлагыг төрийн эрх бүхий этгээд тогтоосон журмын дагуу хэрэглэх эрхтэй. Тиймээс шүүх, арбитр нь талууд харилцан тохиролцох боломжгүй болсон бөгөөд нэг талын эрх ашгийг зөрчсөн үйлдлийг сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр зогсоон өмнөх байдалд нь сэргээж болно. Энэ тохиолдолд эрх зөрчсөн үйлдэл нь үргэлжилсэн шинжтэй байна. Жишээ нь, Иргэн А-г машинаа гражнаас нь гаргах боломжгүй болгон урдуур нь шуудуу татсан үйлдлийг зогсоох, машиныг хэрэглэх боломжоор хангах.

### **3. Хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх**

Хууль болон хэлцлийн үндсэндээ хүлээсэн үүргийг нь гүйцэтгүүлэх байдлаар зөрчигдсөн эрхийг сэргээх арга юм. Энэ нь хүлээсэн үүргээ гүйцэтгэхгүй хойш суух гэх мэт идэвхгүй хэлбэрээр илэрнэ. Жишээ нь: зээлдэгчээс мөнгөө төлүүлэх тухайн нэхэмжлэгчийн нэхэмжлэлээр шүүх хариуцагчаас зээлсэн мөнгийг нь гаргуулах, хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийг нь гүйцэтгүүлэх г.м

### **4. Учруулсан хохирлыг арилгуулах**

Энэ нь хохирол учруулсан гэм буруутай этгээдээр хохирлыг нь нөхөн төлүүлэх маягаар нэхэмжлэгч этгээдийн эдийн засгийн хувьд алдаагүй болгох арга юм. Нөгөө талаар дээр дурьдсан болон бусад аргуудын үр дагавар байдлаар илэрч болох ба идэвхтэй үйлдэл ч байж болно. Тухайлбал: үүрэг



бүхий тал хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, эрх зөрчсөн үйлдлээ өмнөх байдалд нь сэргээгээгүйн улмаас болон санаатай үйлдлээр учирч буй хохирлыг арилгуулах г.м

### **5. Эдийн бус гэм хорыг арилгуулах**

Энэ нь өргөн утгаараа эдийн бус баялагт учирсан гэм хорыг арилгах, явцуу утгаараа “Бусдын нэр төр, алдар хүнд, хувийн нууцад учруулсан гэм хорыг арилгах” асуудал юм. Гэм хор нь тухайн этгээдэд учирсан таагүй, сөрөг үр дагавраар нь тодорхойлогдох бөгөөд гэм хорын мөнгөн илэрхийлэл болсон хохирлыг тооцох нь нилээд ярвигтай асуудал юм. Жишээ нь, нэр төр гутаагдсан хэмээх нэхэмжлэлийг шүүх хянаж үзээд үндэслэлтэй бол эд хөрөнгийн хохирол болон эдийн бус гэм хорыг арилгуулна.

### **6. Хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх**

Талууд урьдчилсан байдлаар торгууль, алданги төлөхөөр тохиролцсон эсвэл хуульд заасан бол тухайн анзыг төлөх үүрэгтэй. Энэ талаар талуудын маргааныг таслахдаа шүүх, арбитр тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан анз төлөх хэмжээг шийдвэрлэнэ. Жишээ нь, Шүүх торгуульд анз эсвэл тооцох анзын аль нэгийг нь сонгож болно.

### **7. Бусдын эрх зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох**

Хуулиар шүүх, арбитрын харьяалал бүхий шийдвэрүүд байна. Жишээ нь, Ажил олгогчоос ажилчныг ажлаас үндэслэлгүй халсан шийдвэрийг хүчингүй болгох гэх мэт.

### **8. Иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх дуусгавар болгох**

Иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн шүүх, арбитрын шийдвэр хамаарна. Энэ нь хэн нэгэн этгээдийн эрх зөрчсөн шийдвэртэй холбоогүй байна. Жишээ нь, Тогтоосон журмаар хуулийн этгээдийг дампуурсанд тооцох.....г.м

### **9. Өөртөө туслах**

Иргэний хуулийн 12-р зүйлд “Эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан болон цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох буюу эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байвал иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, өөртөө туслах зорилгоор эд юмсыг эзэмдэн авах, устгах буюу эвдэх, эсхүл зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохоор тухайн нөхцөл байдалд тохируулан хийсэн үйлдлийг хууль бус гэж үзэхгүй гэж заасан байна.

- **Эрх бүхий байгууллага** гэдгийг зөвхөн “шүүх, арбитрыг эсвэл шүүх, прокурор, цагдаа зэрэг тухайн зөрчил аюулыг таслан зогсоож, зайлуулах буюу хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх, үүрэг бүхий ямар ч байгууллага албан тушаалтан байна. Тухайлбал: шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх газар гэх мэт.

- **Эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан гэдэг** нь дээрх байгууллагуудад хандан хууль тогтоомжид заасан хугацаанд нэхэмжлэл, гомдол гаргах, шаардлага тавих боломжгүй, эрх нь зөрчигдөх нөхцөл байдал нэгэнт бий болсон байхыг ойлгоно. Өөрөөр хэлбэл, өөртөө туслахад эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломж нь цаг хугацаа, орон зай болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан хязгаарлагдсан байдаг.

- **Цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол** гэдэг нь нэгэнт дээрх тохиолдол бий болсон бөгөөд тухайн нөхцөл байдалд тохирсон шуурхай арга хэмжээг өөрөө авахгүй бол өөрийнх нь эдийн болон эдийн бус ашиг сонирхолд нь хохирол учрах магадлал бий болсныг ойлгоно.

- **Эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох** гэдэг нь тухайн эрх, шаардлага нь дуусгавар болох, /эд хөрөнгө нь устгах эсвэл бусдын өмчлөлд бүрмөсөн шилжих, .....г.м/ **эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байх гэдэг** нь уг харилцаа дуусгавар болохгүй ч цаашид эрхээ хэрэгжүүлэх боломж нь хязгаарлагдах/ орон сууц худалдаж аваад мөнгөө шилжүүлчихээд байхад худалдагч тал ордероо өгөхгүй зугтаад байдаг ...г.м/ -ыг тус тус ойлгоно.

- **Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч** гэдэг нь эрх ашиг нь хөндөгдөж байгаа байгаа этгээд / үүрэг гүйцэтгүүлэгч/ -ийг ойлгох бөгөөд харин өөртөө туслах үйлдлийг хэрэгжүүлэхэд түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хууль ёсны бусад төлөөлөгч байж болно.

- **Эд юмсыг эзэмдэн авах** гэдэг нь үүрэг гүйцэтгүүлэгч бусдын эзэмшил ашиглалтанд байгаа эд хөрөнгийг өөрийн мэдэлд шилжүүлэн авахыг ойлгоно. Ийнхүү шилжүүлэн авах нь хуулийн дагуу байх бөгөөд эсрэг этгээдэд хохирол учруулахгүйгээр, зөрчигдөж байгаа өөрийн эрх, ашиг сонирхлын төлөө хийсэн байна. Энэхүү эд хөрөнгө нь бусдын эзэмшил, ашиглалтад байгаа өөрийнх нь эд зүйлс /алдагдсан машинаа буцаан авах/ байж болохоос гадна өөрт нь учирч буй хохиролд дүйцэх үүрэг гүйцэтгэгчийн эд зүйл/ кафегаар үйлчлүүлж хоол идэж, дарс уугаад төлбөрөө хийж чадахгүй байгаа этгээдийн гар утсыг үйлчлэгч авах/ ч байж болно.

- **Эд юмсыг устгах буюу эвдэх** үйлдэл нь өөртөө туслах зайлшгүй шаардлагатай нөхцөлд хийгдэх онцгой арга хэмжээ юм. Жич: Өртэй этгээд зугтах эсвэл өөрийнх нь машиныг хэн нэгэн этгээд булааж зугтах мэтийн тохиолдолд тухайн машины дугуйг хагалж зогсоож болно. Гэхдээ эд хөрөнгийг устгаж, эвдэх үйлдэл нь эд хөрөнгийг эзэмдэн авах, үүрэг гүйцэтгэгчийг



саатуулах аргатай давхцаж хэрэглэгдэхээс гадна эд хөрөнгө хамгаалах үед ч хэрэглэгдэж болно гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал: гал унтраах үйлчилгээ дуудах боломжгүй тохиолдолд хөрөнгө нь шатах аюул нүүрлэсэн бол шатаж буй объектийг устгаж, эвдэх, мөн дээд айлаас ус алдаад эд хөрөнгө нь ашиглах боломжгүй болох нөхцөл байдал нэгэнт бий болсон бол дээд айлын хаалгыг эвдэх г.м. Дээрхи тохиолдол бүрт уг үйлдэл хуульд заасан хэр хэмжээнээсээ хэтрээгүй байх ёстой.

- **Зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах нь** “оргон зугтааж болзошгүй гэм буруутай этгээдийг эрх нь зөрчигдөн хохирч буй этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хувиараа түр саатуулах идэвхтэй үйлдлийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, иргэний чөлөөтэй зорчих эрхийг нь түр хязгаарлана гэсэн үг. Үүргийн тухайд бол гэрээний болон гэрээний бус аль нь ч байж болно. Жишээ нь: Бусдад гэм хор учруулсан этгээд болон гэрээний үүргээ үл гүйцэтгэгч онгоцоор нисэх гэж байвал тасалбар, гадаад паспорт, визийг нь, машинаар зугтах гэж байвал түлхүүр, жолооны үнэмлэхийг нь булаан авах, мориор зугтах бол эмээл, хазаарыг нь авч мориог нь суллан тавих .....г.м

- **Үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоох гэдэг** нь бусдын өмнө хууль болон гэрээгээр үүрэг хүлээсэн этгээд үүргээ гүйцэтгэхгүй байх болон үүрэг гүйцэтгэгчийг үүргээ зохих ёсоор гүйцэтгэхэд саад болж буй бусдын үйлдлийг зогсоохыг ойлгоно. Тухайлбал: ”үүрэг гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа үйлдэл, эс үйлдлийг хүчээр зогсоох, үүрэг хүлээгчээс төлөх гэж байсан төлбөрийг хэн нэгэн этгээд булаах болон болиулах гэснийг таслан зогсоох.

Өөртөө туслах үйлдлийг хийж байгаа этгээд нь зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэж болох бөгөөд ийнхүү хүч хэрэглэсэн үйлдэл нь үүрэг гүйцэтгэгч болон гуравдагч этгээдэд хууль бусаар гэм хор учруулах зорилгыг агуулж болохгүй юм. Хүч хэрэглэх шаардлага нь ихэвчлэн үүрэг гүйцэтгэгч сайн дураараа үүргээ биелүүлэхээс зайлсхийдэгтэй холбоотой. Тиймээс тухайн нөхцөл байдалд хүч хэрэглэсэн нь зайлшгүй шаардлагата байсан гэдгийг нэн даруй хуулийн байгууллагад мэдэгдэн нотлуулах шаардлага гарна.

Өөртөө туслах үйлдлийг хийхэд дараах нөхцөлүүдийг анхаарах хэрэгтэй.

- Эрх зөрчигдсөн, эрх зөрчигдөх бодитой нөхцөл байдал бий болсон байх
- Эрх бүхий байгууллагын тусламжийг авах боломжгүй байх
- Цаг хугацаандаа арга хэмжээ авах зайлшгүй шаардлага тулгарсан байх
- Уг үйлдлийг хийж буй этгээд нь хуульд зааснаар “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч” бөгөөд “өөрийнхөө эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах” зорилготой байх
- Уг үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон хэм хэмжээнээс хэтрээгүй байх

## 10. Аргагүй хамгаалалт

Хууль бус халдлагаас өөрийгөө болон бусад этгээд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор үйлдсэн, зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцсэн үйлдлийг аргагүй хамгаалалт гэнэ.<sup>6</sup>

Аргагүй хамгаалалтаас учруулсан гэм хорыг уг үйлдэл хийсэн иргэн хариуцан арилгах үүрэг хүлээхгүй хэмээн заасан байдаг.

Аргагүй хамгаалалтанд дараах шинж байна.

- Гэм хор учруулах зүйл нь халдлага байх. Халдлага нь хүний санаа зоригоос хамаарах үйлдэл байх учраас нэг талаар халдагч этгээд нь хүн байх утгыг агуулах бөгөөд хүний зохион байгуулалттай үйл ажиллагааны хэрэгсэл нь янз бүрийн зүйл байж болно. Тухайлбал: Амьтны тухайд өөрийнхөө хийж буй үйлдлийг хууль бус гэдгийг ухамсарлах чадвартай байж болохгүй. Тиймээс халдлага биш аюул байх нь ойлгомжтой. Гэхдээ хэн нэгэн этгээд сургуультай нохой болон зуудаг нохой турхирч дайруулсан бол халдлага гэж болно. Хамгийн гол нь халдлага хууль бус байх учиртай. Жишээ нь, хүний биед хүрсэн үйлдэл болгон халдлага биш. Өөрөөр хэлбэл хүний толгой илж ч болно, толгой руу цохиж ч болно. Тиймээс үйлдлийн зорилго болон үр дагаврыг нь анхаарах хэрэгтэй.

- Халдлага эхлэсэн байх. Хохирол зайлшгүй учрах нь халдлага бодитой бий болсноор нотлогдсон байх ёстой. Халдлага эхлээгүй байхад хамгаалалт хийнэ гэсэн ойлголт байхгүй. Тиймээс уг үйлдэл нь халдлага мөн эсэхийг анхаарч хариу үйлдлээ хийсэн байх учиртай.

- Аргагүй хамгаалалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд гагцхүү халдагчид чиглэсэн байх. Дээрх хоёр шинж нэгэнт илэрсэн бол өөрийгөө болон бусад этгээд, эд хөрөнгийг хамгаалах нь тухайн үеийн нөхцөл байдалтай нягт уялдан зайлшгүй шаардлага болон илэрсэн байдаг учраас хариу үйлдэл хийх нь шударга ёсонд нийцнэ. Ийнхүү хамгаалах үйлдлийг хийсэн нь хуулийн дагуу зөвтгөгдөх учраас түүний хүсэж үйлдсэн үйлдэл нь гагцхүү халдагчийн үйлдлийн хариу болж түүнд чиглэсэн бөгөөд үйлдлийн үр дагавар болон учирсан гэм хор нь зөвхөн халдагчид учрах ёстой. Өөрөөр хэлбэл, хамгаалахыг хүссэн үйлдэл нь халдагч руу хандсан байна.

- Үйл ажиллагаа нь халдагын шинж чанарт тохирсон байх. Үйлдэл хийсний улмаас халдагчид учруулсан гэм хор нь тухайн нөхцөл байдалдаа тохирсон байх учиртай. Өөрөөр хэлбэл, уг этгээдийн үйлдэл нь тухайн нөхцөлд сөрөг халдлагын шинжийг агуулж болохгүй. Жишээ нь, Өөрийн машины будгийг халцалж юмуу эсвэл дугуйг нь хагалах үйлдэл хийж байгаа хүүхдийг түлхэн холдуулж болох боловч энэ нь тухайн хүүхдийг зодож гэмтээх үндэслэл болохгүй юм.

<sup>6</sup> Монгол Улсын Иргэний хуулийн 10 дугаар зүйлийн 1дэх хэсэг



## 11. Гарцаагүй байдал

Иргэний хуулийн 11.1-2-д “Тухайн нөхцөл байдалд аюулыг өөр арга замаар зайлуулах боломжгүй бол түүнийг таслан зогсоох, сэргийлэх зорилгоор хийсэн үйлдэл /эс үйлдэхүй/-ийг гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл гэнэ. Гарцаагүй байдалд учруулсан гэм хор нь учирч болох байсан гэм хороос бага байвал уг үйлдэл хийсэн этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээхгүй. Харин учруулсан гэм хор нь учирч болох байсан гэм хороос илт их байвал үйлдэл хийсэн этгээд хэтрүүлсэн тэр хэмжээгээр гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ. Аюул нь гол төлөв хүний санаа зоригоос үл хамаарах шинжтэй нөхцөл байдал байдгаараа онцлог юм. Тухайлбал: амьтны үйлдлийн улмаас гэм хор учрах нөхцөл байдал бий болсон .....г.м. Жишээ нь, Тугалаа харамласан үнээ мөргөх аюул тулгарах, зуудаг нохой дайрч гэм хор учруулж болзошгүй аюул учрах ...гэх мэт

Хэрвээ хүний үйлдэлтэй холбоотой байлаа гэхэд тухайн этгээдийн хувьд гэм хор учруулах гэсэн санаа зориг байхгүй байна. Жишээ нь, уулын уруу эзэнгүй машин өнхрөх .....

Гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл нь дараах шинжтэй.

- Гэм хор учруулж болзошгүй хүчин зүйл нь аюул байх
- Аюул гарцаагүй бөгөөд аюулыг өөр аргаар зайлуулах боломжгүй байх
- Аюулыг таслан зогсоох, сэргийлэх зорилгоор хийсэн байх
- Учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага байх .

### Хоёр. Хяналтын асуулт :

- Иргэний эрх зүйн зохицуулах зүйл болох нийгмийн харилцааны онцлогийг нийтийн эрх зүйн зохицуулах зүйлтэй харьцуулан тайлбарлана уу.
- Иргэний эрх зүйн зохицуулалтын аргыг бодит жишээн дээр тайлбарла.
- Иргэний эрх зүйн нийтлэг болон тусгай зарчмууд, тэдгээрийн практик хэрэглээ хууль зүйн ач холбогдол, онцлогийг тодорхойл.
- Иргэний эрх зүй хичээлийг судлах нь таны амьдралд ямар ач холбогдолтой вэ?
- Хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээ нь ямар нөхцөлд иргэний эрх зүйн эх сурвалж болох вэ?
- Иргэний эрх зүйн эх сурвалжийг ангилсаны хууль зүйн ач холбогдлыг тайлбарла.
- Тодорхой тохиолдол дээр иргэний хууль үйлчлэх хязгаарыг тодорхойл.
- Иргэний эрх зүйн хамгаалалтын зорилго юу вэ?
- Иргэний эрх зүйн хамгаалалтын арга тус бүр дээр жишээ авч тайлбарла.

## Гурав. Хэрэглэгдэхүүн:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Иргэний хууль 2002 он
3. Д.Наранчимэг. “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” I дэвтэр 1999 он 1-3-р тал
4. Т.Мөнхжаргал. “Монгол улсын иргэний эрх зүй” /ерөнхий анги/ 2000 он 9-39-р тал
5. Д.Бат-Өлзий. “Иргэний эрх зүй 1” УБ, 2003 он 22-26-р тал
6. О.Жамбалдорж. “Монгол улсын иргэний эрх зүй” /ерөнхий үндэслэл/ 2004 он 17-51-р тал
7. Б.Улаанбаатар. “Иргэний эрх зүй: тайлбар толь” 2005 он
8. Э. Байгаль. Иргэний эрх зүйн ерөнхий анги. 2009 он
9. “Монгол улсын иргэний хуулийн тайлбар. УБ 2007 он
10. Хасагт хайрхан дээд сургууль, Хууль зүйн мэдээллийн төв, Иргэний хуулиуд (1926, 1952, 1963, 1994, 2002) II Боть, УБ, 2002
11. Б.Баттөмөр. “Монгол Улсын иргэний эрх зүйн зарим асуудал” УБ., 2004 он
12. Т.Мөнхжаргал. “Монгол улсын иргэний цаазын товчоон ” УБ, 2006 он
13. Б.Буянхишиг. “Иргэний эрх зүй” –бодлогын хураамж УБ, 2009 он
14. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он
15. Б. Тэмүүлэн, Д. Энхзул, Б. Буянхишиг. Иргэний эрх зүйн ерөнхий анги, УБ., 2010.
16. Толстой. Гражданское право, Москва, 1996-1998 г
17. Суханов. Гражданское право, Москва, 1998 г
18. Ильярнова. Гражданское право, Москва, 1998 г
19. Под ред Алексеева.А.А, Толстого Ю.К. “Гражданское право” Том.М.1996 г
20. Под ред Красавчикова.О.А “Гражданское право “. М.1988 г
21. Под ред Суханова.Е.А. “Гражданское право”. М., 2002 г



## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА, СУБЬЕКТИВ ЭРХ

### 2.1: Иргэний эрх зүйн харилцаа: ухагдахуун, ангилал

**Сэдвийн зорилго:** Иргэний эрх зүйн харилцааны талаар системтэй мэдлэг, иргэний эрх зүйн харилцааны үндсэн шинж, элементийг тодорхойлох чадвар эзэмшинэ.


#### Нэг. Тойм лекц

##### Иргэний эрх зүйн харилцааны тухай ойлголт

Иргэний эрх зүйн харилцаа нь хүний эрх, эрх чөлөөний үндэс болох хувь хүний чөлөөт байдлын зарчмаар баталгаажсан ба энэ нь хувийн эрх зүйн дараах үндсэн зарчмуудад тусгалаа олсон байдаг. Үүнд:

- гэрээний эрх чөлөө
- чөлөөтэй өвлүүлэх эрх
- өмчлөгчийн өмчөө чөлөөтэй захиран зарцуулах эрх
- хувь этгээдийн эвлэлдэн нэгдэх, хуулийн этгээд байгуулах эрх багтана.

Энэ нь ИХ-ийн §8.1-д зааснаар хувь этгээд хоорондын хэлцлийн үндсэн дээр эсвэл энэ хуульд тусгагдсан гэм хор учруулах, үндэслэлгүй хөрөнгөжих, бусдын үүргийг даалгаваргүй гүйцэтгэх зэрэг тохиолдолд үүсч байдаг эрх зүйн харилцааны түгээмэл хэлбэр билээ. Эдгээр иргэний эрх зүйн харилцаа үүсэх шалтгаан нөхцөл нь холбогдох этгээдийн эдийн болон эдийн бус хөрөнгөтэй холбоотой **субъектив эрхийг** хууль, шүүхээр хамгаалах зорилготой нягт холбоотой.



### Иргэний эрх зүйн харилцааны үндсэн шинж, шалгуур

Аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ шүүхийн харьяаллыг заавал тогтоох ба ингэхдээ хувийн эрх зүйг нийтийн эрх зүйгээс ялгах шаардлага гардаг. Ийнхүү ялгах шинж тэмдэгүүд нь хувийн эрх зүйн ялангуяа иргэний эрх зүйн харилцааны үндсэн шинжийг илтгэнэ. Онолын үүднээс энд 1/. субъектын онол, 2/. ашиг сонирхлын онол, 3/. субординацийн онол болон түүний шинэчлэгдсэн хувилбар болох 4/. тусгай эрхийн онолыг тус тус дурьдаж болно<sup>7</sup>.

Тухайлбал, оролцогсод **тэгш эрхийн** эсвэл **захирах, захирагдах харилцааны** алинд хамаарах эрх зүйн харилцаанд оролцож буйг судлан эрх зүйн харилцааг ангилах нь элбэг. Холбогдох этгээд худалдах-худалдан авах гэрээ байгуулах эсвэл байр түрээслэх зэрэг тохиолдолд эсрэг талтайгаа тэгш эрхийн харилцаа үүсгэж байдаг бөгөөд ийм сайн дурын гэрээ хэлцлийн үндсэн дээр тодорхой эрх, үүрэг үүсгэж байгааг эрх зүйн үүднээс тэгш эрхийн харилцаа гэдэг. Харин төр иргэдтэй харилцахдаа ихэвчлэн шаардлага тавьж, тэдний зөвшөөрлийг үл харгалгалзах нь бий. Тухайлбал, татварын асуудал болон цэрэг татлагад хамрагдах зэрэг. Ийнхүү төрийн эрх мэдэлд захирагдаж, тодорхой хууль тогтоомжийн дагуу үйл хөдлөл хийх үүрэг хүлээж буй бол энд нийтийн эрх зүйн харилцаа үүснэ /*субординацийн онол*/. Хууль тогтоомжоос гадна тодорхой тохиолдлыг зохицуулах шаардлага гарвал төр *захиргааны акт* гаргаж ажиллана. Нийтийн эрх зүйн салбар нь эрүүгийн эрх зүйн болон процессын бүхий л хууль тогтоомжийг хамарч байдаг.

Эрх зүйн харилцааны субъект хэн байх нь тус харилцааг тодорхойлоход төдийлөн ач холбогдолгүй. Учир нь төр өнөөгийн нийгэмд иргэний эрх зүйн харилцаанд оролцох нь хуулиар зөвшөөрсөн, хэвийн үзэгдэл болоод байна.

Эрх зүйн харилцаанд оролцогсод өөр хоорондоо захирах, захирагдах харилцаанд оршиж буй эсэхийг судлахаас гадна тус харилцаанд хамаарах хууль тогтоомж нь нийтийн эрх зүйн салбарт хамаарч байна уу, эсвэл хүн бүрт үйлчлэх хувийн эрх зүйн хууль тогтоомжид суурилсан байна уу гэдгээр нь эрх зүйн харилцааг ялгаж болно. Үүнийг **тусгай эрхийн онол** гэх бөгөөд голлох ач холбогдол бүхий хууль тогтоомжийн салбар эрх зүйн ангиллаар хэргийн харьяаллыг тогтоох ба энэ онолын дагуу Иргэний Хуулиар зохицуулсан харилцааг хувийн эрх зүйд хамруулан үзнэ.

**Хувийн эрх зүй** нь эрх зүйн харилцаанд оролцогсод хооронд үүссэн тэгш эрх бүхий эрх зүйн харилцааг хамрах ба үүнд иргэний эрх зүйн болон бизнесийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүйн бүхий л харилцаа багтана. Иргэний эрх зүй хэмээх ухагдахуун өргөн утгаараа хувийн эрх зүй гэсэн агуулгаар хэрэглэгдэх нь элбэг ч угтаа үүнийг хувийн эрх зүйн цөм хэмээн ойлгож, эрх зүйн энэ бүлийн салбар, хэсгүүдийг өөр хооронд нь ялгахад хэрэглэнэ.

Өөрөөр хэлбэл, **иргэний эрх зүй** нь явцуу утгаараа хувийн эрх зүйн бүх харилцаанд холбогдох суурь зарчмыг агуулж байдгаараа хувийн эрх зүйн үндсэн

<sup>7</sup> Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, 2012 он, 19-20 дахь тал.



салбар болох ба Иргэний Хуулийн зохицуулах зүйлтэй дүйцэж байдаг. Үүнээс хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг зохицуулахад чиглэсэн хувийн эрх зүйн томоохон салбар болох *бизнесийн эрх зүй*, түүнчлэн патентын болон зохиогчийн эрх, өрсөлдөөний хууль тогтоомж, даатгалын зарим салбарыг ялгаж үзэх ба эдгээр нь хувийн эрх зүйн тусгай салбарт багтдаг.

Иргэний эрх зүйн харилцаа үүссэний дүнд талуудад харилцан *шаардах эрх* үүснэ. Үүнд аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг бусдаас шаардах, түүнийгээ шүүхээр хэрэгжүүлэх боломжийг ойлгох ба ийм шаардах эрхийг агуулсан иргэний эрх зүйн хэм хэмжээг **шаардах эрхийн үндэслэл** гэнэ.

Хувийн эрх зүй болон иргэний эрх зүй хэмээх нэр томъёог эрх зүйн онолын үүднээс ийнхүү ялгаж үздэг ч процессын хууль тогтоомжийн хүрээнд нэн ялангуяа ИХШХШТХ-ийн §12-ын хүрээнд нэршсэн “иргэний хэрэг” хэмээх ухагдахуун нь хувийн эрх зүйн салбарын бүх маргааныг үүний дотор иргэний эрх зүйн харилцаанд үүссэн бүх асуудлыг хамарч байгааг анхааруулах нь зүйтэй.

### **Иргэний эрх зүйн харилцааны ангилал, эрх зүйн ач холбогдол**

Иргэний эрх зүйн харилцааг дотор нь өмчийн ба үүргийн эрх зүйн харилцаа хэмээх хоёр том бүлэгт ангилах бол үүргийн эрх зүй нь гэрээний ба гэрээний бус үүрэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Ийнхүү ангилах нь холбогдох шаардах эрхийн үндэслэлийг зөв тодорхойлох, улмаар иргэний хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

### **Иргэний эрх зүйн харилцааны элемент**

Иргэний эрх зүйн харилцаа үүсэхэд зайлшгүй шаардлагатайгаас гадна тодорхой ач холбогдол, нөлөө бүхий бүх хүчин зүйлсийг иргэний эрх зүйн харилцааны элемент гэж ойлгож болно. Үүнд:

- иргэний эрх зүйн харилцаанд оролцогч субъектууд
- эрх үүргийн нэгдлээс урган гарч буй субъектив эрхүүд
- иргэний эрх зүйн харилцааны агуулгыг тодорхойлогч объектууд багтана

### **Хоёр. Хяналтын асуулт:**

- Иргэний эрх зүйн харилцаа, түүний онцлог шинжийг тайлбарлана уу.
- Иргэний эрх зүйн харилцааны элементийг бусад салбар эрх зүйн элементтэй харьцуулан тайлбарлана уу.
- Иргэний эрх зүйн харилцааны агуулгыг тодорхойлогч хүчин зүйлийг тайлбарлана уу.
- Иргэний эрх зүйн харилцааг ангилах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлно уу.
- Иргэний эрх зүйн субъектийн уг харилцаанд оролцох онцлог шинжийг гаргана уу.

- Иргэний эрх зүйн харилцаа нь бусад салбар эрх зүйн харилцаанаас ямар ялгаатай вэ?
- Өгөгдсөн тохиолдол дээр иргэний эрх зүйн харилцааг ангилах, түүний элементүүдийг тодорхойлж, ангилалтыг хийнэ үү.
- Иргэний эрх зүйн харилцааг ангилс ны хууль зүйн учир холбогдол нь юунд орших вэ?
- Өгөгдсөн тодорхой жишээг агуулгаар нь ямар харилцаа болохыг тодорхойлно уу.

## Гурав. Сорилго

1. Иргэний Хууль хэдэн онд батлагдсан бэ?
    - a. 1999 онд
    - b. 1992 онд
    - c. 2002 онд
    - d. 1926 онд
  2. Хувийн эрх зүйн Үндсэн Хуулийн баталгааг нэрлэнэ үү.
    - a. гэрээний эрх чөлөө
    - b. чөлөөтэй өвлүүлэх эрх
    - c. өмчлөгчийн өмчөө чөлөөтэй захиран зарцуулах эрх
    - d. хувь этгээдийн эвлэлдэн нэгдэх эрх
  - e. дээрх бүгд зөв.
  - f. a, b хариулт зөв
3. Хувийн эрх зүй гэдэгт юуг ойлгох вэ?
    - a. Иргэний Хууль ба ИХШХШТХ-д тусгагдсан харилцаа
    - b. Иргэний Хууль ба хувийн эрх зүйн тусгай хууль тогтоомжид тусгасан харилцаа
  4. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийг нэрлэнэ үү.
    - a. Шүүхийн шийдвэр
    - b. Бусдын эрх үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулах
    - c. Хэлцэл хийх, бусдад гэм хор учруулах, үндэслэлгүй хөрөнгөжих
    - d. Дээрх бүгд зөв
    - e. a, c хариулт зөв.
  5. Иргэний эрх зүйн харилцааг ердийн эрх зүйн харилцаанаас хэрхэн ялгах вэ?
    - a. Эрх зүйн үр дагавраар нь.
    - b. Уг харилцаанд хэрэглэгдэх хууль тогтоомжоор.
    - c. Эрх зүйн харилцаа нь дээрхээс гадна нийтийн эрх зүйн харилцааг хамардгаараа ялгаатай.
  6. Иргэний эрх зүйн харилцааг бусад эрх зүйн харилцаанаас ялгах гол шинж юу вэ?



- a. Иргэний эрх зүйн харилцаа нь хувь этгээд хоорондын тэгш эрхийн харилцаа юм.
- b. Иргэд, байгууллага хоорондын захирах, захирагдах харилцааг хэлнэ.
- c. Оролцогсод нь гагцхүү хувь этгээд байна.

### **Дөрөв. Хэрэглэгдэхүүн**

#### **Сурах бичиг:**

1. Т.Мөнхжаргал: МУ-ын Иргэний эрх зүй, УБ хот 2007 он.
2. Наранчимэг Д. “Иргэний эрх зүйн үндсэн асуудал”УБ, 1999 он
3. Б.Баттөмөр: МУ-ын Иргэний эрх зүйн зарим асуудал, УБ хот 2005 он.
4. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
5. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013он
6. Э.Байгал: Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он

#### **Хууль тогтоомж, шүүхийн практик:**

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он

## Сэдэв 2.2: Иргэний эрх зүйн харилцааны объект, субъект болон субъектив эрхийн тухай ойлголт

### Нэг. Тойм лекц

**Сэдвийн зорилго:** Иргэн – иргэний эрх зүйн харилцааны субъект байх чадвар, чадамж, иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, оршин суух газар, түүний эрх зүйн учир холбогдол, иргэнийг сураггүй алга болсон, нас барсан гэж зарлах талаар хууль зүйн онолын мэдлэг олж авах. Мөн хуулийн этгээд, түүний үндсэн шинж, хуулийн этгээдийн төрлийг ялгах, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эрх зүйн зохицуулалт болон эдгээр харилцааны иргэний хуулийн суурь зохицуулалтыг ойлгож судалснаар хуулийн этгээдтэй холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэглэх чадвар, дадалтай болно.

## А. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ СУБЪЕКТ

Иргэний Хуулийн I хэсгийн II дэд хэсэгт хууль тогтоогч иргэний эрх зүйн харилцаанд оролцогсдыг юуны өмнө иргэн болон хуулийн этгээд байхаар тусгажээ. Үүнээс үүдээд иргэн, хуулийн этгээдийг хувийн эрх зүйн гол оролцогсад гэдэг утгаар нь **хувь этгээд** хэмээн нэрлэх явдал эрх зүйн тогтолцоонд нийтлэг болоод байна. Түүнчлэн эрх зүйн харилцааны субъектыг бүрэлдэхүүнээр нь нэгж субъект ба бие хүн, хамтын субъект ба байгууллага, аж ахуйн нэгж гэж ангилах нь ч бий.

### Иргэн хүн эрх зүйн харилцааны субъект болох нь

Эрх зүйн субъект гэдэг нь эрх зүйн харилцаанд оролцож, эрх эдэлж үүрэг хүлээх боломжтой этгээд<sup>8</sup> бөгөөд үүнд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамруулан ойлгоно.

Аливаа субъектын эрх зүйн харилцааны оролцогч байх боломж нь субъектын эрх буюу субъект байх чадвараар тодорхойлогдоно. Хүн бүр төрсөн цагаас эхлэн субъект байх чадвартай, өөрөөр хэлбэл төрийн зүгээс субъектын эрхийг баталгаажуулсан бөгөөд хууль цаазаар тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээх ерөнхий нийтлэг боломжийг **эрх зүйн чадвар** гэнэ<sup>9</sup>. Харин эрх зүйн чадамж хэмээх ухагдахуун нь өөрт оногдсон эрхээ эдэлж, үүрэг хүлээх замаар эрх зүйн харилцаанд бие даан оролцох боломжийг хэлнэ.

ИХ-ийн §14-т иргэний эрх зүйн чадвар иргэнийг төрсөн үеэс эхэлж, нас барснаар дуусгавар болдог, мөн үүнийг хязгаарлахыг хориглох тухай заажээ. Энэ нь дээр дурьдсан эрх зүйн чадвартай ижил утгатай тул **иргэний эрх зүйн чадвар** гэдэгт хувийн эрх зүйн салбарт эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг

<sup>8</sup> Dieter Leipold: BGB I – Einführung und Allgemeiner Teil, 5. Auflage, 2008, Seite 421; Ч.Нямсүрэн: Эрх зүйн ерөнхий онол, 2010 он, 310 дахь тал.

<sup>9</sup> Ч.Нямсүрэн: Эрх зүйн ерөнхий онол, 2010 он, 311-312 дахь тал.



ойлгоно. Ийм чадвар бүхий этгээд нь иргэний эрх зүйн субъект байх бололцоотой. Иргэн бүр төрсөн үеэсээ эхлээд иргэний эрх зүйн чадвартэй байх ба үүнийг ямар ч нөхцөлд хязгаарлах боломжгүй нь хүний ямагт эрх зүйн субъект байдаг шинжтэй холбоотой. Түүнчлэн иргэнээс гадна хуулийн этгээд иргэний эрх зүйн чадвартай байх тухай ИХ-ийн §§25-26-д тусгасан байна.

Иргэний эрх зүйн чадварыг үйл хөдлөл хийх бодит нөөц бололцоо, чадвараас ялгаж үзэх нь чухал. Бие даан эрх олж авах, үүрэг хүлээх бодит боломжийг иргэний эрх зүйн гэрээ хэлцэл хийх орчинд иргэний эрх зүйн чадамж хэмээх ухагдахуунаар тэмдэглэдэг, ИХ-ийн §15.1. Харин хуулиас үүдэх үүргийн хүрээнд гэм хорын хариуцлага хүлээх чадамж гэж нэрлэж болно, ИХ-ийн §504.1. ИХ-ийн §15.1-ийн дагуу иргэний эрх зүйн чадамж 18 наснаас эхлэх ба энэ шаардлага хангагдсан эсэх нь эрх зүйн субъект байх явдалд нөлөөлөхгүй.

ИХШХША-ны субъект байх чадварыг хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадвар гэх бол (ИХШХШТХ-ийн §23), шүүхэд эрхээ хэрэгжүүлэх нөөц бололцоог хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадамж хэмээн ИХШХШТХ-ийн §24-т тусгажээ. Эдгээр нь ИХ-ийн §§14, 15-тай тус тус дүйж байдаг.

### **Эрх зүйн субъектын төрөл**

Иргэн бүр эрх зүйн субъект байхаас гадна хуулийн этгээд эрх зүйн субъект байх боломжтой. Хүн нь байгалиас заяасан эрх зүйн субъект байдаг бол **хуулийн этгээд** нь тухайн эрх зүйн тогтолцоонд эрх зүйн чадварыг нь хүлээн зөвшөөрсөн аливаа хувь хүмүүсийн эсвэл тусгай зохион байгуулалтын тусламжтайгаар эрх зүйн харилцаанд оролцох боломж бүхий хөрөнгө, хүн хүчний нэгдэл юм. Хуулийн этгээд хэмээн нэрийдсэний учир нь хуулийн тодорхой зүйл заалтын тусламжтай эрх зүйн субъект хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байдагтай холбоотой.

Дэлхий ертөнц дээр оршин байдаг бусад зүйлс нь гагцхүү эрх зүйн объект л байх боломжтой. Тухайлбал, эд хөрөнгө, эрх, амьд амьтад нь эрх зүйн объект болох ба иргэний эрх зүйн гол объектуудыг ИХ-ийн §§83-88-д зохицуулсан.

### **Эрх зүйн чадвар бүрдэх мөч**

Өнөө үед иргэнийг төрсөн гэж үзэх мөчөөс эхлэн түүнийг эрх зүйн субъект болохыг хүлээн зөвшөөрдөг. Хүүхдийг төрсөн гэж үзэхийн тулд бие нь эхийн умайгаас бүрмөсөн гарсан бөгөөд энэ мөчид хүүхэд амьд байх ёстой. Хүйг салгасан эсэх нь төдийлөн чухал биш. Амьд байсан гэдгийг хүүхдийн зүрхний цохилт, хүйн лугшилт болон өөрөө бие даан уушгиараа амьсгалах зэргийг ойлгох ба үүнээс гадна тархинаас бусад эрхтэн рүү дохио илгээгдэж буй нөхцөл нь амьдарч буйн гэрч болдог. Хэдийгээр шинэ төрсөн хүүхэд хэдэн минут, секундын дараа нас нөхцсөн ч түүнийг энэ хооронд иргэний эрх зүйн субъект байсан гэж үзнэ. Хүний үр хөврөл (**nasciturus**) хэдийгээр хараахан эрх зүйн чадваргүй байх ч бий болсон мөчөөс нь эхлэн түүнийг хамгаалах тухай нилээд хэд хэдэн зохицуулалт хуулинд тусгагдсан байдаг. Тухайлбал ИХ-ийн §520.1.1-д

өв залгамжлуулагчийн нас барснаас хойш төрсөн хүүхэд өвлөх эрхтэй байхаар заасан. Энэ нь ургийг өвөөс хасагдахаас хамгаалж буй нэг хэлбэр юм.

## **Иргэний эрх зүйн чадвар дуусгавар болох тухай**

**а. Иргэн нас барах:** ИХ-ийн §14.1-д заасанчлан иргэн нас барснаар түүний иргэний эрх зүйн чадвар үгүй болно. Харин орчин үед техникийн тусламжтай хүнийг амьд байлгах боломж бололцоо бий болсноор нас барсан цаг мөчийг тогтооход бэрхшээл гардаг. Хүний нас барах мөч нь ялангуяа, өвийн эрх зүйд шийдвэрлэх үүрэгтэй. Үүнийг тогтоох сонгодог арга нь зүрх зогсох, амьсгалын үйл ажиллагаа алдах явдал байжээ. Эдгээрийг эмнэлгийн аргаар үргэлжлүүлэх боломжтой өнөөгийн нөхцөлд тархины үйл ажиллагаа зогсох мөчид иргэнийг нас барсан хэмээн тооцох болжээ.

**б. Иргэнийг нас барсан хэмээн зарлах:** Иргэн оршин суугаа газраасаа сураггүй алга болсон нөхцөлд 5 жилийн дараа, мөн амь үрэгдэж болзошгүй нөхцөл байдалд орсон бол 1 жилийн дараа түүнийг шүүхээр нас барсанд зарлуулах боломжтой, ИХ-ийн §24.1. иргэнийг нас барсанд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол энэ өдрийг түүний нас барсан өдөр хэмээн тооцох боловч (ИХ-ийн §24.3) амь үрэгдэж болох нөхцөл байдалд алга болсон этгээдийн нас барсан өдрийг шүүх тогтооно, ИХ-ийн §24.4. Энэ мөчөөс эхлэн тухайн иргэнийг иргэний эрх зүйн чадваргүйд тооцно. Гэхдээ процессын явцад нас бараагүй гэсэн нотлох баримт олдвол түүнийг иргэний эрх зүйн чадвартай хэвээр гэж үзнэ.

## **Хуулийн этгээд**

**Хуулийн этгээд** гэдэгт хүмүүс болон хөрөнгийн нэгдлийг тодорхой зохион байгуулалтад оруулж, хамтын зорилгод үйлчлүүлснээр тухайн эрх зүйн тогтолцооноос эрх зүйн субъект болохыг нь хүлээн зөвшөөрсөн нэгдлийг ойлгоно. Үндсэн шалгуур нь хамтын зорилго дор зохион байгуулалттай нэгдэх явдал юм.

## **Хувийн эрх зүйн хуулийн этгээд**

Хувийн зорилгыг хэрэгжүүлэхээр нэгдсэн, хувийн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан зохион байгуулагдсан хуулийн этгээдийг хувийн эрх зүйн салбарын хуулийн этгээд гэнэ. Иргэний эрх зүйн хуулийн этгээдийн үндсэн төрөл нь ашгийн **төлөө** хуулийн этгээд болох нөхөрлөл, компани юм, ИХ-ийн §33.1. Хуулийн этгээдийн нийтэд хүлээн зөвшөөрөгдөх ердийн шалгуур нь улсын бүртгэлд бүртгүүлсэн байх явдал бөгөөд ингэснээр түүнийг эрх зүйн субъект болсонд тооцно, ИХ-ийн §26.1. Тиймээс аливаа хоршоо, нөхөрлөл, хувьцаат компани зэргийг улсын бүртгэлд бүртгүүлснээр иргэний эрх зүйн чадвартай болдог.



Харин ИХ-ийн §33.2-т тусгасан **ашгийн төлөө бус** хуулийн этгээдийн эрх зүйн ангиллыг тодорхойлоход ихээхэн бэрхшээл гардаг. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үндсэн хэлбэр нь хамтран ажиллах гэрээт талууд (ИХ-ийн §476) байх ёстой боловч энэ тухай тодорхой зохицуулалт байхгүй, хамтран ажиллаж буй хүмүүсийн нэгдлийн эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрөөгүй байгаа билээ. Холбоо, сан, хоршооны хувьд хүмүүсийн нэгдэл эсвэл бусад идеаль зорилго чухал байдаг гэсэн үзэл баримтлалын үүднээс ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж үздэг ч эдгээр нь бодит байдал дээр тодорхой ашиг олох үйл ажиллагаа явуулдаг.

Түүнчлэн хуулийн этгээдийн шалгуурт хүрдэггүй, хүмүүсийн нэгдлийг ИХ-нд тусгасан байдаг. Үүнд нийт 3 төрлийн хувь этгээдийн нэгдэл тухайлбал, хамтран ажиллах гэрээний талууд (ИХ-ийн §476), гэр бүлийн гишүүдийн нэгдэл (ИХ-ийн §128) болон хамтран өв залгамжлагчид (ИХ-ийн §530) багтана. Энэхүү хувь этгээдийн нэгдлийн гол онцлог шинж нь аливаа хөрөнгийг хэд хэдэн этгээд хамтдаа захиран зарцуулах эрхтэй байдагт оршино; эдгээр тусгай хөрөнгө нь гэр бүлийн дундын өмч, өвлөгдөх гэж буй эд хөрөнгө болон хуулийн этгээдийн хөрөнгийг хамрах ба дээрх нэгдэлд оролцож буй хувь этгээдийн хөрөнгөөс тусгаарлаж авч үздэгээрээ хуулийн этгээдтэй төстэй. Дээрхээс гадна тодорхой эд зүйлийг хэсгээр өмчлөх хамралууд ч гэсэн хуулийн этгээд болохгүй.

### **Нийтийн эрх зүйн хуулийн этгээд**

Нийтийн зорилгыг хэрэгжүүлэхээр нийтийн эрх зүйн хууль тогтоомжид тулгуурлан зохион байгуулагдсан хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэнэ. Үүнд төр, түүний нутаг дэвсгэрийн нэгжүүд багтахын сацуу төрийн өмчит байгууллагууд (улсын сургуулиуд, сүм хийд зэрэг), төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч бусад байгууллагууд (Улсын Радио, Телевизийн Газар) болон нийтийн эрх зүйн сангууд хамрагдана. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдүүд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулагдах ч, хувийн эрх зүйн харилцаанд оролцогч субъект болдог, ИХ-ийн §26.3.

## **Б. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ Объект**

Эрх зүйн объект нь аливаа субъект эрх зүйн үүднээс нөлөөллөө тогтоон захирах, эрх мэдлээ хэрэгжүүлж болох бүхий л үнэт зүйлсийг хамарсан ойлголт юм. Иргэний Хуулийн §83-т “хөрөнгө” хэмээх ерөнхий ойлголтод **эдийн баялаг** болох эд юмс, **эдийн бус баялаг** болох оюуны үнэт зүйлс, мөн эрх багтана. Хөрөнгө гэдэгт юуны өмнө зах зээлийн харилцаанд ямар нэг хариу төлбөрийн үндсэн дээр олж авч болох бүхий л баялгийг ойлгох<sup>10</sup> бөгөөд өөрөөр хэлбэл, эдийн болон эдийн бус баялгийн аль нь ч гэсэн зах зээлийн харилцаанд

<sup>10</sup> Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, УБ хот 2006 он, §83-ын тайлбар, 292. дахь тал.

үнэлэгдэх боломжтой байх ёстой. Энэхүү үнэлэгдэх шинжээ алдвал иргэний эрх зүйн объектийн шинжээ алдана<sup>11</sup>. Харин эдийн бус баялаг нь эдийн баялаг болох эд юмс шиг физикийн утгаараа материас бүрдэхгүй<sup>12</sup>, биет байдалтай бус, хүний бүтээлч үйл ажиллагааны ашигтай, хамгаалагдсан үр дүн бөгөөд үүгээрээ иргэний эрх зүйн харилцаанд өвөрмөц харилцааг бий болгодогдоороо онцлогтой.

**Эд юмс** гэдэгт бүхий л биет зүйлсийг ойлгож болох бөгөөд эдгээр нь материаллаг, биет байдлаараа эдийн бус баялаг болон эрхээс ялгагдаж байдаг. Аливаа этгээд гагцхүү биет эд юмсыг бодит нөлөөлөлдөө оруулах боломжтой тул эдийн баялгийн хувьд л **эзэмших** тухай ойлголт байж болно. Эд юмсын энэхүү шинж нь дараах нөхцөлд ач холбогдолтой байдаг. Тухайлбал, эд юмсын хувьд биетээр нь булаан авах, гэмтээх гэсэн ойлголт байж болох бөгөөд үүний эсрэг хуулинд (ИХ-ийн §90.2) томоохон хамгаалах арга хэрэгсэл тусгагджээ.

**Эдийн бус баялаг** гэдэг иргэний харилцаанаас үүдэх шаардах эрхээс гадна аливаа зохиогч, зохион бүтээгчийн оюуны бүтээлд хууль тогтоогчоос дангаар ашиглах, борлуулах эрх олгосон явдал багтана. Ийм эдийн бус баялгийн эрх нь утга зохиол, шинжлэх ухаан, урлагийн бүтээл, ашигтай загвар, патент болон барааны тэмдэгт зэрэгт олгогддог.

Аливаа **эд хөрөнгийн эрх** нь бусад эрхтэй харьцуулахад эрх зүйн захиран зарцуулах харилцааны зүйл болдог. Үүнд өмчлөх эрх, бусад өмчийн эрх зүйн хязгаарлагдмал эрхүүд болон эрх эзэмших эрх, эдийн бус баялгийн эрх, шаардах эрхүүд, хуулийн этгээдийн гишүүнчлэлийн эрх зэрэг багтана.

Харин **амины эрхүүд**<sup>13</sup> нь хувь хүнтэй салшгүй холбоотой байх бөгөөд энэ шинжийн улмаас бие даан эрх зүйн объект болдоггүй. Түүнчлэн хийсэн хэлцлээ хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах, гэрээгээ цуцлах зэрэг **харьцангуй эрх** нь эрх зүйн объектын хүрээнд харьяалагдахгүй. Учир нь гагцхүү эдгээрийг үүсгэхэд хүргэж буй эрхүүд л эрх зүйн захиран зарцуулах харилцааны объект байж болно.

Аль ч эрх зүйн тогтолцоонд иргэний хууль нь ерөнхийдөө эдийн баялагт холбогдох харилцааг зохицуулсан байх ба эдийн бус баялагт оюуны өмчийн талаарх салбар эрх зүйн хууль тогтоомжоос гадна иргэний хуулийг бүхэлд нь эсвэл тодорхой хэсэг, зүйл заалтыг хэрэглэж болохоор тодорхойлогдсон байна, ИХ-ийн §98. ИХ-ийн §122-т заасны дагуу эдийн бус баялгийн эрхийг шилжүүлэхдээ эдийн баялагт холбогдох зохицуулалтыг төсөөтэй хэрэглэнэ.

## Эдийн бус ба эдийн баялгийн адил төстэй шинж:

Юуны өмнө эдийн ба эдийн бус баялаг нь өмчийн эрх зүйн объект болохын хувьд түүний өмчлөгч нь туйлын эрхийг олж авдаг<sup>14</sup>. Өмчийн эрх зүй нь үүргийн эрх зүйтэй харьцуулбал зөвхөн тухайн иргэний эрх зүйн субъектүүдийн хоорондох харилцааг зохицуулж байдаг **харьцангуй шинжтэй** бус, харин эд

<sup>11</sup> Б.Баттөмөр: МУ-ын Иргэний эрх зүйн зарим асуудал, 2005 он, 166 дахь тал..

<sup>12</sup> ИХ-ийн тайлбар толь, Ерөнхий анги, УБ хот 2006 он, 293 дахь тал.

<sup>13</sup> Д.Цолмон: Оюуны өмчийн эрх зүй, нүүр 21; С.Нарангэрэл/Н.Тэмүүлэн: Зохиогчийн эрхийн асуудал,

<sup>14</sup> Б.Баттөмөр: МУ-ын Иргэний эрх зүйн зарим асуудал, 167 дахь тал.



зүйл, субъект хоёрын харилцааг зохицуулж, энэ харилцааны үндсэн дээр бусад ямар ч этгээдийг тухайн эд зүйлтэй харилцаа үүсгэхийг хориглож болдог **туйлын шинжтэй** салбар юм. Эдийн баялаг буюу эд юмсыг хууль ёсны өмчлөгчөөс өөр этгээдэд бүр мөсөн шилжүүлж болдог (**транслатив** байдлаар эрх шилжүүлэх) ба мөн тэднийг ашиглах эрх мэдлийг дангаар нь шилжүүлж болдог (эрх үүсгэх буюу **конститутив** байдлаар эрх шилжүүлэх). Оюуны өмчийн хувьд дээрх нэгэн адил үйлчлэх боловч цөөхөн тохиолдолд жишээлбэл зохиогчийн эрхийн хүрээнд транслатив байдлаар эрхийг зөвхөн өвийн журмаар шилжүүлж болдог.

### **Эдийн бус баялаг, эдийн баялгийн ялгаа**

Эдийн бус баялгийг ашиглах явцад зөвхөн ховор тохиолдолд л эд зүйл шиг тухайн бүтээлийн хувийг эзэмшилдээ авсан байхыг шаарддаг тул хүн бүхэнд энэхүү үнэт зүйлийг хүртээх боломжтой. Тиймээс оюуны өмчийн хамгаалалт эдийн баялгийн өмчлөлийг хамгаалахад тавигдах шаардлагаас эрс ялгаатай. Эдийн бус баялгийн тоо томшгүй олон хэлбэр байх боломжтой тул үүнээс үүдээд нэг бүтээлийн хувьд түүнийг маш олон талаас нь хамгаалах бололцоо бий болно. Бүтээлийн биежсэн хэлбэрт эд зүйлийн өмчлөл үүсч болох ба жишээлэхэд байгууллагын лого буюу таних тэмдгийг зохиогчийн эрх, барааны тэмдгийн эрх зэрэг хэд хэдэн оюуны өмчийн хууль тогтоомжоор зэрэг хамгаалах бололцоотой. Тиймээс эрх зүйн хувьд хоорондоо үл зөрчилдөх олон шаардах эрх үүсэх нь ердийн үзэгдэл бөгөөд энэхүү олон талт чанартай холбогдоод олон янзын, өөр хоорондоо ялгаатай эрх зүйн зохицуулалт шаардагдана.

Эдийн бус баялгийн эрхийг олон этгээд хоорондоо өрсөн байж эдлэнэ гэсэн ойлголт байхгүй бөгөөд хэн нэгэнд нь **монополь эрх** олгосноор ховордмол байдлыг хиймлээр үүсгэдэг бол эд зүйлсийн хувьд байгалиасаа зөвхөн ганц этгээд ашиглах боломжтой байдаг нь түүний байгалиас заяасан шинжтэй салшгүй холбоотой. Аливаа үнэт зүйлийг эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалах нь нийгэмд ихээхэн ач холбогдолтой байдаг бол оюуны өмчийн хувьд энэ нь гол төлөв тусгай хууль тогтоомжийн зүйл заалтаар дамжин хэрэгжинэ.

Эзэнгүй эд юмсын хувьд тэдгээр нь хэн нэгэн этгээдийн эзэмшилдээ авснаар ИХ-ийн §115.2 болон ИХ-ийн §104.1-ийн дагуу өмчлөлийн зүйл болох боломжтой байдаг бол ардын утга зохиол болон дуусгавар болсон патент зэрэг нь бүр мөсөн нийтийн өмч болдог. Мөн оюуны өмчийн эрх нь цаг хугацаагаар хязгаарлагдсан байх ба үүний зэрэгцээ энэ эрхэнд хамаарах улс орны хууль тогтоомж эдийн баялагт ноогдохоос илүү олон хязгаарлалт тогтоосон байх бол эдийн баялгийн эрх дуусгавар болтлоо бат оршин байдаг. Иргэний Хуульд эдийн баялагт тогтоосон цөөн хязгаарлалтыг дурьдвал ИХ-ийн §101.3/4 г.м.

### **Эрх зүйн объектийг субъектээс ялгах нь**

Иргэний эрх зүйн объект нь логикийн үүднээс хэзээ ч эрх, үүргийн эзэн байх боломжгүй бөгөөд үргэлж эрх зүйн захирах захирагдах харилцааны зүйл болно.

Эсрэгээрээ эрх зүйн субъект нь хэзээ ч эрх зүйн объект болохгүй. Тухайлбал хувь хүн өөрийгөө болон бусад хүнийг эзэмшинэ гэсэн ойлголт байхгүй. Мөн өнөө үеийн гэр бүлийн хамтын амьдралд эрх зүйн субъектүүдийн эрх чөлөө, тэгш байдлын зарчим үйлчлэх тул гэр бүлийн гишүүд нэг нь нөгөөгөө захирах эрхгүй болно. Амины эрх хувь хүнийг нас барснаас хойш мөн адил үйлчлэх тул хүний биеийн цогцос мөн эрх зүйн объект болохгүй. Хүний биеийн хэсэг зөвхөн биеэс салсан тохиолдолд л эрх зүйн харилцааны объект болно. Жишээ нь, тайрсан үс, шилжүүлэн суулгахад зориулсан эрхтэн гэх мэт. Эдгээрт холбогдох үүргийн хэлцэл нь харин ИХ-ийн §56.1.1-д зааснаар нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуунд харшлах ёсгүй.

### Эд юмсын нэгдэл

Эд юмсын нэгдэл гэдэгт нэгдмэл зорилгын үндсэн дээр нэг бүхэл мэт үзвэл зохих, хэд хэдэн эд зүйлийг ойлгоно. Эдгээр нь ихэвчлэн нэг нэртэй байна. Жишээлбэл, номын сан, мал сүрэг, барааны агуулах, зоосны цуглуулга, хөдөө аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмж, хоолны газар гэх мэт. Дээрх нь тус тусдаа байхаасаа илүү нэгдсэнээрээ эдийн засгийн хувьд ач холбогдолтой болдог. Тухайлбал, эднийг хамтад нь худалдах зэрэг эдийн засгийн харилцааны объект болгох боломжтой. Аливаа эрх зүйн тогтолцоонд өмчлөх эрх нь **тодорхой** эд хөрөнгөтэй салшгүй холбоотой байх тул нэгдмэл эд юмсын өмчлөл гэсэн тусдаа ойлголт байдаггүй. Энд зөвхөн эдийн засгийн нэгдмэл зорилгод нийцсэн эрхийг тодорхойлж, түүнийг захирах эрх бий болгох ба энэ нь өмчийн эрх зүйн тусгай зарчим болох эд хөрөнгө бүхэн тодорхой эрх зүйн субъектэд харьяалагдаж байх зарчимтай уялдаатай юм.

### Эрхийн нэгдэл

Эрхийн нэгдэл гэдэгт нэг этгээдэд ноогдох нийт хөрөнгө, аж ахуйн нэгж зэрэг багтана. Эрхийн нэгдлийн практикт хамгийн өргөн тохиолдох жишээ бол аж ахуйн нэгж юм. **Аж ахуйн нэгж** гэдэг нь хувь хүмүүсийн болон эд хөрөнгийн нэгдэлд суурилсан эдийн засгийн бие даасан нэгж боловч бие даан иргэний эрх зүйн объект болгоход ихээхэн хүндрэлтэй. Үүнийг худалдахын тулд **asset deal буюу хөрөнгийг нэг бүрчлэн шилжүүлэх** эсвэл **share deal буюу хувьцааг шилжүүлэх** хэлбэрээр шилжүүлэх арга замын нэгийг сонгоно.

## В. Субъектив ЭРХ

Зарим судлаачид эрх хэмээх ойлголтыг объектив болон субъектив утгаараа хэрэглэх нь бий. Объектив утгаараа эрх хэмээх ойлголт нь эрх зүйн хэм хэмжээний нийлбэрийг илэрхийлэх ба өөрөөр хэлбэл, энд эрх зүйн тогтолцооны нийлбэр цогцыг ойлгоно. Энэ утгаараа “эрх зүй” хэмээх ухагдахуунтай дүйж байдаг. Субъектив утгаар нь тодорхой этгээдэд оноож өгсөн, түүний хүсэл



зоригоос хамааран хэрэгжиж байдаг эрх зүйн байр суурийг эрх хэмээн ойлгоно. Хэрэв хэн нэгэн аливаа эд зүйлийн өмчлөгч бол тэрээр өмчлөх эрхийг эдлэх субъектив эрхтэй байна гэсэн үг. Субъектив эрх нь объектив хэм хэмжээг аливаа маргааны хүрээнд хэрэглэснээр бий болдог. Субъектив эрхийн шинж нь нэг тал нь аливаа эрх эдэлж, нөгөө тал холбогдох үүрэг хүлээх явдал бөгөөд тодорхой ашиг сонирхлыг хамгаалах үүднээс холбогдох этгээдэд эрх олгосныг **субъектив эрх** хэмээн ойлгоно.

Субъектив эрх хэмээх ойлголтыг тодорхой болгохын тулд суурь эрх зүйн харилцааг судалж авч үзэх хэрэгтэй. Эрх зүйн харилцаа нь тодорхой нэг субъектив эрхээр илрэх боломжтой ч үүнтэй харьцуулахад илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд олон субъектив эрхийг хамрах боломжтой. Жишээ нь, эрх зүйн харилцааны томоохон хэлбэр болох үүргийн харилцааг авч үзвэл энд худалдах-худалдан авах гэрээний үүргийн харилцаа үүссэн нөхцөлд худалдагч үнийг шаардах эрхтэй болох тул тэрээр эд хөрөнгө шилжүүлэхэд чиглэсэн субъектив эрхтэй. Мөн энд бусад субъектив эрхүүд үүснэ. Жишээ нь ИХ-ийн §254-ийн дагуу доголдолтой эд хөрөнгийг солиулах, үнийг бууруулах болон гэрээг цуцлах гэх мэт. Тиймээс аливаа этгээдийн зүгээс бусад этгээдтэй болон эд зүйлстэй харьцах харилцааг эрх зүйн хувьд зохицуулсныг **эрх зүйн харилцаа** гэнэ.

### **Туйлын болон харьцангуй эрх**


Субъектив эрхийг дотор нь олон шалгуураар ангилж болох ч туйлын болон харьцангуй эрх хэмээн ангилна. Өмчийн эрх нь эрх зүйн тогтолцоонд тал бүрээсээ хамгаалагдсан байдаг гэдэг утгаараа *туйлын эрх* болох бөгөөд гадна гагцхүү тодорхой этгээдээс хамгаалахад чиглэсэн эрхий *харьцангуй эрх* гэнэ. Харьцангуй эрхийг зөвхөн холбогдох этгээдийн эсрэг шүүхээр хэрэгжүүлэх боломжтой. Үүнд ИХ-ийн §186.1-д тодорхойлсон шаардах эрхүүд хамаарна. Үүргийн эрх зүйн шаардах эрхүүдийг эрхийн ангилалд хамаатуулан үзнэ. Тиймээс худалдагчийн зүгээс худалдан авагчид хандан хэрэгжүүлэх мөнгө төлүүлэх эрх нь харьцангуй субъектив эрх юм. Харьцангуй эрхийг гуравдагч этгээд зөрчинө гэсэн ойлголт байхгүй. Өмчийн эрх болон бусад туйлын эрхтэй холбоотой маш олон шаардах эрх бий. Эдгээр нь харьцангуй эрхийн ангилалд багтана. Учир нь үүнийг зөвхөн шаардах эрхийн бүрэлдэхүүн хангасан этгээдийн эсрэг хэрэгжүүлэх боломжтой. Жишээ нь бусдын эд зүйлийг эвдсэн гэм буруутай үйлдлийн улмаас өмчлөгч гэм хор учруулагчид хандан хохирол нэхэмжлэх эрх үүснэ, ИХ-ийн §497.

Туйлын эрхийг эд зүйлийг захирах эрх (өмчлөх эрх, барьцааны эрх, сервитут г.м.), амины эрхүүд (ерөнхий болон тусгай амины эрхүүд, жишээ нь нэрийн эрх, өөрийн дүрийг толилуулах эрх, урлагийн бүтээл туурвигчийн эрх г.м.), эдийн бус баялгийн эрх (эдийн бус баялгийг захирах эрх: Зохиогчийн эрх, Патентын эрх) хэмээн ангилна.

## Эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн эрх

Туйлын болон харьцангуй эрхээс гадна эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн процессын шинжтэй эрхүүд нь субъектив эрхийн ангилалд нэгэн адил хамаарна. Эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн эрхийг туйлын эсвэл харьцангуй эрх гэсэн ангилалд багтаан үзэх боломжгүй. Харин эдгээрийг хэрэгжүүлсний дараа гарч буй үр нөлөөг дээрхийн аль нэгэнд хамаатуулан авч үзэх боломжтой.

Жишээ нь, хэлцлийг хүчин төгөлдөр буст тооцуулах эрх, гэрээг цуцлах эрх, гэрээнээс татгалзах эрх гэх мэт. Эдгээрийг эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн эрх хэмээн нэрийдсэн нь эрх бүхий этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэлд тулгуурлан эрх зүйн харилцааг өөрчлөх боломж нээгддэгтэй холбоотой. Ингэснээр тухайн этгээд өөрийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой ашиг сонирхлоо хамгаалах ба иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүнийг процессын хэсэгчилсэн субъектив эрхийн журмаар хэрэгжүүлдэг.



## Хоёр. Хяналтын асуулт:

- Хувь этгээд иргэний эрх зүйн харилцааны субъект байх үндсэн шинжийг тодорхойлно уу.
- Иргэний эрх зүйн чадварыг иргэний эрх зүйн харилцааны бусад субъектын чадвараас ялгаж тайлбарлана уу.
- Өгөгдсөн тохиолдол дээр оролцогчдын иргэний эрх зүйн чадамжийг ангилж, тайлбарлана уу.
- Нэр, оршин суух газрын талаар тохиолдол дээр тайлбарлана уу.
- Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах хууль зүйн үндэслэлийн үр дагаврын онцлогийг тодорхойлно уу.



- Өнөөгийн нөхцөлд иргэн иргэний эрх зүйн харилцааны субъект болохоо хир зэрэг мэдэрч оролцдог вэ?
- Хуулийн этгээдийн үндсэн шинжийг тодорхой байгууллагын жишээн дээр тайлбарлана уу.
- Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагаар ямар ямар байгууллага байж болох вэ?
- Хуулийн этгээдийг ангилах шалгуурыг тодорхойлж, өгөгдсөн тохиолдол дээр төрлөөр ангилж, ялгагдах шинжийг гаргана уу.
- Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг өгөгдсөн тохиолдол дээр ялган тайлбарлана уу.

### Гурав. Сорилго

1. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл
  - a. Хуульд үл харшлах хэлцэл
  - b. Захиргааны байгууллагын шийдвэр
  - c. Шүүхийн шийдвэр
  - d. Хууль зүйн үйл явдал бий болох
2. Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай субъект нь:
  - a. Иргэний эрх зүйн хэлцлийг бие даан хийх эрхгүй
  - b. Иргэний эрх зүйн хэлцлийг бие даан хийх эрхтэй
  - c. Хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ
  - d. Хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлийг хийнэ
3. Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд нь:
  - a. Хязгаарлагдсан чадамжийнхаа хүрээнд, асранхамгаалагчийн зөвшөөрлөөр хэлцэл хийж болно
  - b. Хязгаарлагдсан чадамжийнхаа хүрээнд, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийж болно
  - c. Хууль ёсны төлөөлөгч буюу эцэг эх нь төлөөлж хэлцэл хийнэ
  - d. Хуваарьт хөрөнгийнхөө хүрээнд бие даан хэлцэл хийх эрхтэй
4. Сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгөд:
  - a. Шүүхээс эрхлэн хамгаалалт тогтооно
  - b. Эрхлэн хамгаалалт тогтоож болно
  - c. Өв залгамжлагчид шилжүүлнэ
  - d. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр битүүмжлэнэ
5. Иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй иргэнд аль нь хамаарах вэ?
  - a. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис байнга хэрэглэдэг этгээд

- b. 7 настай сурагч
  - c. Сэтгэцийн өвчний улмаас шүүхээр асран хамгаалалт тогтоолгосон этгээд
  - d. Сураггүй алга болсноор тооцогдсон иргэн
6. Иргэний эрх зүйн чадамжийг хэлцэл хийх замаар хязгаарлаж болох уу?
- a. Болно
  - b. Болохгүй
  - c. Зарим тохиолдолд болно
  - d. Хуульд заасан тохиолдолд хязгаарлаж болно
7. Субъектив эрхийн хоёр том бүлийг нэрлэнэ үү.
- a. Шаардах эрх ба өмчийн эрхүүд
  - b. Эрх өөрчлөхөд чиглэсэн эрхүүд
  - c. Туйлын ба харьцангуй эрхүүд
  - d. Амины ба туйлын эрхүүд

## Дөрөв. Хэрэглэгдэхүүн

### Сурах бичиг, тайлбар толь:

1. Наранчимэг Д. “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ, 1999 он
2. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
3. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
4. Э.Байгал. Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он
5. ГТХН-ээс эрхлэн гаргасан Иргэний хуулийн тайлбар толь. Ерөнхий анги, Улаанбаатар хот 2006 он

### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Д.Энхзул. Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
3. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.

### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.




### Сэдэв 2.3: Иргэний эрх зүйн харилцааны элемент, тэдгээрийг танин мэдэхүйн практик ач холбогдол

**Сэдвийн зорилго:** Иргэний эрх зүйн харилцааны талаар лекцээр олж авсан мэдлэгээ бататгах, иргэний эрх зүйн харилцааны үндсэн шинж, объектын ангилал төрлийг судалж мэдсэнээр хоорондоо ижил төсөөтэй зарим харилцааг ялгаж зааглах, тодорхойлох чадварыг өгөгдсөн тодорхой тохиолдол, баримт бичиг дээр ажилласны үндсэн дээр эзэмшинэ.

#### Нэг. Семинар

- Иргэний Хуулийн бүтэц, агуулгыг судалсан эсэхийг шалгах.
- Иргэний эрх зүйн харилцааны субъект, объектой холбоотой зохицуулалттай танилцсан эсэхийг шалгах.
- Субъектив эрх олгосон гол гол зохицуулалтыг давтах. Өгсөн, авснаа буцаан шаардах, гүйцэтгэлийг явуулах, хохирол арилгуулах, зардлаа нөхөн төлүүлэх, эрхийн зөрчлийг таслан зогсоох, үүнээс сэргийлэх зэрэг иргэний эрх зүйн хамгийн чухал шаардах эрхүүдийг жишээ болгон уншиж, танилцуулах.
- Бодлого бодох аргачлалтай танилцах.
- Лекцээр олж авсан онолын мэдлэгийг тодорхой тохиолдол дээр шинжлэн судлуулах.

**Жишээ нь:** Эдийн баялгийн эрхэд холбогдох хуулийн зохицуулалтыг уншиж танилцах, ангилах:



## - Бодлого бодож эхлэх арга зүйн зөвлөгөө өгөх:

Бодлого бодох, хэрэг хэрхэн шийдэх тухайд хийсвэр онол суралцах явдал хожим практикт төдийлөн ач холбогдолгүй байдаг. Харин онол судлах явцдаа бие даан тохиолдол шийдэх нь хамгийн оновчтой. Үүнд дараах алхмуудыг анхаарах нь зүйтэй.

### 1. Өгөгдлийн эцэст тавьсан асуултыг түрүүлж унших

Зарим уншигчийн хувьд өгөгдлөөс нь эхлэх зүйтэй санагдаж болох авч бодлогын эцэст тавьсан асуултаас эхлэх явдал ялангуяа, урт хэргийн зангилааг түргэн олоход дөхөмтэй байдаг тул асуултыг түрүүлж уншаад, үүгээр удирдуулан хэргийн эхийг судлах нь зохимжтой. Харин “эрх зүйн дүгнэлт өг” гэх мэт ерөнхий даалгавар бүхий бодлогын хувьд оролцогч бүрийн хооронд иргэний эрх зүйн харилцаа үүссэн эсэх, мөн харилцан шаардах эрх бий эсэхийг тогтоох болдог. Тиймээс асуултыг эхэлж хараад, өгөгдөлтэй ажиллах нь зорилгоо удирдлага болгон асуудлыг тодорхой чиглэлээр боловсруулах хялбар дөт зам болдог.

### 2. Өгөгдлийг хоёр дахин унших

Аливаа тохиолдлыг эрх зүйн үүднээс шинжлэх явцад гарах алдаа нь хууль буруу хэрэглэхээс гадна ихэнхдээ өгөгдлийг буруу ташаа ойлгосон, дүгнэсэнтэй холбоотой байх тул эрх зүйн дүгнэлт эхлэхээс өмнө өгөгдлийг заавал ахин нэг анхааралтай унших нь зүйтэй.

### 3. Зураглал бэлдэх

Өгөгдлийг унших явцад дийлэнх бодлогын хувьд зураглал гаргах нь үйл явдлуудыг тухайлбал, гэрээ байгуулагдсан эсэх, эд хөрөнгө шилжүүлэх, төлбөр төлөх эсвэл шаардах эрх шилжүүлэх алхам хийгдсэн эсэх гэх мэт эрх зүйн ач холбогдолтой нөхцөлийг бүрэн гүйцэд тэмдэглэж, зүйл заалт оноож өгөх ба эргэж харахад тустай байдаг. Ялангуяа, олон этгээд оролцсон нөхцөлд зураглал гаргах зайлшгүй шаардлагатай. Мөн эрх зүйн хувьд бие даасан хэд хэдэн үйл явдал өрнөсөн нөхцөлд, жишээ нь аж ахуйн нэгж байгуулаад удалгүй эзэн нь нас барснаар өв залгамжлалын асуудал яригдаж буй тохиолдолд хэд хэдэн зураглал зайлшгүй шаардагдана. Үүнээс гадна хугацаа ач холбогдолтой нь илт байх бодлогын хувьд он цагийн дарааллаар үйл явдлыг хүснэгтлэх нь зохимжтой. Эдгээр нь гэхдээ бодолтын бүрдэл хэсэг болохгүй бөгөөд зөвхөн тухайн бодлого бодогчийн бэлтгэл ажилд хамаарна.

### 4. Хураангуй

Бодлогын асуултыг удирдлага болгон эрх зүйн асуудлыг хураангуй байдлаар тэмдэглэх ба энэ нь бодлогын хариуг бэлтгэх эхний алхам юм.



## 5. Бодлогын хариу

Дээр дурьдсанчлан яг ямар эрх зүйн асуудлыг шийдэхээ тогтоосны эцэст Иргэний хуульд заасан хувь этгээдийн субъектив эрх болох шаардах эрхийг бүрэлдэхүүнээр задлан үүнийхээ дагуу өгөгдлийг шалгаж, богино тэмдэглэл хийх хэрэгтэй. Бодлого бодох цаг ихэвчлэн өөрийн бодлоо ноорог дээр буулгаад дараа нь дахин хэлбэрт оруулахад хүрдэггүй тул шийдвэрээ тухайн шаардах эрхийн нөхцөл бүрт хураангуйлсан байдлаар тэмдэглэх нь зүйтэй. Үндсэндээ цагаа зөв хуваарилах нь их чухал бөгөөд ойролцоогоор гуравны нэгийг хариугаа бэлтгэхэд, гуравны хоёрыг цэвэр бичилтэд зориулах нь зүйтэй. Ингээд хариугаа ахин нэг нягталж үзсэний эцэст дүгнэлтээ бичих бөгөөд цаг үлдвэл яаран хураалгах бус тайван сууж, бичилтээ унших нь хэрэгтэй. Учир нь зарим тохиолдолд чухал санааг төгсгөлд нь олох тохиолдол олон байдаг.

### Өгөгдлийг тайлбарлах

Иргэний эрх зүйн маргааныг сургалтын явцад ихэвчлэн бодлогын өгөгдөл хэлбэрт оруулсан байх ба холбогдох нөхцөлүүдийг маргаангүй, нотлох баримтыг үнэлэх шаардлагагүй байхаар тодорхойлсон байдаг. Өгөгдлийг үндсэндээ бүрэн дүүрэн хэмээн үзэж, бодит үйл явцыг ургуулан бодох, төсөөлөх, мөн амьдралд нийтлэг тохиолддог хэмээн үзэж, өөрийн туршлагаар өгөгдлийг баяжуулах шаардлагагүй.

### Шаардах эрх ба эрх зүйн үндэслэл

Иргэний эрх зүйн бодлогын дийлэнх нь буюу 95 орчим хувь нь хохирол нөхөн төлүүлэх, эд хөрөнгө буцаан олгох, эрх зөрчиж буй үйлдлээ зогсоох болон бусад эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн шаардах эрхийг шалгах даалгавартай байдаг. Аливаа шаардах эрхийг шалгахын тулд эхлээд эрх зүйн үндэслэлийг тодорхойлох ба үүнд бусдаас үйлдэл, эс үйлдэхгүйг шаардах боломж олгож буй субъектив эрх агуулсан хэм хэмжээг ойлгоно, ИХ-ийн §186.1.

Холбогдох шаардах эрхийн үндэслэлийг олсны дараа энэхүү хэм хэмжээний урьдчилсан нөхцөлийг нэг бүрчлэн тогтоогоод эдгээртэй өгөгдлөө харьцуулах замаар тухайн хэм хэмжээний нөхцөлүүд биелсэн эсэхийг шалгаж дүгнэх үйл явцыг **субсумци хийх** (Subsumtion) гэж нэрлэх ба энэ нь хуульч хүний нийлүүлэх гол бүтээгдэхүүн байдаг. Аливаа бодлого бодох явцад өгөгдлийг төгсгөлийн үйл явдлаас эхний үйл явдал хүртэл урвуу дарааллаар авч үзэх бөгөөд энэ нь эрх зүйн ач холбогдол бүхий асуудлыг тодорхой өгөгдсөн зорилгын дагуу дүгнэх боломж олгоно. Харин энэ зорилгоос хөндийрч, лекцээр олгосон мэдлэгийн ач холбогдолтой эсэхийг үл харгалзан буулгах нь бодлого бодох болон улмаар практикт алдаанд тооцогдох аюултай.

### Эрх зүйн дүгнэлт бичих тухай

Бодлогын хариуг эцэст нь уншигчид толилуулсныг эрх зүйн дүгнэлт хэмээн нэрлэх бөгөөд энэ нь шууд утгаараа логик дүгнэлт хэлбэрээр бичигдсэн байдаг.

Дүгнэлт нь эрх зүйн хувьд ач холбогдол бүхий бүх үзэл баримтлалыг хамрах ёстой бөгөөд тухайн маргаанд холбогдох бүх шаардах эрхүүд, мөн шаардах эрхийг үгүйсгэх нөхцөлийг агуулсан байна.

### *Иргэний Хуулинд тусгагдсан чухал шаардах эрхүүд*

Иргэний Хуулийг агуулгаар бүлэглэж, ерөнхий бүтцийг тодорхойлох даалгавар өгсөний дараа шаардах эрхийг тус ангиллын дагуу бүлэглэх дасгал хийх:

- А. Гэрээнээс үүдэлтэй шаардах эрхүүд
- Б. Гэрээтэй төстэй харилцаанаас үүдэх шаардах эрхүүд
- В. Өмчийн эрх зүйн шаардах эрхүүд
- Г. Үндэслэлгүй хөрөнгөж ихтэй холбоотой шаардах эрхүүд
- Д. Гэм хорын эрх зүйгээс үүдэлтэй шаардах эрхүүд

### **- Холбогдох ангиллын дагуу дасгал ажиллах, тохиолдол шинжлэх:**

#### **Дасгал:**

**Жишээ 1:** А амь насанд эрсдэлтэй үйл ажиллагаа эрхэлдэг. Түүний эхнэр Э удахгүй хүүхэд төрүүлэх гэж буй тул тэрээр хүүхдийн амьдралын баталгааг хангах зорилгоор нэгэн үл хөдлөх хөрөнгийг түүнд шилжүүлэх хүсэлтэй. Ингэх боломжтой юу?

а). Б-ийн гэм буруутай ослын улмаас Э хүнд гэмтсэн. Гэмтлийн улмаас хүүхэд тахир дутуу гарчээ. Хохирлыг Б-ээр арилгуулах боломжтой юу?

**Жишээ 2:** А энэ удаа Орос-Монголын харилцааг сайжруулах зорилгоор холбоо байгуулахыг хүсчээ. Тус холбоо нь юуны өмнө соёл-шинжлэх ухааны үйл ажиллагааг дэмжих зорилготой. Түүнээс гадна тэрээр орос хүмүүсийг урьж авчирч, төлбөртэй үзвэр үйлчилгээ санал болгох хүсэлтэй.

а). Дээрх холбоо нь ямар нөхцөлд эрх зүйн харилцаанд оролцох бүрэн эрхтэй болох вэ?

б). Холбоог бүртгүүлснээс хойш 3 сарын дараа үүсгэн байгуулагчийн нэг Ү 17 настай болох нь тогтоогдож, түүний эцэг, эх холбооны гишүүн байхыг зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгджээ. Тэд Ү-ийн төлсөн гишүүний сарын хураамж болох 10000 төгрөгийг хүртэл буцаан шаардав. Эрх зүйн үр дагаврыг тодорхойлно уу.

**Жишээ 3:** а). А өөрийн үйлдвэрийн хашаа руу нэвтрэх хоёр дахь гарц нээхийг хүсч байжээ. Тиймээс тэрээр хөрш Х-тэй харилцан тохирч, тус үйлдвэрт зориулан холбогдох гарцыг Х-ийн өмчлөлийн газраар дамжин өнгөрч байхаар тогтов. Энэ тохиролцооноос ямар эрх, үүрэг үүсэх вэ?

б). Шүдний эмч Э нь А-д зориулан дээд тагнай бүхий хиймэл шүд, мөн доод эрүүнд нь алтан шүд суулгаж өгсөн байна. Холбогдох төлбөрийг А нэгэн зэрэг шууд хийх боломжгүй байсан тул тэд Э-ийн саналаар А-г мөнгөө төлтөл



дээрхийн өмч шилжихгүй байхаар тохирсон байна. А төлбөрийг хийж чадаагүй тул Э хиймэл болон суулгац шүдийг эргүүлэн өгөхийг шаардав.

в). Маш гоёмсог урт үстэй Э үсээ засуулахдаа дараачийн удаа ирэхдээ үсээ тайруулж, үсчин Ү-д өгөх тухай тохиролцож, 50000 төгрөгийг нь урьдчилан авчээ. Ү энэ урт үсийг бусдад үс залгахдаа ашиглах хүсэлтэй байв. Харин Э үсээ тайруулсны эцэст өөрөө авч үлдмээр байгаагаа илэрхийлжээ.

г). Гэр ахуйн хогшил үйлдвэрлэгч Г өөрийн байгуулж босгосон үйлдвэрээ бүхэлд нь Х-д шилжүүлэхийг хүсч байгаа бол энэ боломжтой эсэхийг дүгнэнэ үү.

д). А авсан зээлийнхээ баталгаа болгож Б банкинд үнэт эдлэлийн цуглуулгынхаа өмчлөх эрхийг шилжүүлсэн байна. Тэрээр зун нь нилээд хэдэн зүйл нэмж худалдаж авсан ба өвөл нь зээлээ төлж чадахгүй нөхцөл байдал үүсэхэд банк түүнээс цуглуулгаа биетээр нь шилжүүлэн өгөхийг шаарджээ. А ийнхүү шилжүүлж өгөх үүрэгтэй юу?

**Жишээ 4:** а). Аж ахуйн нэгжийн эзэн А ундааны цех ажиллуулдаг ба суурь машиндаа зориулан Б-ээс нэгэн шинэ моторыг үнийг нь төлснөөр өмчлөх эрх шилжих болзолтойгоор худалдаж авчээ. А үнийг төлж чадахгүй байсан тул Б түүнээс аль хэдийн суурь машиндаа угсарч нэгтгэсэн байсан моторыг эргүүлж өгөхийг шаарджээ.

б). Алтай зоогийн газрын эзэн А үйлчилгээгээ сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчийн нүдэн дээр хоолыг бэлдэхэд тохиромжтой ил зуух, мөн ус халаагч төхөөрөмж авчээ. Эдгээрийг суулгасны эцэст тэрээр үнийг төлөхгүй удсан тул нийлүүлэгч үнэ төлснөөр өмч шилжих тохиролцоогоо сөхөж, төхөөрөмжийг буцаан шаардав.

в). Цэцэг дэлгүүрийн бэлтгэн нийлүүлэгч Н газрын эзэн Г-ээс 20 жилийн хугацаатай газар түрээслэсэн ба тэндээ үл хөдлөх суурь бүхий хүлэмж барьж, цэцэг тарьжээ. Энэ хүлэмж, цэцгүүд нь хэний өмчлөл болох вэ?

г). Ц нь зуслангийн айлуудыг хангахуйц жижиг оврын цахилгаан станц оруулж ирсэн бөгөөд бусад айлуудтай урт хугацааны түрээсийн гэрээ байгуулж, газар дээгүүр нь цахилгаан дамжуулах хоолойг суурилуулсан байна. Харин түүний зээлийн үүрэг гүйцэтгүүлэгч болох Ү нь Ц-ийн үл хөдлөх хөрөнгө дээр үүссэн ипотекийн барьцааны эрх дээрх хоолойг мөн адил хамрах эсэхийг лавлажээ.

### Хоёр. Хяналтын асуулт:

1. Эрх зүйн тогтолцоог ямар хоёр үндсэн салбар бүлэгт хувааж болох вэ?
2. Хувийн эрх зүйн зохицуулах салбар хэсгүүдийг нэрлэнэ үү.
3. Нийтийн эрх зүйн зохицуулах зүйлийг нэрлэж жишээ татна уу.
4. Эрүүгийн хуулийн §148 -д заасан хулгайн гэмт хэрэг хувийн эрх зүйд хамаарах уу, эсвэл нийтийн эрх зүйн асуудал уу?

5. Шаардах эрх гэдэгт юуг ойлгох вэ?
6. 2002 оны шинэ Иргэний Хуулийг батлахаас өмнө Монгол Улсад иргэний эрх зүйн ямар тогтолцоо үйлчилж байсан бэ?
7. Шинэ Иргэний Хуулийн батлагдсаны давуу талыг нэрлэнэ үү.
8. Иргэний эрх зүйн чадвар гэдэгт юуг ойлгох вэ?
9. Хувийн эрх зүйн субъектуудыг хэрхэн ангилах вэ?
10. Үр хөврөл эрх зүйн чадамжтай юу?
11. ИХ-д ямар ямар төрлийн хуулийн этгээдийг тусгасан байдаг вэ? Эдгээр нь хэдийнээс эрх зүйн чадвартай болох вэ?

## Гурав. Сорилго

1. Иргэний эрх зүйн харилцаан дахь хамгийн чухал шаардах эрхүүдийг нэрлэнэ үү.
  - a. Өгсөн авсанаа буцаан шаардах
  - b. Гүйцэтгэл явуулах,
  - c. Хохирол арилгуулах, зардлаа нөхөн төлүүлэх
  - d. Эрхийн зөрчлийг таслан зогсоох, үүнээс сэргийлэх
  - e. Дээрх бүгд зөв.
2. Иргэний Хуулиас шаардах эрх хайх дарааллыг тодорхойлно уу.
  - a. Гэрээнээс үүдэлтэй, гэрээтэй төстэй, өмчийн эрх зүйн, гэм хорын болон үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой
  - b. Гэрээнээс үүдэлтэй, гэрээтэй төстэй, өмчийн эрх зүйн, үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой болон гэм хорын эрх зүйн
  - c. Дээрх хоёр хувилбар хоёулаа зөв.
  - d. Өмчийн эрх зүйн, гэрээний эрх зүйн болон бусад.
3. Анэгэн спортын холбооны гишүүн бол гишүүнчлэлээ охиндоо шилжүүлж болох уу?
  - a. Болно.
  - b. Болохгүй.

## Гурав. Хэрэглэгдэхүүн

### Сурах бичиг, тайлбар толь:

1. Б.Тэмүүлэн./Д.Энхзул/Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
3. Э.Байгал. Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он
4. ХЗҮТ/ГТХАН-ээс эрхлэн гаргасан. Иргэний хууль -Шинэлэг зохицуулалт, УБ хот 2003 он.
4. ГТХН-ээс эрхлэн гаргасан Иргэний хуулийн тайлбар толь. Ерөнхий анги, Улаанбаатар хот 2006 он



### **Гарын авлага, бодлогын хураамж:**

4. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
5. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.

### **Хууль тогтоомж, шүүхийн практик:**

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2003 он
5. Компаний тухай хууль 1999 он
6. Нөхөрлөлийн тухай хууль 1994 он
7. Хоршооны тухай хууль 1999 он

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЭЛЦЭЛ

### 3.1.: Хэлцлийн тухай ойлголт, ангилал

**Сэдвийн зорилго:** Хэлцэл, түүний үндсэн шинж, тавигдах шаардлагыг танин мэдэж, тодорхой тохиолдол дээр хэрэглэх чадвар эзэмших, цаашид гэрээний эрх зүй хичээлийг гүнзгийрүүлэн судлахад суурь болно.

#### Нэг. Тойм лекц

##### Хэлцэл, түүний ач холбогдол

Хэлцэл нь иргэний эрх зүйн чанартай үйл хөдлөлийн гол цөм нь бөгөөд энэ утгаараа аливаа **хүсэл зоригийн илэрхийлэл** нь хувийн чөлөөт байдлыг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл юм. Тиймээс хувийн эрх зүйн тогтолцоо нь Үндсэн Хуулиар баталгаажсан хувь хүний эрх чөлөөг хэрэгжүүлэх томоохон салбар бөгөөд энд хувийн чөлөөт байдлын зарчим үйлчилнэ. Хувь хүний чөлөөт байдал нь чөлөөт ардчилсан нийгмийн тулгуур болохоос гадна зах зээлийн чөлөөт өрсөлдөөний суурь юм. Хувийн эрх зүйн тогтолцоо нь гэрээ, хэлцлийг мөрдөх замаар хэрэгжих тул энд мөн латинаар **pacta sunt servanda** буюу гэрээг заавал биелүүлэх зарчим үйлчилнэ. Нөгөө талаас хувийн эрх зүйд хувь этгээдийн эрх чөлөөг хязгаарлах аргаар шударга ёсыг тогтоох гэсэн оролдлого хийснийг хууль зөрчсөн эсвэл нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуунд харш хэлцэл хийхгүй байх хориг тавих (ИХ-ийн §56.1.1), гэрээний нөхцөлийг шалгах шалгуур үзүүлэлтүүдийг хуулинд тусгах (ИХ-ийн §202), хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж батлах зэргээр оролцогсдын эрх чөлөөг хязгаарласан зохицуулалтаас харж болно.

##### Хэлцэл –ухагдахуун, агуулгын шаардлага

Хэлцэл гэдгийг дор хаяж нэг этгээдийн хүсэл зоригийн илэрхийллээс бүрдэж байдаг, эрх зүйн үр дагавар нь энэхүү илэрхийллийн агуулгаас шууд хамаарах үйлдэл, эс үйлдэхүй хэмээн ИХ-ийн §39.1-д тодорхойлжээ.

Хэлцэлд тавигдах агуулгын шаардлагыг дээрх тодорхойлолтыг задлах замаар тогтоох ба үүнийг хэлцлийн объектив, субъектив бүрэлдэхүүн гэнэ.

##### Хүсэл зоригийн илэрхийлэл, түүний бүрэлдэхүүн

Хэлцэл хэмээх ухагдахууныг ярианы хэлэнд олон янзаар ойлгож болдог ч түүний цөмийг бүрдүүлж буй эрх зүйн ойлголт нь тодорхой шалгуур бүхий хүсэл зоригийн илэрхийлэл хэмээх ухагдахуун байдаг. Энэ нь хувь хүний чөлөөт байдлын зарчимд суурилсан бөгөөд аливаа этгээд хүсэл зоригоо чөлөөтэй бүрдүүлэн түүнийгээ сайн дураараа эрх зүйн харилцаанд оруулж, илэрхийлж



буй үйл явцаас бүрдэнэ. Тиймээс **хүсэл зоригийн илэрхийлэл** гэдэгт эрх зүйн үр дагавар гаргахад чиглэсэн хүсэл зоригоо хувь хүн чөлөөтэй илэрхийлэхийг ойлгоно. Дээрхийг хүний бусад хүсэл зоригоос ялгах гол шалгуур нь тодорхой эрх зүйн үр дагаварт чиглэсэн байх явдал юм.

Аливаа хүсэл зоригийн илэрхийллийг субъектив тал буюу хүсэл зориг, объектив тал буюу илэрхийллээс бүрддэг гэж үздэг. Эдгээрийг хүсэл зоригийн илэрхийллийн бүрэлдэхүүн гэнэ. **Улсын Дээд Шүүхээс** гаргасан тайлбарт<sup>15</sup> “хүсэл зориг” гэдэг нь иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох буюу хэлцэл хийх эрмэлзлийг хэлэх бөгөөд уг эрмэлзлийн гадаад илэрлийг “хүсэл зоригийн илэрхийлэл” гэсэн байна.

**а). Объектив тал (Илэрхийлэл):** Хэлцэл нь талуудын хооронд иргэний эрх зүйн харилцаа үүсгэх гол арга хэрэгсэл гэдэг утгаараа түүний объектив бүрэлдэхүүн буюу илэрхийлэлд ихээхэн ач холбогдол өгөх нь чухал. Учир нь хүний хүсэл зориг нь гадагш илэрхийлэгдэж байж л эрх зүйн ач холбогдолтой болдог. Энэхүү илэрхийлэл нь амаар болон бичгээр эсвэл бодит үйлдлээр илэрч болно. Аливаа этгээдийн үйлдлийг хүсэл зоригийн илэрхийлэл гэж үзэх эсэх нь маргаантай бол энд ИХ-ийн §40-ийн дагуу хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлах ажиллагаа хийгдэнэ.

**б). Субъектив тал (Хүсэл зоригийн агуулга):** Гадагш илрэх үйлдлийн агуулга нь эхлээд тухайн этгээдийн ухамсарт эрх зүйн үр дагаварт чиглэсэн хүсэл зориг болон бүрэлдэн тогтсон байх ёстой. Хүний дотор бүрдээд буй хүсэл зоригийг зайлшгүй шаардагдах бүрэлдэхүүн хэсэгт хувааж үзэх ба энэ нь онолын хувьд үйл хөдлөл хийх хүсэл, хүсэл зоригоо гадагш илэрхийлэх хүсэл буюу эрх зүйн ухамсар, мөн тухайн эрх зүйн харилцааг үүсгэх хүсэл гэсэн бүрэлдэхүүн хэсэгт ангилж үзэхэд хүргэдэг.

**аа). Үйл хөдлөл хийх хүсэл:**

Үүнд гадагш чиглэсэн илэрхийллийг үйлдэх ерөнхий хүсэл хамрагдана. Жишээ нь, бичих, хэлэх гэх мэт. Өөрөөр хэлбэл, эл үйлдэл нь илэрхийлэгчийн мэдрэл, сэрэхүйг хамаарсан сайн дурын үйлдэл байх ёстой. Харин давагдашгүй хүчний нөлөөнд эсвэл нойрондоо хийсэн зэрэг хүн ухамсарлалгүй хийдэг, рефлекс үйлдлүүд нь хүний хүсэл зоригоос үл хамаарсан үйл хөдлөл юм. Холбогдох этгээдэд үйл хөдлөл хийх ямар ч хүсэл байгаагүй бол үүнийг хүсэл зоригийн илэрхийлэл гэж үзэхгүй.

**бб). Хүсэл зоригоо илэрхийлэх ухамсар (Илэрхийлэх хүсэл):**

Тодорхой хүсэл зориг илэрхийлэх хүсэл буюу ухамсар гэдэгт холбогдох этгээдэд эрх зүйн ач холбогдол бүхий санал илэрхийлж байна гэсэн төсөөлөл

<sup>15</sup> Улсын Дээд Шүүхийн Тогтоол: ИХ-ийн 5,6,7-р бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, 2010 оны 6-р сарын 22, Дугаар 17.

бий болсон байхыг ойлгоно. Энэхүү ухамсар нь жишээлэхэд баярын захидал бичиж байна гэж бодоод захиалгын хуудаст гарын үсгээ зурах зэрэгт бүрдээгүй байдаг. Мөн дуудлага худалдаан дээр гараа өргөх нь бусдад ямар ойлголт төрүүлж болохыг мэдсэн мөртөө энэхүү гадагш чиглэсэн үйлдлийг хийсэн бол хүсэл зориг илэрхийлж байна гэсэн ухамсар бий гэж үзэх жишээтэй. Сүүлийн тохиолдолд үйлдэл хийсэн этгээд нь хүсэл зоригийн илэрхийллээ хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулж болно.

### **вв). Тухайн хэлцлийг байгуулах хүсэл:**

Илэрхийлэлд тусгасан агуулга нь тодорхой хэлцлийг байгуулах гэсэн бодит хүсэл эрмэлзлээс зөрсөн ч гэсэн эрх зүйн учир холбогдолтой үйлдэл хийж байна гэсэн ухамсар бий л бол хэлцэл хийгдсэн гэж үзнэ. Харин тухайн хэлцэл хийхэд гарсан аливаа эндүүрэл, дутагдлыг төөрөгдөл, хууран мэхлэх, хүч хэрэглэхтэй холбоотой зохицуулалтаар шийднэ.

Тиймээс “тодорхой” хэлцэл хийх гэсэн хүсэл эрмэлзэл, төсөөлөл нь хэлцэл хийх буюу гэрээ байгуулах саналын зайлшгүй шаардагдах элемент хэмээн тооцогдохгүй. Хууль тогтоогч хүсэл зориг бүрэлдэх явцад ийм субъектив доголдол гарсан ч эрх зүйн үр дагавар бүхий хүсэл зоригийн илэрхийлэл бий гэж үзээд, дутагдлыг ИХ-ийн §§58-60-ын дагуу бодит хүслээс зөрсөн хэлцлийг хүчин төгөлдөр бус болгох эрхийг олгосон.

### **Хүсэл зоригийн илэрхийлэл хүчинтэй болох мөч**

Эрх зүйн харилцаанд эсрэг талд заавал хүрсэн байх шаардлагатай хүсэл зоригийн илэрхийллээс хэн нэгэнд хандах шаардлагагүй илэрхийллийг ялгаж үзэх нь зүйтэй. Хэн нэгний эрх ашгийг хөндөх, түүнд нөлөөлөхүйц илэрхийллийг харилцагч этгээд заавал хүлээн авч, энэ тухай мэдсэн байх ёстой гэсэн шаардлагыг ИХ-ийн §40 тавьдаг. Иргэний эрх зүйд бүх гэрээний санал, саналын хариу нөгөө талдаа хүрч, мэдэх боломж нээгдсэнээр хүчинтэй болдог. Харин нэг талын хэлцлүүд өөр хоорондоо илэрхийлэгчийн гадагш чиглэсэн үйлдэл төгсгөвөр болмогц хүчинтэй болдог өөрөөр хэлбэл, хэн нэгэнд хүрэх, мэдэгдэх шаардлагагүй илэрхийлэл, мөн хэн нэгний эрх ашигт нөлөөлөх бол түүнд заавал хүрэх шаардлагатай хэмээн хоёр төрөлд хуваагдана.

### **Бусад этгээдэд хүрэх шаардлагагүй хүсэл зоригийн илэрхийлэл**

Өөр этгээд хүлээн авах шаардлагагүй нэг талт хэлцлийн жишээг дурьдвал гэрээслэл (ИХ-ийн §522), шагнал олгохоор амлах (ИХ-ийн §420), сан байгуулах гэх мэт. Эдгээр гадагш чиглэсэн илэрхийлэл буй болсон мөчөөс эхлэн хүчинтэй болно. Энэ талаар өөр этгээд мэдсэн эсэх нь ач холбогдолгүй.

### **Эсрэг талд заавал хүрэх шаардлагатай хүсэл зоригийн илэрхийлэл**

Эрх зүйн орчинд заавал хэн нэгэнд хүрч байж сая хүчинтэй болдог хүсэл зоригийн илэрхийллийн хувьд ИХ-ийн §40.1 нь эсрэг талд хандсан илэрхийлэл



нөгөө талд хүрч, түүнийг хүлээн авснаар хүчинтэй болно гэдгийг тодотгосон. Тус зохицуулалт нь нэг талаас гарч буй хүсэл зоригийн илэрхийллийн эрх зүйн орчинд буй болох, хүчинтэй гэж үзэх цаг мөчийг тодорхойлж байгаагаараа хүлээн зөвшөөрөх саналаас ялгагдана.

Эсрэг талдаа хүрч байж сая хүчинтэй болдог илэрхийллийг эсрэг талд шууд хандсан эсвэл дамжиж хүрэх хэмээн 2 ангилж болно. Үүнийг судлаач Д.Энхзул “нүүр тулж илэрхийлсэн”, “нүүр тулахгүйгээр илэрхийлсэн” хэмээн ангилсан байна.

### **Дамжиж хүрэх илэрхийллийн онцлог**

Дамжиж хүрэх илэрхийллийн хувьд дамжуулах хэрэгсэл саатсан, доголдсон эрсдлийг хэнд хүлээлгэх нь зүйтэй вэ гэсэн асуулт гардаг. Жишээ нь, бичгээр илгээсэн илэрхийлэл эсрэг тал уншиж, мэдсэн мөчөөс хүчинтэй болох уу эсвэл илгээсэн мөч чухал уу гэдгийг шийдвэрлэх шаардлагатай.

Хүсэл зоригийн илэрхийлэл нь эсрэг талд хүрсэн мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болохоор ИХ-ийн §40.1-д заасан тул илэрхийлэгч этгээд дамжуулах хэрэгслийн эрсдэлийг үүрнэ гэсэн үг. Харин нэгэнт эсрэг талдаа хүрсэн, хүлээн авсан гэж үзэх мөчөөс эхлэн уг илэрхийлэлтэй танилцах эрсдэл хүлээн авагчид шилжинэ. Учир нь хүлээн авагч унших эсэхээс үл хамааран түүнд хүрсэн л бол хуулийн хүчинтэй хүсэл зоригийн илэрхийлэл бий болох юм. Тиймээс энд нөгөө талд хүрэх гэсэн ойлголт ихээхэн ач холбогдолтой болох нь харагдаж байна.

## **Хоёр. Сорилго**

1. Хүсэл зоригийн илэрхийлэл нь:

- a. Хийсэн үеэс хүчин төгөлдөр болно
- b. Нөгөө тал түүнийг хүлээн авснаар хүчин төгөлдөр болно
- c. Нотариатаар гэрчлүүлсэн үеэс хүчин төгөлдөр болно
- d. Зөвхөн бичгээр хийсэн тохиолдолд хүчин төгөлдөр байна

2. Хүсэл зоригийн илэрхийллийг бусад хэлцэлтэй төстэй үйлдлээс хэрхэн ялгах вэ?

- a. Хэлцэл гэдэгт эрх зүйн үр дагавар гаргахад чиглэсэн хүсэл зоригийн илэрхийллийг ойлгох бол хүний ухамсарт үйл хөдлөлөөр нөхцөлдсөн бодит үйлдэл нь эрх зүйн үр дагаварт чиглэдэггүй
- b. Хоёулаа эрх зүйн үр дагаварт чиглэх боловч хэлцэл нь амаар болон бичгэн илэрхийллээр дамжин хүрч, бодит үйлдэл нь хүний ухамсарт үйл хөдлөлөөр нөхцөлдөнө
- c. Дээрх бүгд зөв

3. Хүсэл зоригийн илэрхийллийн бүрэлдэхүүнийг тодорхойл

- a. Чөлөөтэй үйл хөдлөл хийх, хүсэл зоригоо илэрхийлэх ухамсар
- b. Чөлөөтэй үйл хөдлөл хийх, хүсэл зоригоо илэрхийлэх ухамсар, тодорхой гэрээ, хэлцэл хийх хүсэл

4. Эсрэг талд хүрснээр хүчин төгөлдөр болох хүсэл зоригийн илэрхийлэл гэдэгт:

- a. Гэрээг цуцлах мэдэгдэл
- b. Гэрээ байгуулах санал
- c. Гэрээний саналыг хүлээн зөвшөөрөх санал
- d. Гэрээ
- e. Дээрх бүгд зөв
- f. b, c, d хариулт зөв
- g. a, b, c хариулт зөв

## Гурав. Хэрэглэгдэхүүн

### Сурах бичиг, тайлбар толь:

1. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
3. Э.Байгал. Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он
4. ГТХН-ээс эрхлэн гаргасан Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, Улаанбаатар хот 2006 он

### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.

### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
4. Улсын Дээд Шүүхийн тогтоол. ИХ-ийн 5, 6, 7-р бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, 2010 оны 6-р сарын 22, Дугаар 1



### 3.2 : Хэлцлийн ангилал, төрөл зүйл

**Сэдвийн зорилго:** Энэ хичээлээр иргэний эрх зүйн харилцааны үндэс болох хэлцлийн төрөл, зүйлтэй танилцах ба ингэснээр өмчийн болон үүргийн хэлцлийг тусгаарлах зарчмыг баримтлан ИХ-ийн холбогдох зохицуулалтыг зөв сонгон тохиолдол шийдэх аргачлалд суралцана.

#### Нэг. Тойм лекц

##### **Оролцогчийн тоогоор ангилах нь**

Хэлцэл нь зарим тохиолдолд цорын ганц хүсэл зоригийн илэрхийллээс бүрдэх ба үүнийг **нэг талын хэлцэл** гэнэ. Жишээ нь, хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг цуцлах илэрхийлэл нь нэг талын хэлцэл юм. Харин **гэрээ** нь дор хаяхад хоёр талын, заримдаа түүнээс олон талын хүсэл зоригийн нэгдэл байдаг. Тиймээс түүнийг оролцогсдын тоогоор нь хоёр ба олон талын хэлцэл гэж нэрлэх нь зүйтэй.

##### **Эрх зүйн үр дагавраар ангилах нь**

Хэлцлийг шууд гарах үр нөлөөгөөр нь үүргийн ба өмчийн эрх зүйн шинжтэй хэлцэл хэмээн ангилж болно:

##### **Захиран зарцуулах буюу өмчийн хэлцэл**

Захиран зарцуулах хэлцлийн үндсэн дээр оршин тогтнож буй эрхийг шилжүүлэх, өөрчлөх үйл явц өрнөдөг тул үүнийг өмчийн эрх зүйн шинжтэй хэлцэл гэнэ. Захиран зарцуулах хэлцэл гэдэгт юуны өмнө хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх үед бий болж буй зөвшилцөл, тэдгээрийг барьцаалах тухай хүсэл зоригийн илэрхийлэл багтана. Түүнчлэн нэгэнт үүсээд буй өмчийн эрхийн агуулгыг өөрчлөх үйлдэл тухайлбал серветутын зүйлийн ашиглалтыг өөрчлөн тодорхойлох эсвэл ипотекийн барьцааг талууд тохиролцон хасуулах зэрэг нь дээрхэд хамаарна.

**Захиран зарцуулах** үйлдэл нь нэгэнт бий болоод байгаа эрхийг шилжүүлэх, агуулгыг нь өөрчлөх, хязгаарлах, үгүй болгох замаар түүнд нөлөөлж байдаг тул эрх зүйн үр дагаварт чиглэсэн эрхийн эзний хүсэл зоригийн илэрхийлэл буюу **хэлцэл** мөн.

##### **Үүргийн хэлцэл буюу суурь хэлцэл**

Аливаа гэрээг байгуулснаар холбогдох эд зүйлийн харьяалал шууд өөрчлөгдөхгүй, гагцхүү тэдгээрийг харилцан солилцох үүрэг үүсэх тул үүнийг үүрэг үүсгэх буюу *үүргийн хэлцэл* гэнэ. Гэрээг байгуулсны дараа талууд өмчлөх эрхийг шилжүүлэх үйлдлийг хийж гүйцэтгэх ба үүнийг хууль тогтоогч үүнийг гэрээний эрх зүйн зохицуулалтад бус, харин өмчийн эрх зүйд тусад нь

зохицуулсан байна. Тиймээс үүргийн хэлцэл нь захиран зарцуулах хэлцэлтэй харьцуулахад эд юмсын эрхийг бие даан өөрчлөхгүй, гагцхүү ийнхүү өөрчлөх үүргийг талуудад ноогдуулж байдаг.

**Үүргийн хэлцэл** гэдэгт үүргийн харилцаа үүсгэхэд чиглэсэн бүх хэлцлийг ойлгох ба тухайлбал үүрэг үүсгэх хэлцэл нь нэг талын үйлдэл, эс үйлдэхүйд чиглэсэн шаардах эрхийг нөгөө этгээдийн эсрэг үндэслэж байдаг. ИХ-ийн §186.1-д хууль тогтоогч нэг этгээд нөгөөгийнхөө өмнө тодорхой үйлдэл хийх эсвэл аливаа үйлдлийг хийхгүй байх үүрэг хүлээснийг үүргийн харилцаа, энэхүү үүрэгтэй холбогдуулан эсрэг талд үүсч буй субъектив боломжийг шаардах эрх хэмээн тодорхойлжээ. Үүргийн хэлцэл нь ихэнх захиран зарцуулах хэлцлийн суурь болж байдаг.

### **Тусгаарлах зарчмын ач холбогдол**

Ийнхүү үүргийн болон өмчийн хэлцлийг тусгаарлаж үзэх явдал нь эдгээрийг тус тусад нь хуульчилсантай холбоотой бөгөөд үүнээс үүдээд Монгол Улсын иргэний эрх зүйд **хийсвэрлэх зарчим** үйлчлэнэ гэсэн системийн тайлбар хийх боломжтой<sup>16</sup>.

### **Болзол тавьж хийсэн хэлцэл**

Аливаа хэлцлийн эрх зүйн үр дагаврыг ирээдүйд болох, тодорхой бус үйл явдлаас хамааруулсан бол үүнийг болзол тавьж хийсэн хэлцэл гэнэ. Болзол хэмээх ухагдахуун нь ИХ-ийн §44.1-д хэлцлийн шинж чанарыг тодорхойлох тодотгол маягаар, харин ИХ-ийн §44.2 ба 3-т ирээдүйд болох үйл явдлыг илэрхийлж байгааг харж болно. Энэ зүйлд хууль тогтоогч зөвхөн хэлцлийн үндсэн дээр тохиролцооны зүйл болж буй болзлыг тодорхойлсон ба үүнд хуулиар тавигдах болзол үл хамаарна. Хуулиар тавигдах болзол гэдэгт тухайн хэлцлийг хүчинтэй болоход зайлшгүй тавигдах, аливаа эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан шаардлагыг ойлгоно. Дээрхээс харахад хэл зүйн утгаараа болзол хэмээх ойлголтод багтах тохиролцоо бүр ИХ-ийн §44.1-д заасан болзол хэмээх ухагдахуунд хамрагдахгүй. Ихэнхдээ эдгээрийг ирээдүйн тодорхой бус үйл явдал хэмээн дүгнэх боломжгүй байдаг. Жишээлбэл, нийлүүлэлтийн болон төлбөр хийх нөхцөлүүд, стандарт нөхцөл нь тодорхой бий болж болзошгүй тохиолдолд гарах үр дагаврыг агуулсан болзолт тохироо бөгөөд ИХ-ийн §44.1-д заасан болзол биш байна.

Тиймээс энэ зүйлийн урьдчилсан нөхцөл болох ирээдүйд бий болох, тодорхой бус үйл явдал гэдгийг хэрхэн тайлбарлах тухай авч үзэх нь зүйтэй. Юуны өмнө тодорхой бус үйл явдалд зайлшгүй бий болох нөхцөлүүд хамрагдахгүй. Тухайлбал, ирээдүйд товлосон үйл явдал болох нь зайлшгүй, харин уг үйл явдал хэзээ болох нь тодорхойгүй байвал болзол тавьсан бус, харин “хугацаа заасан хэлцэл” болно. Мөн хуулинд заасан болзол хэмээх ойлголт нь өнгөрсөн, одоогийн

<sup>16</sup> Д.Энхзул: Хамтын бүтээл, Иргэний эрх зүйн ерөнхий анги, УБ хот 2010 он, 46 дахь тал.



бус гагцхүү ирээдүйд бий болох үйл явдал байх ёстой. Тиймээс хууль тогтоогч ИХ-ийн §44.2-т тусгайлан “нэгэнт бий болсныг нь хэлцэл хийгч талууд мэдээгүй байгаа үйл явдал” мөн эдгээр зохицуулалтад хамрагдахаар зохицуулсан байна.

### **Болзол тавьж хэлцэл хийх хориотой тохиолдол**

Хэдийгээр өмчийн болон үүргийн хэлцлийн аль алинд нь хугацаа зааж, болзол тавих боломжтой ч зарим тохиолдолд үүнийг хуулиар хориглосон байдаг. Тухайлбал, хууль тогтоогч нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэр бүлийн эрх зүйн хүрээнд болзол тавьж хэлцэл хийхийг хатуу хоригложээ. Үүнээс гадна үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тухай өмчийн тохиролцоо нь мөн чанарын хувьд болзол тавьсан байх бололцоогүй. Учир нь үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэл энэ тохиолдолд эрх зүйн тодорхой байдлыг хангахад чиглэж байхад, энэхүү хэлцэлд хугацаа зааж, болзол тавих нь тодорхойгүй байдал үүсгэх юм. Тиймээс тодорхой хугацааны турш гэр бүл болох эсвэл мөнгө төлж дууссанаар үл хөдлөх хөрөнгийн өмчлөл шилжих тухай хэлцэл нь хүчингүй байна.

### **Болзлын хэлбэр, төрөл, ангилал:**

**а). Хойшлуулах болзол.** ИХ-ийн §44.2-т заасны дагуу бий болох эсэх нь мэдэгдэхгүй эсвэл бий болсныг нь талууд мэдээгүй байгаа үйл явдлаас шалтгаалан хэлцэлд заасан эрх, үүрэг үүсэхээр тохиролцсон бол түүнийг хойшлуулах болзлоор хийсэн хэлцэл гэнэ (супенсив болзол). Энэхүү үйл явдал бий болохоос өмнө хэлцлийн хувьд хүчинтэй эсэх нь тодорхой бус нөхцөл байдал үүсэх ба уг үйл явдалтай зэрэгцэн хэлцлийн үр дагавар бий болно.

**б). Өөрчлөгдөх болзол.** Мөн ирээдүйд бий болох эсэх нь тодорхойгүй үйл явдлаас хамааран талууд хэлцлийг дуусгавар болгохоор тохирсон бол өөрчлөгдөх болзлоор хийсэн хэлцэл гэнэ. Энэ нөхцөлд хэлцэл хийсэн даруйд хүчин төгөлдөр болох боловч тус үйл явдал бий болмогц дуусгавар болно.

### **Зөвшөөрөл шаардагдах хэлцэл:**

Ердийн гэрээ, хэлцэл нь байгуулсан цагаасаа эхлэн хүчин төгөлдөр болдог. Гэсэн ч хууль тогтоогч нилээд олон гэрээ, хэлцлийн хүчинтэй байх эсэхийг тодорхой этгээдүүдийн зөвшөөрөх эсэхээс хамаарахаар заасан. Энэ нь юуны өмнө тухайн үйлдэл хийж буй этгээдийг өөрийг нь хамгаалах зорилготой.

Тухайлбал, насанд хүрээгүй этгээдүүд болон сэтгэцийн эмгэгийн улмаас эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан этгээдүүдийн өмнөөс тэдний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хэлцэл хийх ба ингэснээр дээрх этгээдүүдийг өөрийн ашиг сонирхолд харш хэлцэл хийхээс сэрэмжилж байгаа билээ (**Асран хамгаалах чиг үүрэгтэй холбоотой зөвшөөрөл**).

Нөгөөтэйгүүр тухайн хэлцлийн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөж буй гуравдагч этгээдийг хамгаалах зорилгоор хуульд түүний зөвшөөрлийг шаардлагатай хэмээн тусгасан тохиолдол бий (**Эрх ашиг хөндөгдсөнтэй**

**холбоотой зөвшөөрөл**). Тухайлбал дундаа хамтран өмчлөх аливаа эд зүйлийг нэг өмчлөгч нь бусдад худалдах бол нөгөөгөөс зөвшөөрөл авсан байх ёстой.

Ийнхүү хүчин төгөлдөр болохын тулд гуравдагч этгээдийн зөвшөөрөл шаардагдах хэлцлийг **зөвшөөрлөөр хийх хэлцэл** гэнэ, ИХ-ийн §50.1. Зөвшөөрөл зайлшгүй шаардагдах тухай Иргэний хуульд тодорхой заасан байх ёстой. Зөвшөөрөл олгох этгээд нь зөвхөн хувь этгээд байна. Өөрөөр хэлбэл, хувь хүн болон иргэний эрх зүйн салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн зөвшөөрлөөр хийх хэлцлийг Иргэний хуульд зохицуулсан байх ба энд нийтийн эрх зүйн субъектийн зүгээс олгох зөвшөөрөл хамрагдахгүй. Гэхдээ төрийн байгууллагын зөвшөөрлийн хувьд ИХ-ийн §§50- 53 дахь зохицуулалтыг төсөөтэй хэрэглэж болно.

### **Зөвшөөрөл – ухагдахуун, ангилал**

Зөвшөөрлийг ИХ-ийн §51.1-д дурьдсанаар цаг хугацааны хувьд хийх гэж буй хэлцлийн өмнө илэрхийлсэн бол урьдчилан олгосон, мөн ИХ-ийн §53-т заасан хожим олгосон зөвшөөрөл хэмээн 2 төрөлд ангилан авч үзнэ.

Зөвшөөрөл нь аливаа хэлцлийг хүчин төгөлдөр байх эсэхэд нөлөөлдгөөрөө эрх зүйн хувьд ач холбогдол бүхий хүсэл зоригийн илэрхийлэл юм (ИХ-ийн §39). Тиймээс энд **нэг талт хэлцэлд** хамаарах бүхий л зүйл заалт үйлчлэх бөгөөд зөвшөөрөл олгогч этгээд иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх ёстой. Зөвшөөрөл нь нөгөө талын эрх ашгийг хөндөж байгаа тул эсрэг талд хүрсний үндсэн дээр өөрөөр хэлбэл, түүнд мэдэгдсэнээр хүчинтэй болно, ИХ-ийн §40.1. Харин зөвшөөрөл олгосон эсвэл татгалзсан тухайгаа хэлцлийн талуудын алинд нь ч мэдэгдэж “болохыг” ИХ-ийн §50.1-д аль алинд нь мэдэгдэх “үүрэгтэй” мэт заасан нь онолын хувьд хачирхалтай шийдэл юм.

### **Урьдчилан олгосон зөвшөөрөл**

Зарим хэлцэл хоёр талтай бус, харин нэг талын хүсэл зоригоор хийгдэх тал бий. Энэ нөхцөлд холбогдох этгээд зөвхөн урьдчилан зөвшөөрөл олгосон бол хэлцэл хүчинтэй болно.

Жишээ нь, ИХ-ийн §55.2-ын дагуу хуулиар зөвшөөрснөөс бусад өөрөөр хэлбэл, ИХ-ийн §16.3-т зааснаас бусад нэг талт хэлцлийг зөвхөн урьдчилан олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ. Энд тухайн нэг талт хэлцлийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдэд эсрэг талын гэрээ цуцалсан, гэрээнээс татгалзсан эсвэл үүнийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулсан илэрхийлэл хүчинтэй эсэх нь тодорхой биш нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх үүднээс ийнхүү хожим зөвшөөрөл олгох явдлыг хязгаарласан байна.

Хоёр талт хэлцлийн хувьд нэг тал нь зөвшөөрөл олгох хүртэл өөрийн хүсэл зоригоос татгалзах, буцах зэрэг хэлцэлд нөлөөлөх боломжтойн дээр анхнаасаа зөвшөөрөл шаардагдах хэлцлийг хийхгүй байх сонголт бий тул нэг талын эрх ашгийг илүүтэйгээр хамгаалах шаардлагагүй. Иймээс ИХ-ийн §53-д хожим



зөвшөөрөл олгогдсоноор гэрээ, хэлцэл хүчинтэй болох боломжийг олгосон.

### **Хожим олгох зөвшөөрөл**

Зөвшөөрөлгүй хэлцэл хийсэн этгээдийн үйлдлийг холбогдох этгээд хожим дэмжин зөвшөөрсөн бол энэ хэлцэл хийсэн цаг мөчөөсөө эхлэн хүчин төгөлдөрт тооцогдоно, ИХ-ийн §53. Үүнийг эрх зүйн шинжлэх ухаанд **ex – tunc** байдлаар буюу хэлцэл хийсэн үеэс хүчин төгөлдөр болгох арга хэмээн нэрлэх бөгөөд энэ замыг сонгосноор хууль тогтоогч шаардагдах зөвшөөрөл нэгэнт олгогдсон бол анхнаасаа зөвшөөрөл дутагдалтай байгаагүй мэт эрх зүйн харилцааг үргэлжлүүлэхийг зорьсон байна. Зөвшөөрөл ийнхүү олгосон цаг мөчид бус өнгөрсөн үед очиж нөлөөлөх нь тусгайлсан хуулийн зохицуулалт, ялангуяа зөвшөөрөл шаардагдах хэлцлийн хувьд хориглогдоогүй байх ёстой. Түүнчлэн зөвшөөрөл хэзээ, хэрхэн нөлөөлөх тухай талууд шийдэж болно.

### **Биржийн хэлцэл**

Биржийн хэлцэл нь хөрөнгийн бирж дэх мэргэшсэн оролцогчдын дунд хийгдэж буй хэлцэл багтах ба энэ нь ердийн хэлцлээс хүчин төгөлдөр болох шалгуураараа ялгагдана. Үүнийг тусгай хууль тогтоомжоор зохицуулна.

### **Хоёр. Хяналтын асуулт:**

- Хэлцлийн төрөл тус бүрийг жишээн дээр тайлбарлана уу
- Өгөгдсөн тохиолдлоос хэлцэлд тавигдах ямар шаардлага зөрчигдөж байгааг олж тайлбарлана уу
- Хүчин төгөлдөр бус хэлцэл, бус гэж тооцож болох хэлцлүүдийн ялгагдах гол шинжүүдийг гаргана уу

### **Гурав. Сорилго:**

1. Хэлцлийг оролцогч талуудын тоогоор хэрхэн ангилах вэ?

- а. Нэг талт, хоёр ба олон талын хэлцэл
- б. Нэг талын хэлцэл, гэрээ
- в. Дээрх бүгд зөв

2. Хэлцлийг иргэний эрх зүйн хамаарах бүл, эрх зүйн үр дагавраар нь хэрхэн ангилах вэ?

- а. Болзол заасан
- б. Зөвшөөрөл шаардах
- в. Нэг ба олон талын
- д. Үүргийн ба өмчийн эрх зүйн

### 3. Үүргийн ба өмчийн хэлцлийн ялгаа

- a. Үүргийн хэлцэл гэдэгт аливаа этгээдийн өмнө тодорхой гүйцэтгэл явуулахад чиглэсэн хүсэл зоригийн илэрхийлэл, өмчийн хэлцлийн дүнд эрх өөрчлөх үр дагавар гарна
- b. Үүргийн хэлцэл нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогсдын хооронд тодорхой үүрэг үүсгэхэд чиглэх бол өмчийн хэлцэл нь эд зүйл, хувь этгээдийн харилцааг өөрлөхөд чиглэнэ
- c. Дээрх бүгд зөв

### Дөрөв. Хэрэглэгдэхүүн

#### Сурах бичиг, тайлбар толь:

1. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
2. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
3. Э.Байгал: Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он
4. ГТХН-ээс эрхлэн гаргасан Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, Улаанбаатар хот 2006 он

#### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Д. Энхзул: Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.
2. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
3. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.

#### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Улсын Дээд Шүүхийн тогтоол: ИХ-ийн 5,6,7-р бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, 2010 оны 6-р сарын 22, Дугаар 1
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.




### Сэдэв 3.3.: Хүчин төгөлдөр бус хэлцэл, түүний үр дагавар


**Сэдвийн зорилго:** Хүчин төгөлдөр бус хэлцэл болон тэдгээрийн үр дагаврын талаар онолын тодорхой мэдлэг олж авах, хүчин төгөлдөр бус байх, хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцлүүдийн үндсэн шинжүүдийг танин мэдэж, зөв зүйлчлэх, хууль хэрэглэх чадвар, дадалтай болоход оршино.

#### Нэг. Лекц

ИХ-ийн §§56-59-д хууль тогтоогч тодорхой нөхцөл байдлын улмаас хэлцэл хүчингүй гэж үзэх үндэслэлүүдийг тусгасан. ИХ-ийн §56-д хууль тогтоогч хэлцэл ямар ч нөхцөлд хүчингүй байх нөхцөл байдлыг тусгасан бол ИХ-ийн §§57-60-д хамгаалагдаж буй этгээд төөрөгдсөн, хууран мэхлэгдсэн зэрэг зүй бус нөлөөллийн талаар олж мэдсэний дараа хэлцлийг хүчингүйд тооцуулах эсэхээ өөрөө шийдэх эрхтэй байхаар тусгасан. Ийнхүү хэлцэл хүчингүй байх үндэслэлүүдийг 2 бүл болгон ангилж үзсэнийг толилуулбал:



Эдгээрийг хуулийн техник, хэрэглээний үүднээс 1/. хүсэл зоригийн субъектив тал доголдсонтой холбоотой; 2/. бусад объектив хүчин зүйлстэй холбоотой үндэслэлүүд хэмээн ангилна. Доорх ангиллыг баримтлан хэлцлийн агуулгыг шалгах ажил хийгдэх ба хүсэл зоригийн бүрэлдэхүүний холбогдох хэсэгт илэрсэн хэлцэл хүчингүй байх үндэслэлийг байршуулна.



Эдгээрээс ИХ-ийн §§56.1.2, 56.1.3 болон ИХ-ийн §56.1.4-т заасан тохиолдлуудыг хүсэл зоригийн дутагдал буюу **санаатай**гаар хэлцлийн субъектив тал доголдуулсан, ИХ-ийн §58 нь хүсэл зоригийн дутагдлыг **санаандгүй** үүсгэх тохиолдлыг, мөн ИХ-ийн §§59, 60-д хууль бус, санаатай нөлөөллийн улмаас хүсэл зориг бүрэлдэн тогтох явцад нөлөөлж буй үзэгдлийг тус тус зохицуулсан. Харин ИХ-ийн §§56.1.1, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10 нь хүний хүсэл зоригоос ангид объектив хүчин зүйлсийн улмаас хэлцэл хүчингүй гэж үзэх үндэслэлийг зохицуулжээ.

## Дүр үзүүлэн хийсэн хэлцэл

Хүсэл зоригоо илэрхийлж буй этгээд нь бодит байдал дээр уг илэрхийллийн үр дагаврыг хүсээгүй байсан ч хүлээн авч буй этгээдийн хувьд бүрэн дүүрэн илэрхийлэл мэт санагдах нь элбэг. Ийм нөхцөлд холбогдох этгээд хэлцлийн гадагш чиглэсэн хүчин зүйл болох илэрхийллийг харилцагчдаа хүргэх



ухамсар байдаг ч уг илэрхийллээс үүдэх эрх зүйн үр дагаврыг үүрэх хүсэл сонирхол байдаггүй. ИХ-ийн §56.1.2 нь ИХ-ийн §56.1.4-тэй харьцуулахад санаа зорилготойгоор бодит бус илэрхийллийг эрх зүйн орчинд бий болгож байдгаараа ихээхэн ноцтой үйлдэл хэмээн тооцогддог.

Хүсэл зоригийн илэрхийллийг хүлээн авч буй тал холбогдох этгээд уг үр дагаврыг хүсэхгүй байгааг олж мэдсэн бол түүнийг хамгаалах шаардлагагүй бөгөөд энэ нөхцөлд хэлцэл ИХ-ийн §56.1.2-ын дагуу хүчингүй болно. ИХ-ийн §56.1.2 нь илэрхийллийн бодит бус гэдгийг нөгөө тал төвөггүй нягталж, мэдэх боломжтой байсан нөхцөлд хэлцлийг хүчингүй гэж үзэх үндэслэлийг тусгасан. Харин дээрх нөхцөл байдал өөрөө ил болоогүй, далд байсан бол илэрхийлэл хүчинтэй хэвээр үлдэнэ.

### **Халхавчилсан хэлцэл**

Хүсэл зоригоо илэрхийлэгч талууд харилцан тохирсоны үндсэн дээр бодит байдлаас өөр хэлцлийг хүчинтэй мэт дүр эсгэн хийж буй бол үүнийг халхавчилсан хэлцэл гэх ба ийм хэлцэл ИХ-ийн §56.1.3-ын дагуу хүчингүй. Энэ тохиолдолд хүсэл зоригийн бүрэлдэхүүнийг аваад үзвэл талууд тухайн хэлцлийн эрх зүйн үр дагаврыг үүрэх хүсэлгүй байдаг. Ийнхүү талууд харилцан зөвшилцөж, хэлцлийн бодит бус гэдэг дээр санал нэгдсэн бол энд хамгаалбал зохих итгэх үнэмшил бүрэлдэхгүй. Энэхүү зөвшилцөл нь ИХ-ийн §56.1.3-ыг бусад ИХ-ийн §56.1.2 ба 1.4-т тусгасан үндэслэлээр ялгах гол онцлог юм.

Гэрээний аль нэг тал үнэн байдлыг ойлгоогүйн улмаас халхавчилсан хэлцэл хийгдээгүй бол халхавчилсан хэлцэл хийх санаа зорилго агуулж байсан талын хүсэл зоригийн илэрхийлэл ИХ-ийн §56.1.3 бус, гагцхүү ИХ-ийн §56.1.4-ийн дагуу хүчингүй болно. Хүсэл зоригийн илэрхийлэл хүчингүй нь тогтоогдсон бол эсрэг тал ИХ-ийн §56.6-ийн дагуу хохирлоо нэхэмжлэх эрхтэй.

Халхавчилсан хэлцлийн ард нуугдаж буй талуудын бодитоор хүссэн эрх зүйн үр дагавар бүхий тохиролцоог *халхавчлагдсан хэлцэл* гэнэ. Халхавчлагдсан хэлцэл хүчингүй байх тухай ИХ-ийн §56-д тусгаагүй ч энэ хэлцлийг бусад хуулийн шаардлагад нийцэж буй эсэхээр нь дүгнэнэ. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө худалдах тухай талуудын бодит тохиролцоо нь ИХ-ийн §109.2-т заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй шалтгаанаар ИХ-ийн §56.1.8-ын дагуу хүчингүй байна.

### **Үнэн санаанаасаа бус хийсэн хэлцэл**

Аливаа этгээд илэрхийлсэн хүсэл зоригийнхоо үр дагаврыг хүсэхгүй байхаас гадна энэ талаар харилцагч тал мэдэх боломжгүй гэдгийг ухамсарлаж байсан бол хэлцэл ИХ-ийн §56.1.2-ын дагуу хүчингүй. ИХ-ийн §56.1.4 нь дээрхтэй харьцуулахад хуурч мэхлэх гэсэн сэдэлтгүй, холбогдох этгээд илэрхийллийнхээ бодит бус болох нь ил байгаа, илрэнэ гэж найдсан байдаг.

Хэрэв харилцагч тал энэхүү хүсэл зоригийн илэрхийлэл илэрхийлэгчийн бодит хүсэлтэй нийцэхгүй байна гэдгийг ойлгоогүй бол ИХ-ийн §56.6-ийн дагуу хохирол арилгуулахаар шаардах эрхтэй. Илэрхийлэгч тал нь эсрэг тал хэлцлийг бодит хэмээн итгэж буйг мэдсэн бол түүнд тэр даруй үнэн мэдээллийг өгөх үүрэгтэй. Ингээгүй этгээд идэрхийллээ хожим ИХ-ийн §56.1.4-ийн дагуу хүчингүйд тооцуулах нь шударга ёсонд үл нийцнэ.

### Хоёр. Хяналтын асуулт

1. ИХ-ийн ерөнхий ангид тусгагдсан хэлбэрийн шаардлагыг хөнгөнөөс хүнд рүү нь хэрхэн ангилбал зохих вэ? Агуулгын хувьд эдгээр хэлбэрт тавигдах шаардлагыг нэрлэнэ үү.
2. Хүсэл зориг илэрхийлэлд холбогдох ухамсар дутмаг байх гэдэгт юуг ойлгох вэ? Энд ямар эрх зүйн үр дагавар үүсэх вэ?
3. Дүр үзүүлэн хийсэн хэлцэл үнэн санаанаасаа бус хөнгөмсгөөр найдаж хийсэн хэлцлээс юугаараа ялгаатай вэ?
4. Халхавчлагдсан хэлцэл хүчинтэй байх тохиолдлыг дурьдана уу.

### Гурав. Сорилго

1. Хүсэл зориг илэрхийлэгч этгээд илэрхийллийн агуулгыг бодитоор хүсээгүй ч санаатайгаар уг илэрхийллийг бусдад хүргэсэн бол үүнийг хүчинтэй гэж үзэх боломжтой юу?

- a. Үргэлж хүчинтэйд тооцно. Учир нь илэрхийлэл эсрэг талд хүрснээр хүчинтэй болж, хүлээн авагчийг хамгаалах нь зүйтэй нөхцөл байдал үүснэ
- b. Боломжтой. Гэхдээ хуулинд дүр үзүүлэн хийсэн хэлцэл, үнэн санаанаасаа бус хийсэн хэлцэл, халхавчилсан хэлцлийг хүчингүйд тооцохоор заасан
- c. Дээрх бүгд зөв

2. Т найз нөхдийн хүрээнд чинээлэг харагдахыг хичээж алтан цагаа тайлан найз Н-дээ бэлэглэжээ. Гэхдээ тэрээр Н дээрх байдлыг ойлгож байгаа хэмээн бодож, бэлгийг буцаан өгөх байх гэж найдаж байлаа. Харин Н энэ талаар сонсохыг ч хүсээгүй бол хэрхэх вэ?

- a. хүсэл зоригийн илэрхийлэл хүчинтэй
- b. хэлцэл хүчингүй

2. Түрээсийн гэрээний хөлслөгч тал нэгэн ил захидалд балын харандаагаар гэрээг цуцлах тухайгаа бичиж гарын үсэг зуран хөлслүүлэгчид илгээсэн бол энэ нь бичгийн хэлбэрийн шаардлагад нийцэж байна уу?

- a. Гарын үсэг зурсан бол хангалттай
- b. Үгүй, ил захидал тул хүсэл зоригийн илэрхийлэл болохгүй
- c. Гэрээг цуцлахад хэлбэрийн шаардлага хамаарахгүй



## Дөрөв. Хэрэглэгдэхүүн

### Сурах бичиг, тайлбар толь:

1. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
3. Э.Байгал. Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он
4. ГТХН-ээс эрхлэн гаргасан Иргэний хуулийн тайлбар толь. Ерөнхий анги, Улаанбаатар хот 2006 он

### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.

### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он

### Сэдэв 3.4.: Хүчин төгөлдөр бус хэлцэл, түүний үр дагавар

**Сэдвийн зорилго.** Энэ хичээлээр хэлцэл хүчин төгөлдөр эсэхийг практик тохиолдол дээр тодорхойлох дасгал хийх ба ингэснээр өгсөн, авсанаа буцаах эрхийг зүй зохистой хэрэгжүүлж сурах дадал хэвшүүлнэ.

#### Нэг. Тойм лекц

Хэлцэл хийгч этгээд хүсэл зоригоо илэрхийлэхдээ ямар нэг алдаа гаргасан бол үүнийг эрх зүйн үүднээс янз бүрээр дүгнэх боломжтой. Тодорхой тохиолдолд тухайлбал, Иргэний хуулийн §56-д тусгасан нөхцөл байдал илэрвэл уг хэлцлийг хууль тогтоогч хүчингүй байхаар зохицуулжээ. Тэгэхээр тухайн хэлцэл нь анхнаасаа ямар нэг эрх зүйн үр дагавар үүсгэхгүй гэсэн үг. Жишээлбэл, хуульд заасан хэлбэрийн шаардлагыг баримтлаагүй (ИХ-ийн §56.1.8), дүр үзүүлэн хийсэн хэлцэл (ИХ-ийн §56.1.3) зэрэг нь хийсэн үеэс хүчингүй байна.

#### Хууль зөрчсөн хэлцэл

ИХ-ийн §56.1.1-ийн дагуу хууль зөрчиж буй хэлцэл нь хүчин төгөлдөр бус байна. Үүнд бүх хууль тогтоомжийн актыг хамруулан үзэх эсэх нь маргаантай. Ямартай ч хэлцлийг хүчингүй гэж үзэхийн тулд агуулгын хувьд хорио тогтоосон хуульд нийцэхгүй байж, энэхүү хуулийн зохицуулалтыг зөрчих нь хэлцлийг хүчин төгөлдөр бус байх үр дагаврыг бий болгох зорилго агуулсан байх ёстой<sup>17</sup>. Ингэхдээ холбогдох хуулийн хэм хэмжээг утга агуулга, зорилгын дагуу тайлбарлах нь зүйтэй. Ихэнх хуулийн зохицуулалт “хориглоно” “болохгүй” гэх мэт нэр томъёонууд агуулаагүй боловч, утгын хувьд түүнд агуулагдаж буй “зөвшөөрөхгүй”, “шилжүүлэх боломжгүй” гэх мэт томъёоллууд тодорхой хэлцэл хийхийг хориглож байгаагийн жишээ билээ<sup>18</sup>. Гэсэн ч эдгээр хэм хэмжээг зөрчсөн хэлцэл болгон хүчин төгөлдөр бус байхгүй.

Зарим хууль тогтоомжид агуулагдаж буй хэм хэмжээ нь хэлцэл хийх арга замыг хориглосон байдаг. Улмаар хэлцэл хийсний үр дүнд бий болох үр дагаврыг хориглоход чиглэгдээгүй. Ийм хорио тогтоосон хэм хэмжээг зөрчин хийсэн хэлцэл нь хууль зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус болох үндэслэл болохгүй. Зарим нэг хориглосон хэм хэмжээ нь хэлцлийн агуулгаас шалтгаалан тухайн хэлцлийг хийхийг хориглодог. Агуулгын хувьд хориглосон хэм хэмжээг зөрчин хийсэн хэлцлүүд хүчин төгөлдөр бус байх бөгөөд эрх зүйн үр дагаврыг үүсгэхгүй.

<sup>17</sup> Б.Тэмүүлэн: Хамтын бүтээл – Иргэний эрх зүй /Ерөнхий анги, 2010 он, 98 дахь тал.

<sup>18</sup> Б.Тэмүүлэн: Хамтын бүтээл – Иргэний эрх зүй /Ерөнхий анги, 2010 он, 99 дэх тал.



### **Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш хэлцэл**

ИХ-ийн §56.1.1-ийн дагуу хууль зөрчихөөс гадна зан суртахууны хэм хэмжээ зөрчиж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна. Үүнд хүний зөв зүйтэй гэж үзсэн бүхий л ёс суртахууны хэмжээ багтах боловч гол шалгуур нь Иргэний Хуулийн үйлчлэлийн хүрээнд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Нийт гэдэг нь өргөн утгаараа улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамрана, явцуу утгаараа холбогдох этгээдийн харъяалал бүхий нутаг дэвсгэрийн нэгж гэж хоёр аргаар тайлбарлах боломжтой. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, нийгмийн зан суртахуун<sup>19</sup> нь зан суртахууны хэм хэмжээ бүрэлдэх үндэс болдог бол үүнд нийтээр болон тодорхой бүлэглэлийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн ёс зүйн үзэл баримтлал, үзэл бодол гол үүрэгтэй<sup>20</sup>. Хэлцэл хийж буй этгээд түүний үйлдэл зан суртахууны хэм хэмжээнд харш гэдгийг мэдэж байх ёстой. Энэ талаар дүгнэхэд хэлцэл хийсэн цаг хугацаа ач холбогдолтой тул хэлцэл хийгдсэний дараа нийгмийн суртахууны үзэл бодол өөрчлөгдөх нь хэлцлийг хүчин төгөлдөр болгохгүй.

### **Хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцэл**

ИХ-ийн §56.1.8-д хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй хэлцэл хүчингүй болохыг, мөн ИХ-ийн §42-т аман болон бичгийн, нотариатаар гэрчлүүлбэл зохих эсвэл улсын бүртгэл гэсэн хэлбэрийн шаардлагыг тоочсон зохицуулалт тусгагдсан. Эдгээрийг хэлбэрийн шаардлагын агуулга, эрх зүйн үр дагаврыг тодотгоход чиглэсэн зохицуулалт бол жинхэнэ хэлбэрийн шаардлагыг тусгай зохицуулалтаар хуульд тусгана.

Хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй хэлцэл нь хийсэн үеэсээ ИХ-ийн §56.1.8-ын дагуу хүчингүй. Түүнчлэн хуульд заасан хэлбэрээр хийвэл зохих хэлцлийн бусад нөхцөл, нэмэлт өөрчлөлт зэргийг заавал энэ хэлбэрээр хийж гүйцэтгэнэ. Харин аливаа гэрээг харилцан дуусгавар болгох хэлцэл хуульд зааснаас бусад тохиолдолд хэлбэрийн шаардлагад хамаарахгүй.

### **Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн хэлцэл**

Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэл хэлцэл хийсэн үеэс хүчингүй байна, ИХ-ийн §56.1.5. Энэ зохицуулалт нь шууд утгаараа ИХ-ийн §18.1 болон ИХ-ийн §18.2-т заасан хоёр тохиолдлыг, мөн ИХ-ийн §19.1-д хамаарах тохиолдлыг тус тус хамрах бол үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгохгүй, түр зуурын болон үргэлжийн сэтгэцийн сааталд орсон этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэл ИХ-ийн §56.1.6 болон ИХ-ийн §56.1.7-д зааснаар хүчингүй юм. Иргэний эрх зүйн бүрэн бус, хязгаарлагдмал эсвэл зарим чадамжтай этгээдүүдийн хийсэн хэлцэл ИХ-ийн §16-17-д тусгагдсанаас бусад тохиолдолд ИХ-ийн §56.1.5-ын дагуу хүчингүй.

<sup>19</sup> Иргэний хуулийн тайлбар, Ерөнхий анги, 2006 он, 184 дэх тал.

<sup>20</sup> Иргэний хуулийн тайлбар, Ерөнхий анги, 2006 он, 184 дэх тал.

### Зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл

Хүчин төгөлдөр болохын тулд гуравдагч этгээдийн зөвшөөрөл шаардагдах хэлцлийг **зөвшөөрлөөр хийх хэлцэл** гэнэ, ИХ-ийн §50.1. Зөвшөөрөл ийнхүү зайлшгүй шаардагдах тухай хуульд тодорхой заасан байх ёстой бөгөөд уг этгээд зөвшөөрлөө олгоогүй бол хэлцэл ИХ-ийн §56.1.8-ын дагуу хүчингүй. Ийм зохицуулалт компанийн эрх зүй эсвэл төрийн өмчийг ашиглах, захиран зарцуулах хэлцлийн хувьд элбэг байдаг бол гэрээгээр нөхцөлдсөн зөвшөөрөл олгогдоогүй бол хэлцэл хүчин төгөлдөр эсэх нь эргэлзээтэй байна.

### Хоёр. Дасгал

**Тохиолдол 1:** Ажил олгогч А ажилтан Б-г алдаа гаргасны улмаас түүнийг сарын эцсээр халах тухай бичиг гардуулжээ. Гэхдээ зөвхөн Б-г айлгах гэсэн хүсэл давамгайлж байлаа. Удалгүй А жинхэнээсээ халах хүсэлгүй байгаагаар Б-д дуулгасан. Харин сандарсан Б өөр аж ахуйн нэгжид хандан ажлын байр олоод хөдөлмөрийн гэрээнд аль хэдийн гарын үсэг зурсан байлаа.

**а).** Гэрээг цуцлах илэрхийлэл хүчинтэй юу?

**б).** Хэрэв Б тохиолдлоор А-ийн нарийн бичигтэй ярьсан ярианаас цуцлах илэрхийлэл нь түүнийг айлгах зорилготой гэдгийг мэдсэн бол хэрхэх вэ?

**Тохиолдол 2:** А, Б нар А-ийн үл хөдлөх эд хөрөнгийг 150 сая төгрөгөөр Б-д шилжүүлэх тухай харилцан тохирсон. Гэрээг нотариатаар гэрчлүүлэхдээ нотариатын зардал болон үл хөдлөх хөрөнгө шилжүүлсний татварыг хэмнэх зорилгоор 90 сая төгрөг хэмээн багасгаж бичүүлсэн. Гэтэл хожим А тус хөрөнгийг шилжүүлж өгөхөөр татгалзсан.

**а).** Б дээрх үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх шаардлага гаргах эрхтэй юу?

**б).** Б-г улсын бүртгэлд өмчлөгчөөр бүртгүүлэхийг А зөвшөөрч, холбогдох өөрчлөлтийг оруулсан. А 150 сая төгрөгөө нэхэмжлэх эрхтэй юу?

**в).** А, Б нарыг үнийн талаар хэлэлцээр хийх үед А-ийн гэр бүлийн хүн болох Э-ийн хүсэлтээр гэрээний зүйлийн 90 сая төгрөг хэмээн батлуулсан. А энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваагүй тул хөрөнгийг энэ үнээр худалдаж байгаа гэж ойлгосон. А ямар шаардах эрхийг Б-ийн эсрэг хэрэгжүүлж болох вэ?

### Гурав. Хяналтын асуулт:

1. Хууль тогтоомж зөрчсөн хэлцэл бүр хүчингүй байх уу?
2. Зан суртахууны хэм хэмжээ хэлцлийг хүчингүй байх үндэс болдог гол шалгуур нь юу вэ? Цөөнхийн үзэл баримтлал үүнд хамаарах уу?
3. Заншлын хэм хэмжээ ИХ-ийн §56.1.1-ийн аль тохиолдолд хамаарах вэ?
4. Иргэний Хуульд заасан хэлбэрийн шаардлагыг олж тодорхойлно уу.
5. Компанийн тухай хуулийг уншиж танилцаад зөвшөөрлөөр хийх хэлцэлтэй холбоотой зохицуулалтыг олно уу.



### Дөрөв. Сорилго:

1. Зөвхөн Баян-Өлгий аймагт хүлээн зөвшөөрөгдсөн зан суртахууны хэм хэмжээнд харш хэлцэл хүчинтэй юу?
  - а. Тийм
  - б. Үгүй, бүх нутгаар мөрдөгдөх хэм хэмжээ байх ёстой
  - с. Хэлцэл хийгч тал тус нутагт харьяалагдах бол уг хэм хэмжээ ач холбогдолтой
  
2. Сайн дурын хэлбэрийн шаардлагыг хангаагүй хэлцэл ИХ-ийн §56.1.8-ын дагуу хүчингүй болох уу?
  - а. Болно.
  - б. Үгүй, энэ зохицуулалт гагцхүү хуульд заасан хэлбэрийн шаардлагад хамаарна.
  
3. Согтуу хүнийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж үзэж болох уу.
  - а. Болно. Учир нь согтуу хүн ч ИХ-ийн §56.1.-ийн хамгаалалтад хамрагдах ёстой
  - б. Үгүй, тэрээр өөрөө үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгох чадваргүй болсон тул түүний хийсэн хэлцэл хүчингүй болох ёсгүй.

### Гурав. Хэрэглэгдэхүүн

#### Сурах бичиг:

1. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
3. Э.Байгал. Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он

#### Гарын авлага, бодлогын хураамж:

3. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он
4. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он

#### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он
4. Компанийн тухай хууль. 2010 он

## Сэдэв 3.5 .: Хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулж болох хэлцэл

**Сэдвийн зорилго:** Практикт тохиох гэрээ, хэлцлийг хуулийн хүчин төгөлдөр эсэхийг тодорхой аргачлалын дагуу шалгах, тогтоох чадварыг эзэмшүүлэх, энэ эрхийг шүүхээр хэрэгжүүлэхэд анхаарах хүчин зүйлсийг таниулах зорилготой.

### Нэг. Семинар

- Хүчин төгөлдөр буст тооцуулах хэлцлийг хүчингүй хэлцлээс ялгах шалгуур, эрх зүйн үр дагаврыг тайлбарлах
- Хэлцлийг шүүхээр хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах эрхийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөлүүдийг толилуулах
- Хэлцэл хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах үндэслэлүүдийг онолын хувьд нэг бүрчлэн тайлбарлах, бие даан судлах даалгавар өгөх
- Холбогдох дасгал ажиллуулах

### Жишээлбэл:

#### **Хүчин төгөлдөр буст тооцуулах хэлцлийг хүчингүй хэлцлээс ялгах нь**

Хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулж болох хэлцлийг ИХ-ийн §56-д тусгасан хүчингүй хэлцэлтэй харьцуулахад тухайн төөрөгдсөн тал хэлцлээ шүүхээр хүчингүйд тооцуулахаас өмнө энэ нь хүчинтэй хэвээр байна. Холбогдох этгээд ийнхүү тооцуулахаа эсрэг талд мэдэгдсэний үндсэн дээр шүүх үүнийг хүчингүйд тооцсон бол эдгээр хэлцэл хийсэн үеэсээ хүчингүй болно, ИХ-ийн §57.2. Энэхүү хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах эрх нь гэрээний талын хүсэл зоригийн үндсэн дээр хэлцэл хийсэн цаг мөчид очиж нөлөөлж буй **эрх өөрчлөхөд чиглэсэн харьцангуй эрх** болно. Тэгэхээр энэ эрхийн объект нь хүчин төгөлдөр буст тооцуулах үндэслэлээр нөхцөлдсөн хэлцэл, тухайлбал гэрээ байгуулах болон хүлээн авах санал зэрэг юм. Гэрээний саналын нэгийг хүчингүйд тооцуулснаар хэлцэл бүхэлдээ хүчингүй болох буюу гэрээний тохиролцоо үгүй болдог.

Хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах эрх бүхий этгээд нь ийнхүү тооцуулах эсвэл хэлцлийг хэвээр нь байлгах *сонголт хийх* эрхтэй. Тиймээс холбогдох хэлцэл хийхэд буй болсон дутагдал доголдлын тухай нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд хуульд заасан хугацааны дотор хэлцлийг хүчин төгөлдөр буст тооцуулахаа илэрхийлэх ёстой. Учир нь эсрэг талын хувьд эрх зүйн тодорхой байдлыг бий болгох ашиг сонирхол нь хуулиар хамгаалагддаг.



## Хэлцлийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах алхмууд

Ноцтой төөрөгдлийн улмаас хэлцлийг хүчингүйд тооцуулахын тулд дараах нөхцөл биелсэн эсэхийг шалгана. Үүнд:


· Юуны өмнө дээр дурьдсанчлан ИХ-ийн §58-д заасан төөрөгдөл бий болсон эсэхийг тогтоох ба үүнийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах үндэслэл гэнэ.




**а). Агуулгын төөрөгдөл** гэдэг нь холбогдох этгээд илэрхийллийн агуулгыг буруу ташаа ойлгож, эндүүрсэн тохиолдлыг хамарна, ИХ-ийн §58.2.2. Энэ нөхцөлд тэрээр үндсэндээ ямар агуулга бүхий хүсэл зориг илэрхийлж буйгаа мэдэж байх авч, уг агуулгын эрх зүйн ач холбогдлыг зөв зүйтэй дүгнээгүйн улмаас хэлцлийн гадаад, дотоод хэлбэр аль аль нь түүний жинхэнэ эрх ашиг, хүсэл сонирхлоос зөрж байдаг. Тэгэхээр энд холбогдох этгээд илэрхийллийн агуулгыг бодит байдлаас өөр зүйлтэй холбон ойлгосон алдаа буй болж байна.

**б).** ИХ-ийн §58.2.1-д зохицуулсан **илэрхийллийн төөрөгдөл** хэмээх ухагдахуун нь зөвхөн илэрхийлэх үйл явцад гарч буй алдааг хамарна. Энэ тохиолдолд холбогдох этгээд өөрийн гадагш илэрхийлэхээр зэхэж байсан хүсэл зоригийг буруу ярих, буруу бичих зэргээр ташаа ойлгуулсан байдаг. Жишээлэхэд бараа бүтээгдэхүүнээ тодорхой үнээр худалдахыг хүсч байсан мөртөө үнийг алдаж бичих, мөн түүнчлэн компьютерийн программ буруу ажилласнаас үнэ ба холбогдох мэдээлэл нь буруу тавигдах дээрхэд багтах бөгөөд үүнээс гадна ямарваа нэг эрх зүйн үр дагаварт чиглэсэн үйлдэл хийх ухамсар үгүй бол энэ үндэслэлийг хэрэглэх боломжтой. Үүнийг зургаар үзүүлбэл:

**Илэрхийллийн алдаа, ИХ-ийн §58.2.1:**



**Агуулгын төөрөгдөл, ИХ-ийн §58.2.2:**



**в).** Хүсэл зоригийг төлөөлөгч, зуучлагч **буруу дамжуулах** нөхцөлд дээрхийн ижил гадаад илэрхийллийн түвшинд төөрөгдөл үүсэхтэй ижил нөхцөл байдал бий болдог. Тухайлбал холбогдох этгээд хүсэл зоригоо илэрхийлэхдээ хувь хүн, хуулийн этгээдээр (шуудан г.м.) дамжуулах ба эдгээр нь илэрхийллийг буруу ташаа хүргэсэн тохиолдол хамаарна. Энд төлөөлөгч, зуучлагч нараас гадна цахилгаан явуулах зэрэг дамжуулах хэрэгсэл буруу мэдээлсэн нөхцөлд ч мөн адил тухайн илэрхийллийг уг этгээд хүсээгүй байдаг. Тиймээс үүнийг ИХ-ийн §58.2-т хамааруулан ойлгохоор ИХ-ийн §58.4-т зохицуулсан ажээ.

Үндсэндээ бусдаар хүсэл зоригоо дамжуулсан тал үүнийхээ алдааг хариуцах тул гадаад илэрхийллийн агуулгаар гэрээ байгуулагдсан гэж үзэх боловч тэрээр хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах эрхтэй болно. ИХ-ийн §58.4-ийн дагуу хэлцлийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах урьдчилсан нөхцөл нь дамжуулагч илэрхийллийг **санамсаргүй буруу дамжуулах** явдал юм.

**г). Эсрэг талын хувийн шинж байдлын талаар төөрөгдөх, ИХ-ийн §53.3.1:**

Эсрэг талын этгээдийн хувийн шинж байдал гэдэгт тухайн этгээдийн хувь хүнтэй салшгүй холбоотой, тогтсон бодит болон эрх зүйн чанартай шинж тэмдгүүд, тухайлбал нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн байр суурь, итгэл үнэмшил, гэмт хэрэгт холбогдсон эсэх, мэргэжлийн чадвар, эдийн засгийн чадавхи, жирэмсэн эсэх гэх мэт багтана. Эдгээр нь тухайн хийх гэж буй хэлцэлтэй агуулгын хувьд холбоотой нөхцөлд эрх зүйн үүднээс ач холбогдолтой.

**д). Эд зүйлсийн шинж байдлаар төөрөгдөх, ИХ-ийн §58.3.2:**

Эд зүйлсийн шинж тэмдэг гэдэгт түүний эдэлгээ, үнийг тодорхойлоход нөлөөлж байдаг байгалиас заяасан шинж тэмдгүүд, мөн хүрээлэн байгаа орчинтойгоо холбогдох бүхий л бодит болон эрх зүйн харилцааг ойлгож болно. Өөрөөр хэлбэл, үүнд тодорхой хугацааны турш **үнийг бүрдүүлэх хүчин зүйлүүд**



хамрагдана. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн хувьд байршил, хэмжээ, хөрсний чанар, барилга барих боломжтой эсэх нь үнийг тодорхойлоход ач холбогдолтой байх тул эдгээр нь түүний шинж байдал болно.

**е). Тооцооны хүчин зүйлийн талаар төөрөгдөх нь:**

Хэлцлийн нэг тал нь хэлцлээс үүдэх ашгийг тооцохдоо үнэ, тоо хэмжээ зэрэг тооцооны үндэс болж болохуйц нөхцөл байдлын талаар эндүүрснийг тооцооны төөрөгдөл гэнэ. Тухайлбал, ажил гүйцэтгэх гэрээний хөлсийг бодоход ажил гүйцэтгэхэд зайлшгүй орох эд материалын үнэ, ажил үйлчилгээний агуулга, хэмжээ, ажилчдын цалин хөлс зэргийг тооцох ёстой байх ба эдгээрийн нэгийг буруу үнэлсэн нөхцөлд тооцооны алдаа гарах ба холбогдох этгээд ажлын хөлсийг энэ тооцоондоо тулгуурлан буруу тогтоож, төөрөгдөл үүснэ.

Хэлцэл хийгч нэг талын тооцооны үзүүлэлтүүд нөгөө талдаа илэрхий болоогүйгээс төөрөгдөл үүссэн бол ач холбогдолгүй /**нуугдмал тооцооны төөрөгдөл**/

**Төөрөгдөл болон хэлцэл хоёрын шалтгаант холбоог тогтоох:**

Холбогдох этгээд төөрөгдсөний улмаас уг хэлцлийг хийх шийдвэрт хүрсэн байх ёстой. Энэ хоёрын шалтгаант холбоог тогтоох явдал нь хоёр арга зам байдаг.

**а).** Нэг талаас тухайн этгээд үнэн нөхцөл байдлыг мэдсэн тохиолдолд тус хэлцлийг хийхгүй байсан гэдгийг тогтоох хэрэгтэй. Харин тэрээр төөрөгдөлд ороогүй байсан ч уг хэлцлийг тэртэй тэргүй хийх байсан нь нотлогдвол дээрх төөрөгдөл нь түүний хувьд **субъектив ач холбогдолгүй** байсны нотолгоо болно.

**б).** Нөгөө талаас уг этгээд нөхцөл байдлыг зөв дүгнэсэн тохиолдолд тус хэлцлийг хийхгүй байсан гэдгийг тогтоох нь чухал. Ийнхүү аливаа хүсэл зоригийн илэрхийллийн **объектив ач холбогдолтой** эсэхийг тогтоох шалгуур нь хэлцлийг хүчингүйд тооцуулах эрхийн нэг хязгаарлалт болдог. Энэ тохиолдолд тухайн этгээд өөрийнхөөрөө зөрүүдлэлгүй, субъектив сэтгэл санааны төлөв байдал, ертөнцийг үзэх гаж үзлээсээ үл хамааран уг хэлцлийг саруул ухаантай хүний хувьд хийх байсан эсэхийг тогтооно.

**Хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах илэрхийлэл:**

Хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах **илэрхийлэл** нь аливаа хэлцлийг эрх зүйн хувьд хүчингүй болгоход чиглэсэн байдаг тул эрх зүйн үр дагаварт чиглэсэн нэг талын хүсэл зоригийн илэрхийлэл, өөрөөр хэлбэл ИХ-ийн §39-т заасан 1 талт хэлцэл мөн. Энэхүү илэрхийлэл нь заавал “хүчин төгөлдөр буст тооцуулах” гэсэн нэр томъёог агуулах албагүй бөгөөд үүнийг сонсож хүлээн авч буй тал нь уг этгээдийн зүгээс тодорхой хэцлийг ноцтой төөрөгдлийн улмаас хүчингүй болгохыг хүсч байгаа нь мэдэгдэх үйлдэл, эс үйлдэхүй байж болно. Ийм хэлцлийг хүчингүйд тооцуулах илэрхийлэлд хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах үндэслэлийг бүрэн дүүрэн тоочсон байх шаардлагагүй.

**Хүчингүйд тооцуулах хугацаа, ИХ-ийн §58.6:**

ИХ-ийн §58.6-д зааснаар холбогдох этгээд хэлцлийг хүчингүйд тооцуулах тухайгаа нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ. Ингэснээр эсрэг тал нь хэлцэл хүчинтэй эсэхэд эргэлзэж, үүргээ биелүүлэх үгүй нь тодорхойгүй байх нөхцөл байдал үүсэхээс сэрэмжлэх зорилготой. “**Нэн даруй**” хэмээх ойлголт нь тайлбарлавал зохих, хугацааны хэмжүүр агуулсан эрх зүйн ухагдахуун юм. Төөрөгдсөн этгээд энэ талаар нөгөө талдаа мэдэгдэж, гэрээний тохиролцоо хүчинтэйд найдан элдэв үйлдэл, төлөвлөгөө гаргахаас сэргийлэх нь зайлшгүй чухал бөгөөд хожим маргаан шүүхэд очиход шүүгч нэн даруй мэдэгдээгүй бол эрхээ алдсан хэмээн үзэж буцаана.

Нөгөөтэйгүүр хуулинд тогтоосон хугацаанд аливаа эрхийг хэрэгжүүлээгүй бол эрхээ алдах **үр дагавартай** нь хэн бүхэнд тодорхой үзэгдэл тул дээрхтэй санал нийлэх боломжгүй юм. Энэхүү хугацааг холбогдох тал төөрөгдсөнөө мэдсэн даруй **тоолж эхлэх** ба эрх бүхий этгээдэд хэсэг зуур бодох, эрх зүйн зөвлөгөө авах хугацаа олгож болно.

**Эрх үгүйсгэх нөхцөл:**

Аливаа хэлцлийг хүчингүйд тооцуулахад эрх хэрэгжүүлэх хугацаа өнгөрсөн, холбогдох этгээд мэдсээр байж хэлцлээс үүдэх үүргийг гүйцэтгэхээр зөвшөөрсөн эсвэл хэлцэл хүчингүйд тооцуулах нь шударга ёсонд харшлах зэрэг уг эрхийг хязгаарласан эрх зүйн үндэслэл байх ёсгүй.

**Эрх зүйн үр дагаврыг тодорхойлох**

- ИХ-ийн §57.2.-т заасны дагуу хүчин төгөлдөр буст тооцох үндэслэл бий хэлцлийг ийнхүү тооцуулсан бол хэлцэл хийсэн үеэсээ буюу “ex tunc” хүчин төгөлдөр бус болно.
- Хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулсан этгээд нь ИХ-ийн §58.7.-ийн дагуу нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

**Бие даан судлах даалгавар:**

- Хууран мэхэлсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн шалтгаанаар хэлцлийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулах үндэслэлийг дээрхийн адилаар шалгах

**Агуулга:**

♦ ИХ-ийн §60.1-д хүч хэрэглэж эсвэл хүч хэрэглэхээр заналхийлж хийсэн хэлцлийг хүчингүйд тооцуулахаар шаардах эрхтэй хэмээн заажээ. Эдгээр тохиолдолд мөн л чөлөөтэй шийдвэр гаргах эсрэг талын хүний эрх зөрчигдөнө.

♦ **Хүч хэрэглэх** гэдэгт бусдын бие махбодид үзүүлэх албадлагын чанартай нөлөөллийг ойлгох бол хүч хэрэглэхээр заналхийлэх гэдэгт тухайн этгээд ирээдүйд тохиолдож болох аюулд нөлөөлж чадах мэт ойлголт төрүүлэхийг хамруулж үзнэ. Ийнхүү заналхийлэх нөхцөлд сэтгэл санааны дарамт шахалт



буюу латинаар **vis compulsiva** гэсэн нэр томъёо хэрэглэгдэх бол биеийн хүчний нөлөөллийн улмаас хүсэл зориг бүрдэх, шийдлээ сонгох эрх бүрмөсөн үгүй болдог гэдэгт утгаар нь **vis absoluta** хэмээн нэрлэдэг.

### Хоёр. Дасгал

А нэгэн үл хөдлөх хөрөнгийг Б-д м<sup>2</sup>-ыг нь 1300 доллараар бодож худалдахаар болжээ.

**а).** Б үнийг сонсоод хэсэг зуур эргэцүүлэн бодох үед А сүүлийн үеийн зах зээлийн ханш бүр 1500 доллар болоод байгаа хэмээгээд жишээ болгон тус байран дахь бусад сууцыг 1500 доллараар худалдсан хэд хэдэн тохиолдол бий гэжээ. А энэ тухай өөрөө сайн мэдэхгүй ч ойролцоогоор тохирч магадгүй гэж бодож байлаа. Гэтэл бодит байдал дээр тус байрны чанараас шалтгаалан талбайн үнэ дунджаар 1100 доллар байжээ. Б гэрээг хүчингүй хэмээн тогтоолгох боломжтой юу?

**б).** А дээрх тохиолдолд 1м<sup>2</sup> талбайн үнэ 1100 доллар л хүрнэ гэдгийг сайн мэдэж байсан боловч гэрээ байгуулах үед энэ талаар Б-д хэлээгүй бол хэрхэх вэ?

**в).** Б байр худалдан авах тухай гэрээ байгуулахдаа Х банкнаас 100 сая төгрөгийн зээл авсан. Х банк нь А-ийн хамтран ажилладаг түнш байгууллага. Хэрэв Б нь А-тай байгуулсан дээрх гэрээг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулсан бол зээлийн гэрээг дуусгавар болгох боломжтой юу?

**г).** А нь Б банкнаас 15 сая төгрөгийн зээл авсан бөгөөд зээлээ хүүгийн хамт эргэн төлөх үүрэг хүлээсэн. Тэрээр мөнгийг гэр бүлийн орон сууцанд тавилга, цахилгаан хэрэгсэл авахад зориулсан. А-г зээлээ төлөхгүй удахад Б түүний нөхөр Н-д хандан холбогдох батлан даалтыг гаргаж өгөхгүй бол а/. А-ийн эсрэг шүүхийн тогтоол гаргуулан шүүхийн шийдвэр гаргуулах; б/. Банкинд ил болсон татвар нуун дарагдуулсан хэргээр А-г цагдаад мэдэгдэнэ гэж сүрдүүлжээ. Н нэн даруй батлан даалтын гэрээнд гарын үсэг зурсан боловч үүнийгээ хүчингүйд тооцуулах хүсэлтэй.

### Гурав. Хяналтын асуулт:

- Хүчин төгөлдөр бус байх, хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцлийн онцлогыг харьцуулан тайлбарлана уу.
- Хэлцэл хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулсны дараах эрх зүйн үр дагаврыг тайлбарлана уу.
- Хууран мэхлэх гэдэгт юуг ойлгох вэ? Ноцтой төөрөгдөл үүсгэх, хууран мэхлэх үйлдлийн адил төстэй болон ялгагдах шинжийг тодорхойлно уу.
- Хэлцлийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулахад баримталбал зохих алхамуудыг нэрлэнэ үү.

**Дөрөв. Хэрэглэгдэхүүн:****Сурах бичиг, тайлбар толь, өгүүлэл:**

1. Т.Мөнхжаргал: МУ-ын Иргэний эрх зүй, УБ хот 2007 он.
2. Наранчимэг Д. “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ, 1999 он
3. Б.Баттөмөр: МУ-ын Иргэний эрх зүйн зарим асуудал, УБ хот 2005 он.
4. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
5. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
6. Э.Байгал: Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он
7. “Иргэний хууль: Шинэлэг зохицуулалт” хамтын бүтээл. ХЗҮТ. УБ., 2004 он.
8. Сугар. Д “Монгол Улсын иргэний хуулийн шинэтгэл” Монголын төр, эрх зүй” УБ. 2002. № 2
9. Амарсайхан. Ц.”Хэлцлийн хэлбэр” Монголын төр, эрх зүй 2002 №2
10. Бат-Өлзий.Д “Иргэний эрх зүй 1” УБ.2003 он 74-96 тал
11. Жамбалдорж.О “Монгол Улсын иргэний эрх зүй “ /ерөнхий анги/ 1-р дэвтэр УБ. 2004 он 17-51 тал
12. Зундуй.Д “Монгол Улсын иргэний эрх зүй “ /ерөнхий, тусгай анги/ УБ.2001 он 86-97 тал
13. Сүхбаатар.З, Оюундэлгэр.П “Иргэний эрх зүй “ /ерөнхий анги: схемчилсэн тайлбар/ УБ. 2003 он 67-72
14. Кают.Ё “Монгол Улсын шинэ иргэний эрх зүй “ УБ. 2003 он
15. Под ред. Сергеев. А.П, Толстой Ю.К “Гражданское право “ М. 1997 г 1 том стр 217-292
16. Под ред. Суханов А.Е. “Гражданское право” Москва., 2002г. Том 1.
17. Амарсанаа.Ж, Гебхард.И, Заяа.Л “Монголын иргэний эрх зүйн шинэтгэл” УБ. 1998 он
18. Амарсайхан.Ц, Цолмон.Д. “Гэрээний эрх зүй” УБ., 2002 он.
19. Цолмон.Д. “Гэрээний эрх зүй” УБ., 2003 он.
20. Michael Jewell. “An introduction to English Contract law” Baden 1997
21. “International business law” 5th edition 1999. West law.
22. ХЗДХЯ. ГТХАН. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ., 2005 он

**Гарын авлага, бодлогын хураамж:**

4. Д. Энхзул: Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.
5. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
6. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.



### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.
4. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хууль 2002 он
5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2003 он
6. Компаний тухай хууль 1999 он
7. Нөхөрлөлийн тухай хууль 1994 он
8. Хоршооны тухай хууль 1999 он

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ТӨЛӨӨЛӨЛ

**Сэдвийн зорилго:** Төлөөллийн ойлголт, төрлийн талаар суурь мэдлэг олгох, иргэний эрх зүйн харилцаанд төлөөллийг хэрэгжүүлэх, хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгөх чадвар эзэмшихэд оршино.

### Нэг. Тойм лекц

#### 4.1 Төлөөллийн ойлголт, төрөл

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь өөрөө тухайн үйлдлийг биечлэн хийхийг хүсэхгүй байх, эсхүл чадахгүй, амжихгүй байх тохиолдолд түүнийг төлөөлөгчөөр дамжуулан хийх нь элбэг байдаг. Жишээ нь:

1. Эрх зүйн чадамжгүй этгээд нь эрх зүйн хувьд хувьд хүчин төгөлдөр хүсэл зоригоо илэрхийлж чадахгүй. Иймээс тэд эрх зүйн харилцаанд төлөөлөгчөөрөө дамжуулан оролцдог.

2. Хуулийн этгээд нь өөрөө хэлцлийг хийх боломжгүй. Түүний хувьд байгууллагууд нь хэлцлийг хийх бөгөөд энэхүү үйлдэл нь тухайн хуулийн этгээдийн үйлдэл гэж тооцогдоно.

3. Төлөөллийн харилцаа нь дээрхээс гадна бодит үндэслэлийг шаарддаг. Тухайлбал, томоохон худалдааны төвийн эзэмшигч нь бүхий л гэрээгээ өөрөө байгуулж амжихгүй. Тиймээс ажилтан ажилчид нь энэ тохиолдолд түүнийг төлөөлж байдаг.

Эрх зүйн харилцаанд оролцогчдыг дэмжихийн тулд Иргэний хуулийн 62-р зүйл болон түүнээс хойшхи зүйлүүдэд шууд төлөөллийн үндсэн дээр хийх боломжийг олгосон байдаг. Үүний дагуу аливаа этгээд нь хэлцлийг төлөөлөгчөөрөө дамжуулан хийж болно.

Хэдийгээр төлөөлөгч хэлцэл хийж байгаа боловч түүний үр дагавар нь төлөөлүүлэгчид үүсч байдаг. Гэрээний агуулга болон хүчин төгөлдөр байдал нь төлөөлүүлж байгаа этгээдийн хүсэл зоригоос хамаарна.

Ийнхүү хэлцлийн үр дагавар төлөөлүүлэгчид үүсэхийн тулд дараах урьдчилсан нөхцөл бүрдсэн байх ёстой.

#### **Төлөөлөх этгээд өөрийн хүсэл зоригийг илэрхийлэх**

Төлөөлөх этгээд нь өөрийн хүсэл зоригийг илэрхийлдэг. Хэрэв тэрээр зөвхөн бусдын хүсэл зоригийг дамжуулж байгаа бол төлөөллийн харилцаа бус харин элч гэж нэрлэнэ. Энэхүү байдал нь төлөөлөл ба элчийн ялгагдах гол ялгаа юм.

#### **Төлөөлөх этгээд нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс тодорхой үйлдэл хийх**

Төлөөлж буй этгээд нь бусдын нэрийн өмнөөс хэлцэл хийх бөгөөд ийнхүү бусдын нэрийн өмнөөс хэлцэл хийж буй гэдэг нь хэлцэл хийгч нөгөө талд мэдэгдэж байхыг шаардана.



## Төлөөлөх бүрэн эрхтэй байх

Төлөөлөгчөөр дамжуулан хийсэн хэлцлийн үр дагавар нь гагцхүү төлөөлж байгаа этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй үед л, эсхүл төлөөлүүлж байгаа этгээд нь түүнийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд л төлөөлүүлэгчид үүснэ.

Эдгээрээс дүгнэн авч үзвэл: **Төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс төлөөлөгч нь аливаа хэлцлийг хийж, хийсэн хэлцлийнх нь үр дагавар төлөөлүүлэгчид шууд бий болж байдаг иргэний эрх зүйн нэг төрлийн харилцааг төлөөлөл гэж тодорхойлж болно.**

## Төлөөллийн харилцаанд оролцогчид:

- Төлөөлүүлэгчийн хүсэл зоригоос санаанаас үл хамааран, төлөөлөгч, түүний эрх, үүргийг хууль тогтоомжид шууд заасныг **хууль ёсны төлөөлөл** гэнэ. Жишээ нь, бага насны хүмүүсийн нэрийн өмнөөс түүний эцэг, эх, асран хамгаалагч нь хэлцэл хийж аливаа эрх зүйн харилцаанд оролцох, ХХК-ийн гүйцэтгэх захирал төлөөлөх гэх мэт.
- Хуулийн этгээдийн байгууллага шийдвэр гаргаж өөрийн нэрийн өмнөөс бусадтай гэрээ, хэлцэл, бусад хууль зүйн үйлдэл хийх эрхийг тодорхой этгээдээр гүйцэтгүүлэхийг томилсон **захиргааны актын үндсэн дээр** төлөөлөгчийн бүрэн эрхийг тогтоож болно. Жишээ нь: төлөөлөгчийн газар хуулийн этгээдийг төлөөлөх
- Хоёр талын сайн дурын үндсэнд байгуулсан **хэлцлийн үндсэн дээр** төлөөллийн харилцаа үүсч болно.

Нэг этгээд өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх бүрэн эрхийг нөгөө этгээдэд олгосноо бичгээр тодорхойлсныг **итгэмжлэл** гэнэ. Итгэмжлэл нь төлөөлөгчийн бүрэн эрх, түүний эрх, үүрэг, эрх хэмжээг тодорхойлсон хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичиг юм.

Итгэмжлэл ямар гэрээ, хэлцэл, үүрэг даалгаврыг ямар хугацаанд хэрхэн яаж биелүүлэх нөхцөл болзлыг нөгөө этгээдэд санал болгодог. Нөгөө этгээд уг саналыг заавал хүлээн авах үүрэггүйн зэрэгцээ хэрэв хүлээн авсан бол итгэмжлэлийн агуулгыг өөрчлөх эрхгүй байна. Энэ шинжээр нь авч үзвэл итгэмжлэл нь нэг талын хэлцэл юм. Итгэмжлэл нь нэг талын хэлцэл болохынхоо хувьд хэлцэлд тавигддаг шаардлагыг мөн хангасан байна.

## Итгэмжлэлд тавих хууль зүйн шаардлага


♦ Итгэмжлэлийг хэлбэрийн хувьд амаар болон бичгээр хийж болно. Итгэмжлэлийг хуульд бичгээр хийхээр заасан, талууд бичгээр хийхээр харилцан тохиролцсон бол бичгээр хийнэ.

Бичгээр олгосон итгэмжлэлд дараах шаардлага тавигдана:

- Итгэмжлэлд итгэмжлэл олгогч гарын үсэг зурсан байх
- Итгэмжлэлд олгосон он, сар, өдрийг заана.

Итгэмжлэл нь хугацаатай ба хугацаагүй байна. Итгэмжлэлийн дээд хугацаа 3 жил, харин итгэмжлэлд хугацаа заагаагүй бол итгэмжлэгдэгчид олгосон өдрөөс эхлэн нэг жилийн дотор хүчин төгөлдөр байх ба итгэмжлэл олгосон он, сар, өдрийг бичээгүй бол эрх зүйн баримт бичиг болж чадахгүй.

- Итгэмжлэлийг хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх
- Итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах
- ♦ Итгэмжлэл тодорхой нэр бүхий эзэнтэй, өөрөөр хэлбэл итгэмжлэгдэгчийн овог, нэр бичигдсэн байх ёстой.
- ♦ Итгэмжлэл тодорхой хугацаатай байх
- ♦ Төлөөлөгчийн бүрэн эрх тодорхой тусгагдсан байх



- Итгэмжлэгдэгчийн өргөн хүрээтэй хэлцэл, хууль зүйн үйлдэл хийх бүрэн эрх олгосон итгэмжлэлийг **ерөнхий итгэмжлэл** гэнэ.
- Төлөөлөгчийн үйлдэж болох тодорхой тооны ихэвчлэн нэг төрлийн үйлдлүүдийг хийлгэхээр бүрэн эрх олгосон итгэмжлэлийг **тусгай итгэмжлэл** гэнэ.
- Нэг удаагийн тодорхой үйлдлээр хэлцэл буюу хууль зүйн үйлдэл хийх итгэмжлэлийг **нэг удаагийн итгэмжлэл** гэнэ.

### Хоёр. Хяналтын асуулт:

1. Эрх зүйн харилцаан дахь төлөөлөлийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг тайлбарлана уу.
2. Төлөөлөх бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэлийг тодорхойлно уу.
3. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдыг төлөөлөх, түүний үр дагаврыг жишээн дээр тайлбарлана уу.
4. Итгэмжлэлд тавигдах шаардлагыг тодорхойлж, итгэмжлэлийн төсөл боловсруул.

### Гурав. Дасгал:

Р-нь өөрийн өмчлөлийн орон сууцыг суллаж, түүнийг захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлийг Х-д олгон, нотариатаар гэрчлүүлжээ. Р-нь уг итгэмжлэлийг олгосныхоо маргааш нь орон сууцаа худалдахаа больсон тухай факсыг Х-д илгээсэн боловч түүний утас техникийн сааталтай байсны



улмаас орон сууцыг А-д худалдсан байна. Х нь Р-ийн нэрийн өмнөөс А-тай худалдах худалдан авах гэрээ хийн, нотариатаар гэрчлүүлж, улсын бүртгэлд бүртгүүлжээ. Р-нь байрыг А-д худалдсан тухай мэдмэгц худалдах худалдан авах гэрээг хүчингүйд тооцуулахыг шаардаж, А-аас байр чөлөөлж өгөхийг шаардсан боловч А түүнийг шаардлагыг хүлээн авхаас татгалзав. Тиймээс Р нь худалдах худалдан авах гэрээг хүчингүй болгох тухай нэхэмжлэл шүүхэд гаргажээ. Р-нь итгэмжлэлд заасан үйлдлийг нэн даруй зогсоох тухай факсыг худалдах худалдан авах гэрээ хийгдэхээс өмнө Х-д илгээсэн гэдгээ нотолж Х-г худалдах ба худалдан авах тухай гэрээ хийх эрхгүй гэжээ.

### **Асуулт. Р-ийн шаардлага үндэслэлтэй юу?**

- Итгэмжлэл хүчин төгөлдөр байхын тулд ямар шаардлага хангасан байх ёстой вэ?
- Р-ийн Х-д олгосон итгэмжлэл ямар төрлийн итгэмжлэл вэ?

### **Дөрөв. Хэрэглэгдэхүүн:**

1. Монгол Улсын хууль 1992 он
2. Иргэний хууль 2002 он
3. Д.Наранчимэг “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” I дэвтэр 1999 он 4-27-р тал
4. Т.Мөнхжаргал “Монгол улсын иргэний эрх зүй” /ерөнхий анги/ 2000 он 40-90-р тал
5. Д.Бат-Өлзий “Иргэний эрх зүй 1” УБ, 2003 он 27-73-р тал
6. О.Жамбалдорж “Монгол улсын иргэний эрх зүй” /ерөнхий үндэслэл/ 2004 он 76-184-р тал
7. Б.Улаанбаатар “Иргэний эрх зүй: тайлбар толь” 2005 он
8. Э. Байгаль. Иргэний эрх зүйн ерөнхий анги. 2009 он
9. “Монгол улсын иргэний хуулийн тайлбар. УБ 2007 он
10. Хасагт хайрхан дээд сургууль, Хууль зүйн мэдээллийн төв, Иргэний хуулиуд (1926, 1952, 1963, 1994, 2002) II Боть, УБ, 2002
11. Б.Баттөмөр “Монгол Улсын иргэний эрх зүйн зарим асуудал” УБ., 2004 он
12. Т.Мөнхжаргал “Монгол улсын иргэний цаазын товчоон” УБ, 2006 он
13. Б.Буянхишиг “Иргэний эрх зүй” –бодлогын хураамж УБ, 2009 он
14. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он
15. Б. Тэмүүлэн, Д. Энхзул, Б. Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, УБ., 2010.
16. Толстой, Гражданское право, Москва, 1996-1998 г
17. Суханов, Гражданское право, Москва, 1998 г
18. Ильярнова, Гражданское право, Москва, 1998 г
19. Под ред Алексеева.А.А, Толстого Ю.К. “Гражданское право” Том.М.1996 г
20. Под ред Красавчикова.О.А “Гражданское право “. М.1988 г
21. Под ред Суханова.Е.А “Гражданское право”. М., 2002 г

## ТАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУГАЦАА

### Сэдэв 1: Иргэний эрх зүй дэх хугацаа, ойлголт, ангилал

**Сэдвийн зорилго:** Иргэний эрх зүй дэх хугацаа, түүний төрлийн талаар онолын мэдлэгтэй болох, хугацаа зөрчигдсөнөөс үүсэх үр дагаврыг шийдвэрлэх чадвар эзэмшихэд оршино.

#### Нэг. Семинар:

#### Иргэний эрх зүйд хугацааг тоолох зохицуулалт

Иргэний эрх зүйн харилцаанд хугацаатай холбоотой асуудал чухал үүрэг гүйцэтгэх нь элбэг тул ИХ-ийн §§71-73-т тусгасан хугацаа тоолох аргыг судлах шаардлагатай. Эдгээр зохицуулалт нь ямар нөхцөлд хугацаа баримтлах үүрэг үүсэх тухай зохицуулаагүй, гагцхүү тогтсон хугацааг хэрхэн тоолох, тодорхойлох аргыг тусгасан. Иргэний эрх зүйн салбарт баримталбал зохих хугацааг:

- эрх хэрэгжүүлэх хугацаа, ИХ-ийн §§58.6, 59.4, 60.3 г.м.
- үүрэг биелүүлэх хугацаа, ИХ-ийн §208
- эрх хамгаалах хугацаа
- гомдлын шаардлага гаргах хугацаа, ИХ-ийн §§254.6, 349
- баталгаат хугацаа, ИХ-ийн §§254.6/7
- хөөн хэлэлцэх хугацаа ИХ-ийн §§74-82 зэрэг ухагдахуунаар тэмдэглэдэг.

ИХ-ийн §§71-73 /хугацааг тайлбарлах хуульд заасан арга/

#### хуульд заасан

Жишээ нь:

- гомдлын шаардлага гаргах хугацаа, ИХ-ийн §§254.6, 349
- хөөн хэлэлцэх хугацаа, ИХ-ийн §75

#### шүүхээр тогтоосон

#### гэрээ, хэлцэлд тусгасан

Жишээ нь:

- баталгаат хугацаа
- үүрэг гүйцэтгэх хугацаа
- талууд хөөн хэлэлцэх хугацаа зэргийг хуульд зааснаас өөрөөр тохирч болно



### **Хугацааг тоолох үндсэн зарчим**

Хугацааг тоолохдоо бүхэл өдрийг тооцооны нэгж болгон ашиглах нь хамгийн түгээмэл арга гэдгийг ИХ-ийн §73.1-ээс харж болно. Өөрөөр хэлбэл, үйл явдал болсон өдрийн цагаас хугацаа дуусах өдрийн цаг хүртэл тооцох бус, гагцхүү тодорхой өдрөөс хугацаа дуусах өдрийг бүхэлд нь нэрлэж тоолно.

ИХ-ийн §72.1-д тусгаснаар хугацааг эхлүүлж буй үйл явдал болсон өдрийг тооцохгүй, дараачийн өдрөөс эхлэн тоолно. Тухайлбал шүүхийн шийдвэр хугацааг эхлүүлэх бол уг шийдвэрийг гардуулсан өдрийг тооцохгүй. Харин тодорхой үйл явдал болох эсэх нь чухал биш, хуанлийн өдөр өөрөө хугацааг эхлүүлж буй цорын ганц үзүүлэлт бол энэ өдрөөс эхлэн хугацааг тоолно.

**Жишээ:** 4 сарын 1-ээс хойш 14 хоногийн дотор түрээсийн төлбөрийг төлөх тухай тохиролцоонд 4 сарын нэгнийг оролцуулан хугацааг тоолно. Мөн хувь хүний төрсөн өдрөөс эхлэн хугацаа тоолох бол уг өдрийг оролцуулна. 1989 оны 9 сарын 15-нд төрсөн этгээд 2007 оны 9 сарын 14-нийг дуусмагц насанд хүрнэ.

Өдрөөр тогтоосон хугацаа нь уг хугацааг дуусах сарын мөн өдөр дуусна. Долоо хоног, сараар тогтоосон хугацаа дараачийн долоо хоногийн эсвэл сарын тухайн гариг, өдөр дуусна. Жишээ нь, 2 сарын 3-ны хоёр дахь өдөр шүүхийн шийдвэрийг гардуулснаар эхлэх долоо хоногийн хугацаа 2 сарын 10-ны хоёр дахь өдрийн 24 цагт дуусгавар болно. Сараар тогтоосон хугацааны хувьд хуанлийн сар нийт хэд хоногтой болох нь ач холбогдолгүй. Тиймээс 1 сарын 31-нд эхлэх сарын хугацаа 2 сарын 28-нд дуусна.

Тоолох хугацааны эцсийн өдөр хагас, бүтэн сайн өдөр эсвэл олон нийтийн амралтын өдөр таарвал хугацааг сунгаж, дараачийн ажлын өдөр дуусахаар тооцно, ИХ-ийн §72.2. Энэ зохицуулалт гэрээний гүйцэтгэл явуулах, хүсэл зориг илэрхийлэх болон хугацаа хэтрүүлсэн эсэхийг тогтооход ач холбогдолтой. Мөн хөөн хэлэлцэх хугацаа дуусах тохиолдолд төсөөтэй хэрэглэгдэнэ.

Түүнчлэн ИХ-ийн §73-т хуанлийн жилийг хэрхэн тооцох, долоо хоног, гариг, хоног, цагаар тогтоосон хугацааг хэрхэн тооцох тухай тайлбар агуулжээ. Ийнхүү хугацаа дууссан нь тогтоогдвол материаллаг эрх зүйн тусгай зохицуулалтад тусгасан эрх зүйн үр дагавар бий болно. Процессын эрх зүйд аливаа хугацаа дуусгавар болсны дараа шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянах боломжтой, ИХШХШТХ-ийн §179.

### **Хөөн хэлэлцэх хугацааны тухай ерөнхий ойлголт**

Хөөн хэлэлцэх хугацаа гэдэгт аливаа шаардах эрхийг шүүхээр хэрэгжүүлэх боломжит хугацааг хуульд тусгасныг ойлгоно. Энэ нь тодорхой хугацаа өнгөрснөөр уг шаардлагыг нотлох боломж хомсдож, хууль сахиулах байгууллагад хандан гүйцэтгүүлэх явдал хүндрэлтэй болдогтой холбоотой. Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл тухайн шаардах эрхийг эрх зүйн ач холбогдолгүй

болно хэмээн үзэхээр хууль тогтоогч шийдсэн. Тиймээс үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хангахаас бүрмөсөн татгалзах эрхтэй болдог, ИХ-ийн §82.

Хөөн хэлэлцэх хугацаа нь зарим талаараа нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой, заавал биелүүлбэл зохих хууль тогтоомж юм. Тиймээс хөөн хэлэлцэх хугацааг гэрээний тохиролцооны үндсэн дээр уртасгах боломжгүй. Харин талуудын хүсэлтээр шүүхээс өөрчлөн тогтоож болно, ИХ-ийн §75.3.

### **Хөөн хэлэлцэх хугацаа хамаарах эрхүүд**

ИХ-ийн §74.1-ийн дагуу зөвхөн шаардах эрхэд л хөөн хэлэлцэх хугацаа гэсэн ухагдахуун хамааралтай. Шаардах эрхээс бусад субъектив эрхийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа дуусна гэсэн ойлголт байхгүй. Туйлын эрхийн хувьд тус эрхийн зөрчилтэй холбоотой үүдэж буй шаардах эрхүүдэд хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг хэрэглэх нь бий. Учир нь өмчлөх эрхийн хөөн хэлэлцэх хугацаа дуусна гэсэн ойлголт байхгүй ч үүнийг зөрчсөн үйлдэл *бүрээс* эхлэн холбогдох шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой.

### **Хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох нь**

Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа 10 жил байхаар ИХ-ийн §75.1-д заажээ. Энэхүү **ерөнхий зохицуулалт** нь хуульд тусгайлсан заалт байхгүй тохиолдолд хэрэглэгдэнэ. ИХ-ийн §75.2-т дээрхээс богино хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан зохицуулсан, мөн тусгай ангид энэ талаар нилээд зохицуулалтыг оруулсан байна.

ИХ-ийн §75.2-т гэрээний үүрэгтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа 3 жил, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой гэрээний үүргийн хөөн хэлэлцэх хугацаа 6 жил, хөөн хэлэлцэх хугацаа, тогтмол хугацаанд гүйцэтгэх үүргийн хувьд 3 жил, гэм хор учруулсантай холбоотой шаардах эрх 5 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай байхаар тус тус зохицуулсан байна.

Иргэний эрх зүйн тусгай ангиас дээрхтэй холбогдуулан ИХ-ийн §§298.1, 376, 395 зэргийг дурьдаж болно. Харин аливаа шаардах эрхийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр тогтоосон бол хөөн хэлэлцэх хугацаа нь шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 жил байна, ИХ-ийн §80.1. Хөөн хэлэлцэх хугацааг тоолоход үүрэг гүйцэтгэгч болон үүрэг гүйцэтгүүлэгч солигдох явдал нөлөө үзүүлэхгүй. Эрх залгамжлагч гуравдагч этгээдэд эрх шилжсэн ч шаардах эрхийн өмнөх этгээдийн эзэмшилд байсан үеэс хөөн хэлэлцэх хугацааг үргэлжлүүлэн тоолно, ИХ-ийн §81.1.

### **Хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх үе:**

ИХ-ийн §76.1-ийн дагуу хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс тоолно. Шаардах эрх үүссэн мөч нь юуны өмнө холбогдох үүргийг шаардаж болох, шаардлагатай бол холбогдох нэхэмжлэл гаргаж болох үеэс эхлэн



тодорхойлогдох бол үүнд гэрээ байгуулсан эсвэл гэм хор учруулсан үйлдэл хийсэн өдрийг ойлгоно. ИХ-ийн §76.2-т энэ зарчмаас хазайх тохиолдлуудыг зохицуулсан. Аливаа шаардах эрх үүсэх эсэх нь гэрээ цуцлах, хүчин төгөлдөр бус болгох, гэрээнээс татгалзах зэргээс мөн шалтгаалахаар бол (ИХ-ийн §§355, 227, 256 гэх мэт) хөөн хэлэлцэх хугацаа нь эдгээр эрхийг хэрэгжүүлж болохуйц цаг мөчөөс эхэлнэ.

### **Хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох, хойшлуулах, тасалдах:**

Хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох нөхцөл байдал үүссэн бол энэ хугацааг хөөн хэлэлцэх хугацаанд оруулан тоолохгүй. ИХ-ийн §78.1-д заасан тохиолдлууд бий болсон бол хөөн хэлэлцэх хугацаа **түр зогсох** ба энэ байдал өнгөрөхөд дээрхийг цааш **үргэлжлүүлэн тоолно**. Тэгэхээр 3 жил үргэлжлэх хөөн хэлэлцэх хугацаа байсан бол тэр нь түр зогссон хугацаагаар уртсах юм. Эдгээрт үндсэндээ шаардах эрхийн эзэн эрх зүйн үүднээс эсвэл өөр бусад бодит шалтгаанаар эрхээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг хамруулан ойлгох бөгөөд жишээлэхэд үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэхээс татгалзсаныг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн зөвшөөрсөн бол энэ хооронд хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй хүлээнэ, ИХ-ийн §78.1.2.

Түүнчлэн ИХ-ийн §78.4-т заасан нөхцөл байдал бий болсон бол хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болох огноог **хойшлуулна**. Ийм нөхцөлд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох үндэслэл арилсанаас хойш 6 сарын дотор хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй. Харин хөөн хэлэлцэх хугацаа түр зогсоох шалтгаан энэ хугацаа дуусгавар болохоос 6 сарын өмнө арилсан бол ИХ-ийн §78.4-т зааснаар хөөн хэлэлцэх хугацааг хойшлуулах шаардлагагүй.

Хөөн хэлэлцэх хугацаа нь **тасалдах** тохиолдолд тасалдсан өдрөөс өмнө тоологдсон хугацаа хамаарахгүй бөгөөд ийнхүү тасалдах үндэслэл арилсны дараа хугацааг **шинээр тоолно**, ИХ-ийн §79.7. Хөөн хэлэлцэх хугацаа нь эрх бүхий талын зүгээс хуульд тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан эсхүл үүрэг гүйцэтгэгч тал нь эрх бүхий талд хандан урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол тасалдана, ИХ-ийн §79.1. Шүүхэд нэхэмжлэл гаргасан нөхцөлд шүүхийн ажиллагаа дуусгавар болсноор хөөн хэлэлцэх хугацааны тасалдал зогсоно, ИХ-ийн §79.3. Ингээд ч маргааныг эцэслэн шийдвэрлэж чадаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа дээр дурьдсанчлан шинээр эхлэн тоологдоно.

### **Эрх зүйн ач холбогдол**

Хөөн хэлэлцэх хугацаа дуусахад аливаа шаардлага бүрэн хэмжээгээр оршин байх боловч энэ мөчөөс эхлэн үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэхээс бүрмөсөн татгалзах эрхтэй болдог, ИХ-ийн §82.1. Энэхүү татгалзах эрхийг хэрэгжүүлснээр шаардах эрх хэзээ ч дахин хэрэгжих боломжгүй болно гэсэн үг. Тиймээс хэрэг маргаан хянан шийдвэрлэх явцад хариуцагч дээрх татгалзах эрхийг хэрэгжүүлбэл нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно.

Гэхдээ энэ нь тухайн нэхэмжлэлийн шаардлага хууль сахиулах байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх боломжгүй болохоос бус эрх нь хэвээр байх тул хариуцагч хүсвэл үүнийг биелүүлж болно. Тиймээс тэрээр хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон байхад үүргээ гүйцэтгэх юм бол гүйцэтгэсэн үүргээ буцаан шаардах эрхгүй, ИХ-ийн §82.3.

### **Гомдлын шаардлага гаргах хугацаа:**

Хөөн хэлэлцэх хугацаанаас тусгай ангид тусгагдсан гомдлын шаардлага гаргах хугацааг ялгаж үзэх нь зүйтэй. Хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусахад уг шаардах эрх үүссэн хэвээр байх ба зөвхөн эсрэг тал татгалзах эрх хэрэгжүүлсний улмаас шаардлагыг шүүхээр хэрэгжүүлэх боломж үгүй болдог бол гомдлын шаардлага гаргах хугацаа өнгөрмөгц *шаардах эрх үүсэх* ч бололцоогүй юм. Өөрөөр хэлбэл, гомдлын шаардлага гаргах хугацаа нь шаардлагын агуулгыг үгүйсгэх нөхцөл мөн.

Хөөн хэлэлцэх хугацаа нь ихэвчлэн анхдагч шаардах эрхтэй холбоотой зохицуулагдах бол гомдлын шаардлага гаргах хугацаа нь гол төлөв эрх зүйн байдлыг өөрчлөхөд чиглэдэг хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах эрхэд хамаарна. Мөн зарим тохиолдолд доголдолтой холбоотой эрх үүсэх урьдчилсан нөхцөл болдог. Жишээ нь, ИХ-ийн §§254.6, 349 гэх мэт.

## **Хоёр. Дасгал:**

### **Тохиолдол шинжлэх**

а). Үйлдвэрлэл эрхлэгч Ү нэгэн тавилгын дэлгүүрээс 2004 оны 12 сарын 12-нд албан тасалгаандаа зориулж 200 000 төгрөгөөр нэгэн шүүгээ худалдаж авчээ. Гэрээнээс үүдэлтэй хөөн хэлэлцэх хугацаа хэзээ дуусах вэ? Энэ хугацаа дууссаны дараа үнийг төлсөн бол мөнгөө эргүүлэн авч болох уу?

б). Худалдагч 2007 оны 12 сарын 31-нд хөөн хэлэлцэх хугацаа нь дуусах байсан шаардах эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлсэн бол (ИХ-ийн §123) үүрэг гүйцэтгүүлэгч солигдсоноос үл хамааран дээрх шаардах эрх тухайн өдөр өнгөрөхөд хэрэгжүүлэх боломжгүй болно. Яагаад гэвэл энд ИХ-ийн §81-г баримтлан эрх залгамжлал бий болсноос үл хамааран хөөн хэлэлцэх хугацааг тооцно.

в). Бусдын эд зүйлийг хулгайлсан этгээд өмчлөгчийн шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа буюу 11 жил өнгөрөх үед өөр нэг найздаа эд зүйлийг дамжуулжээ. Энэ нөхцөлд өмчлөгчийн зүгээс шинэ эзэмшигчийн эсрэг эд зүйлийг буцаан шаардах эрх үүсэх боловч гуравдагч этгээд нь хулгайчийн хүсэл зоригийн үндсэн дээр эрх олж авч байгаа тул уг эд зүйлийг эзэмших эрхийг залгамжлан авсан гэж үзэхээр байна. Буцаан шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлно уу.



г). Нэгэн хоолны газрын эзэн Э 2008 оны 1 сарын 1-нд Чингис пивоны үйлдвэртэйгэрээхийхдээ тус үйлдвэрийн пивоноос өөр задгай пиво худалдахгүй хэмээн амлажээ. Гэтэл Э 2009 онд Сапугийн задгай пиво худалдаалах болсон байна. Энэ тохиолдолд уг зөрчлийг арилгуулахад чиглэсэн шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа ямар байх вэ?

д). А нь Б-д 1 сая төгрөг зээлджээ. Талууд 2008 оны 8 сарын 1-ээс гэрээг цуцалж, мөнгөө шаардах боломжтой байхаар тохирсон. Энэ нөхцөлд А дээрх хугацаа өнгөрснөөс хойш гэрээ цуцалсан бол хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ?

е). Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай А-ийн гэм хороос үүдэх шаардах эрхийн (ИХ-ийн §497) хөөн хэлэлцэх хугацаа 2007 оны 8 сарын 31-нд дуусах бөгөөд тэрээр 2007 оны 5 сарын 26 хүртэл хууль ёсны төлөөлөгчгүй байсан. Түүний хууль ёсны төлөөлөгчтэй болсон өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл 3 сар үлдэж байгаа бол тэрээр хэдий хүртэл эрхээ хэрэгжүүлэх боломжтой вэ?

### Гурав. Хяналтын асуулт:

- Хөөн хэлэлцэх хугацаа, гомдлын шаардлага гаргах хугацаа хоёрын эрх зүйн ач холбогдол ялгааг тайлбарлана уу.
- Баталгаат хугацаа, гомдлын шаардлага гаргах хугацаа, тэдгээрийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлана уу.
- Хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох, тасалдах үндэслэл тус бүр дээр жишээ гарган тайлбарлана уу.
- Хөөн хэлэлцэх хугацаанд хамаарахгүй шаардлагуудыг дурдана уу.
- Хугацаа зөрчигдсөнөөс үүсэх үр дагаврыг шийдвэрлэх талаар жишээ гарган тайлбарлана уу.

### Дөрөв. Сорилго:

1. Гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан хэргийг шүүх авч шийдвэрлэх боломжтой юу?

- а. Үгүй. Энэ нь хуульд заасан эрх үгүйсгэх нөхцөл тул болохгүй
- б. Болно. Талууд хүсвэл дээрх хугацаа заасан зохицуулалт хамаагүй

2. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан шаардлагыг шүүхээр хэрэгжүүлж болох уу.

- а. Болно. ИХ-д хариуцагч хүсвэл шаардлагыг хангаж болно гэж заасан.
- б. Үгүй. Шүүх энэ хэргийг шийдэж үл болно.

3. Хөөн хэлэлцэх хугацааг хэдийнээс эхлэн тоолох вэ?

- а. Шаардах эрх үүссэн жил дуусгавар болох мөчөөс
- б. Шаардах эрх үүссэн өдрөөс

- c. Шаардах эрх үүссэн өдрийн дараачийн өдрөөс
- d. Дээрх бүгд зөв

4. Хугацааг тоолох тухай ИХ-ийн §§71-73-д заасан зохицуулалтыг хэдийд хэрэглэх вэ?

- a. Гэрээнд заасан хугацааг тоолоход
- b. Хуульд заасан хугацааг тогтооход
- c. Шүүхээр тогтоосон хугацааг тайлбарлахад
- d. Дээрх бүгд зөв

## Тав. Хэрэглэгдэхүүн

### Сурах бичиг:

1. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
2. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, УБ хот 2013 он
3. Э.Байгал: Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2011 он

### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Д. Энхзул: Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.
2. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж, 1-р хэвлэл, УБ хот 2009 он.
3. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.
4. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж II дэвтэр, УБ хот 2011 он.

### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.
4. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн
5. бүртгэлийн тухай хууль 2002 он
6. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2003 он
7. Компаний тухай хууль 1999 он
8. Нөхөрлөлийн тухай хууль 1994 он
9. Хоршооны тухай хууль 1999 он



## ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН БА ЭДИЙН БУС БАЯЛГИЙН ЭРХ

**Бүлгийн зорилго:** Эдийн ба эдийн бус баялаг, түүний эрх зүйн дэглэм, онцлог, төрөл, ангилалт, эдийн ба эдийн бус баялаг эзэмшигчийн бүрэн эрхийн талаар мэдлэг эзэмших, эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрхээ хэрэгжүүлэх чадвар эзэмших, өмчийн болон эд юмсын эрх зүйг цаашид гүнзгийрүүлэн судлах чиг баримжаатай болох юм.

### Нэг. Тойм лекц


#### Эдийн баялагийн ойлголт

♦ **Өмч гэдгийг нийгмийн харилцаа гэж авч үздэг ба өмчлөгч болох туйлын тодорхой этгээдийн туйлын эрхийг аливаа бусад этгээд хүлээн зөвшөөрч, зөрчихгүй байх үүрэгтэй байдаг нийгмийн харилцаа юм.**

Иргэний хуулийн 99-р зүйлийн 1-д “ Монгол улсад нийтийн ба хувийн өмч байна” гэжээ. Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна. Хувийн өмч нь иргэн, хуулийн этгээдийн, дундын гэсэн хэлбэртэй байна. Нийтийн ба хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно гэж заасан.

Өмчлөх эрх гэдэг нь :

- ♦ Эзэмших
- ♦ Ашиглах
- ♦ Захиран зарцуулах эрхүүдийн нийлбэр юм.



**Өмчлөх эрх үүсгэх анхдагч арга гэдэг нь өмнөх өмчлөгчийн санаа зоригоос үл хамааран өмчлөх эрх олж авах, өмчтэй болох арга юм. Тухайлбал: эд хөрөнгийг нийгэмчлэх ба хувьчлах аргаар, мөн хууль ёсоор өв залгамжлах аргаар өмчлөх эрх олж авах. Иргэний хуульд заасан нэг өвөрмөц, шинэлэг**

зохицуулалт бол "Хуульд өөрөөр заагаагүй бол эзэнгүй үл хөдлөх хөрөнгийг олж авсан өмчлөгч бус этгээд уг эд хөрөнгийн өмчлөгчөөр улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 15 жилийн хугацаанд уг эд хөрөнгийг өмчлөгчийн адил эзэмшиж байсан бол дээрх хугацаа дууссанаар уг этгээд өмчлөх эрхийг олж авна" гэж заасан явдал юм. Эдгээрээс гадна өмчлөх эрх үүсгэх анхдагч аргад дараах аргууд хамаардаг.

- Гээгдэл эд хөрөнгө олж авах
- Эзэнгүй эд юмс олж авах
- Алдуул мал олж авах
- Дарагдмал үнэт зүйл олж авах

**Өмчлөх эрх үүсгэх үүсмэл арга гэдэг нь** өмнөх өмчлөгчийн хүсэл зоригийн дагуу өмчтэй болох аргыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, гэрээ хэлцлийн үндсэн дээр өмчлөх эрхтэй болохыг хэлнэ. Тухайлбал: худалдах, худалдан авах гэрээний үед эд хөрөнгө худалдагчийн зөвшөөрснөөр худалдан авагчид, зээлийн гэрээний үед эд хөрөнгө зээлдүүлэгчийн зөвшөөрлөөр зээлдэгчид шилжинэ. Мөн гэрээслэлээр өв залгамжлах нь өмчлөх эрх олж авах үүсмэл аргын нэг юм. Эдгээрээс гадна эд хөрөнгө шилжүүлсэн, эрх зүйн үйл ажиллагааг баталгаажуулснаар өмчлөх эрх үүсэх үндэслэлийг хуулинд зааж өгсөн.

### **Өмчлөх эрх дуусгавар болох үндэслэл**

- ◆ Өмчлөгч буюу өмчлөх эрхийг хүлээн авах эрх бүхий этгээд тухайн эд хөрөнгийг өмчлөхөөс татгалзсан. Жишээ нь: өвлөгдсөн хөрөнгөөс татгалзах
- ◆ Өмчлөгчийн санаа зоригоос үл хамаарах шалтгаанаар өмчлөлийн зүйл устаж үгүй болсон
- ◆ Өмчлөгч нас барсан, нас барсан гэж зарлагдсан
- ◆ Хуулийн этгээдийн хувьд татан буугдсан буюу дампуурсан

### **Өмчлөх эрхийн хязгаарлалт**

Өмчлөгч эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөх эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно. 2002 онд батласан Монгол Улсын Иргэний хуульд өмчлөгч өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ "эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөх эрхийг хязгаарлах" эрхийн зохицуулалтыг шинээр хуульчилсан байна.

Бусдын өмчлөх эрхийг хязгаарлах үйлдэл нь газар, ус, ой бусад үл хөдлөх хөрөнгийг өмчлөх, ашиглах, захиран зарцуулах, харилцаанд элбэг тохиолдох бөгөөд өмчлөх эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны өвөрмөц нэг хэлбэр юм. Монголд газрын хувьд өмчлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн нь бусдын өмчлөх эрхийг хязгаарлах явдал төр, иргэн, хуулийн этгээд өмчлөх эрхээ хэрэгжүүлэх явцад зайлшгүй үүсэх өмчийн эрх зүйн харилцааны нэг хэсэг болж байна.



Бусдын өмчлөх эрхийг хязгаарлах явцад үүссэн харилцаа нь дараах онцлог шинжүүдийг өөртөө агуулна. Үүнд:

- Тухайн харилцаанд эрхийг хязгаарласан тал, эрх нь хязгаарлагдсан тал гэсэн хоёр этгээд байх зарим тохиолдолд гуравдагч этгээд оролцож болно.

- Өмчлөгч өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийн тулд бусдын өмчлөх эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай болсон, жишээ нь, бусдын өмчлөлийн газраар /хөрсөн дээр буюу доор/ дайрч өнгөрөх засмал ба төмөр зам тавих, зам харгуй, зөрөг гаргах, цахилгаан утас, хийн шугам, сүлжээ, ус суваг хоолой тавих, барилга байгууламж барих зэрэг тохиолдолд хязгаарлаж болно.

- Дээр дурьдсан ажил, үйлчилгээний зорилго нь улс орны аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдал, нийтийн болон эрхийг хязгаарласан талын ашиг сонирхол, хэрэгцээг хангахад чиглэсэн байдаг. Иймд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хязгаарлах, хязгаарлуулах үйл ажиллагаа нь ашгийн төлөө биш байдаг онцлогтой.

- Өмчлөгч өмчлөх эрхээ хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын улмаас хэд хэдэн өмчлөгчийн эрхийг хязгаарлах тохиолдол байж болно. /хэд хэдэн өмчлөгчийн газраар цахилгаан утас, шугам хоолой тавих...../

- Бусдын өмчлөх эрхийг хязгаарлах эрх нь өмчлөгч эд хөрөнгөө худалдаагүй, түрээслэх зэрэг гэрээний хэлбэрээр бусдын эзэмшил, ашиглалтад шилжүүлээгүй зөвхөн эрх нь хязгаарлагдсан этгээдийн өмчлөх эрхийг хязгаарлаж эд хөрөнгөө өөрөө өмчилж, эзэмшиж, ашиглаж байдаг.

- Бусдын өмчлөх эрхийг хязгаарлах эрх зүйн харилцаа нь хууль буюу гэрээний үндсэн дээр үүсдэг. “Монгол улсын иргэн газар өмчлүүлэх” тухай хуулийн 33-р зүйлд сум, дүүргийн засаг дарга улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдол, тухайлбал: газраар дамжин өнгөрөх, газрын заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэг тавих, намагжилтийг багасгах зэрэг ажил гүйцэтгэхэд сервитутаар иргэний газар өмчлөх эрхийг хязгаарлаж болно гэж заажээ. Энэ бол хуулиар газар өмчлөгчийн эрхийг хязгаарлаж болох үндэслэл юм. Иргэд хоорондоо өөрийн өмчийн газар, бусад үл хөдлөх эд хөрөнгийг харилцан тохиролцож аль нэгийгхээ өмчлөх эрхийг хязгаарлаж болно.

Өмчлөх эрхийн хязгаарлалтад:

- Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх
- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг хязгаарлах эрх /сервитут/
- Бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх /узифрукт/
- Барьцааны эрх зэрэг нь хамаарна.

а) Бусдын газар дээр барилга, байгууламж барих эрх нь тодорхой хугацаатай /99 жил/, барилга барих зориулалттай байна. Энэхүү эрхийн хугацаа дуусахад газар өмчлөгч барьсан барилгын нөхөн төлбөрийг өгөх, эсвэл газар эзэмших

эрхийн хугацааг сунгах үүрэгтэй. **Бусдын газар гэдэг нь төрийн өмчийн болон Монгол улсын иргэний хувийн өмчийн газар байна.** Бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийг эзэмшигч энэ эрхээ бусдад худалдах, барьцаалах, бусад хэлбэрээр захиран зарцуулж болдгоороо онцлогтой.

б) Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэх зорилгоор өөр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрхийг сервитут гэнэ. Сервитутыг ашиг олох зорилгоор биш, харин өмчлөгч өөрийн эрхийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаагаар нотлох замаар тогтооно. Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь:

- Бусдын үл хөдлөх хөрөнгө, эд хөрөнгийг тэргүүн ээлжинд хязгаартай ашиглах

- Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг бусад өмчлөгчид даалгах

- Эрх нь хязгаарлагдсан өмчлөгчөөс сервитут бүхий талын үл хөдлөх хөрөнгийн хувьд зарим эрхийг хэрэгжүүлэхийг хязгаарлах замаар сервитут тогтоож болно. Сервитутын харилцаа нь хуульд зааснаар эсхүл гэрээ байгуулж бүртгүүлснээр үүсдэг. Сервитутын харилцаа нь эрх хязгаарласан этгээд болон өмчлөгч нэг этгээд болсон, хугацаа дууссан, сервитут тогтоох зайлшгүй шаардлага арилсан тохиолдолд дуусгавар болно.

с) Узуфрукт гэдэг нь үр шимийг нь хүртэх, ашиг олох зорилгоор бусдын эд хөрөнгийг хязгаартай эзэмшиж, ашиглах эрхийг хэлнэ. Узуфрукт эзэмшигч нь гагцхүү гуравдагч этгээдийн өмчлөлд бүр мөсөн шилжүүлэх замаар захиран зарцуулахаас бусдаар уг эд хөрөнгийг өмчлөгчийн нэгэн адил эзэмшиж, ашиглах эрхтэй ба харин гуравдагч этгээдэд уг эд хөрөнгийг барьцаалах, түрээслэх тохиолдолд өмчлөгчийн зөвшөөрлийг заавал авна. Узуфрукт дуусгавар болоход тухайн эд хөрөнгийн өмчлөгч нь узуфрукт эзэмшигчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний оролцогч болно. Узуфруктыг хариу төлбөртэй ба хариу төлбөргүй, тодорхой ба тодорхой бус хугацаагаар эсвэл узуфрукт эзэмшигчийн бүх насаар нь тогтоож болно.

### Хоёр. Дасгал:

А-гийн газар дээр офисын зориулалттай барилга барихаар Б харилцан тохиролцож гэрээ байгуулжээ. Тэдний тохиролцооны дагуу Б нь барилга барих эрхээ захиран зарцуулахдаа газар өмчлөгчийн зөвшөөрлийг авах ёстой. Б барилга барихаар төлөвлөж С-ээр барилгын зураг төслийг захиалгаар хийлгүүлсэн байна. Гэхдээ Б гадаадад суралцахаар болж өөрийн барилга барих эрхээ, барилгын зураг төслийн хамт Д-д заржээ. Хэсэг хугацааны дараа Д барилгаа барихаар бэлтгэж эхлэх үед газар өмчлөгч болох А надаас зөвшөөрөл аваагүй гэх шалтгаанаар барилга барихыг хориглосон бөгөөд түүний эзэмшилд байгаа барилгын зураг, төсөлтэй яг адилхан барилгыг өрсөлдөгч компани нь барьж эхэлсэн болохыг мэджээ.



- Дээрх тохиолдлоос эдийн болон эдийн бус баялагийн жишээг жагсаана уу.
- Өмчлөгч болон эзэмшигчийг тодорхойлно уу.

### Гурав. Хэрэглэгдэхүүн:

1. МУ-ын Иргэний хууль 2002 он
2. Д.Наранчимэг. “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” I дэвтэр 1999 он
3. Иргэний хууль. шинэлэг зохицуулалт
4. Монгол улсын иргэний хуулийн тайлбар
5. Хуулчийн сорилгын хураамж тестийн эмхэтгэл
6. Т.Мөнхжаргал. “Монгол улсын иргэний эрх зүй” /ерөнхий анги/ 2000 он
7. Ц.Амарсайхан, Д.Цолмон. “Гэрээний эрх зүй” 2002 он
8. Б.Оюунбат. “Иргэний эрх зүйн бодлого, дасгалын хураамж: үүргийн тусгай төрөл” 2002 он
9. Д.Цолмон. “Гэрээний эрх зүй” 2003 он
10. О.Жамбалдорж. “Монгол улсын иргэний эрх зүй” /ерөнхий үндэслэл/ 2004 он
11. GTZ, ХЗДХЯ. “Монгол улсын шинэ иргэний эрх зүй” 2005 он
12. Б.Улаанбаатар. “Иргэний эрх зүй: тайлбар толь” 2005 он
13. О.Жамбалдорж. “Монгол улсын иргэний эрх зүй” II дэвтэр 2006 он
14. Нотариатчдад зориулсан сургалтын материал “Иргэний эрх зүйн зарим асуудал” 2007 он
15. “Монгол улсын иргэний хуулийн тайлбар. Гэрээний эрх зүй 1” 2007 он

## ДОЛДУГААР БҮЛЭГ. ҮҮРГИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

### Сэдэв 7.1.: Үүргийн эрх зүйн тухай ерөнхий ойлголт, ангилал

**Сэдвийн зорилго:** Үүргийн ойлголт, ангилал, үүргийн нийтлэг үндэслэлийн талаар суурь мэдлэг олж авах, үүргийн субъектийг тодорхойлж, гэрээний эрх зүй, гэрээний бус үүргийн эрх зүйн харилцаанд хууль хэрэглэх чадвартай болоход оршино.

#### Нэг. Тойм лекц

##### Үүргийн харилцааны тухай ухагдахуун

Үүргийн эрх зүй нь үүргийн харилцааг үндсээр нь зохицуулдаг **хувийн эрх зүйн үндсэн салбар** билээ. Хувийн эрх зүйн салбар гэдэг утгаараа үүргийн эрх зүй нь тэгш эрх бүхий субъектууд хоорондын ижил түвшний эрх зүйн харилцааг зохицуулдаг<sup>21</sup>. Тиймээс энд нийтийн эрх зүйн салбарт тохиодог шиг захирах, захирагдах харилцаа бий болохгүй.

ИХ-ийн §186-д нэг этгээд нөгөөгөөс тодорхой үйлдэл хийхийг эсвэл эс үйлдэл хийхгүй байхыг шаардах боломжтой нөхцөлд үүргийн харилцаа үүснэ хэмээн тодорхойлсон байдаг. Хувь этгээдүүд хоорондын тусгайлсан харилцаа болох үүргийн харилцаанд оролцогсдыг **үүрэг гүйцэтгэгч** ба **үүрэг гүйцэтгүүлэгч** гэж нэрлэнэ. Үүрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө тодорхой үйл хөдлөл хийх эсвэл хийхгүй байх **үүрэг** хүлээнэ. Ийнхүү үүргийн харилцаа нь үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн хэмжээ хязгаар, хүрээ буюу хийх үйлдлийн агуулга, цар хүрээг тодорхойлж байдаг. Үүрэг гүйцэтгэгчийн үйл хөдлөл, эс үйлдэхүйтэй холбогдон эрх зүйн үүднээс үүрэг гүйцэтгүүлэгчид ихэнх тохиолдолд тодорхой **шаардах эрх** үүснэ. Цөөн тохиолдолд хуулиар шаардах эрх олгохгүй нөхцөл бий.

Нэг этгээд нь нөгөөгийнхөө өмнө тодорхой үйлдэл хийхгүй байх эс үйлдэхүйтэй холбоотой эрхийг *сөрөг эрх* хэмээн тодорхойлох нь элбэг.

##### Хуулийн зохицуулалт ба хэрэглээ:

Үүргийн эрх зүй нь Монгол Улсын ИХ-ийн §§186-538-ыг хамрах ба үүнийг дотор нь үүргийн эрх зүйн ерөнхий, тусгай анги гэсэн хоёр томоохон бүлэгт хувааж үзнэ.

*Үүргийн эрх зүйн тусгай анги* буюу ИХ-ийн §§243-538-д хууль тогтоогч практик амьдралд өргөн тохиолдох үүргийн харилцааг түүвэрлэн тусгасан бөгөөд эдгээр тусгай харилцааны дийлэнхэд нь анхаарвал зохих иргэний эрх

<sup>21</sup> Хувийн эрх зүйн харилцааг нийтийн эрх зүйн харилцаанаас зааглах тухай Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, УБ 2012 он, 18 дахь талаас.



зүйн тогтолцооны чанартай нийтлэг шинжийг Иргэний Хуулийн ерөнхий анги болон үүргийн эрх зүйн ерөнхий ангид **нийтлэг журам** болгон зохицуулжээ. Ийнхүү нийтлэг журмыг багцлах аргыг математикийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг **хаалтын аргачлал** нэрээр тэмдэглэдэг.

Иргэний эрх зүйн цөм нь үүргийн эрх зүй гэж хэлж болох ба энэ нь ерөнхий болон тусгай зохицуулалтын харилцан хамаарал дээр оршиж байдаг. Үүргийн эрх зүйн салбар нь хүмүүсийн хувийн амьдрал нэн ялангуяа, эдийн засгийн харилцаанд хэрэгцээгээ хангахад чиглэсэн суурь зохицуулалтыг агуулна. Үүргийн эрх зүй нь тусгай ангидаа хөрөнгө бүтээх, солилцох үйл явцыг зохицуулдаг худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ зэргээс гадна аливаа этгээдийн үндэслэлгүй хөрөнгөжсөн явдлыг арилгах (ИХ-ийн §492), мөн хүний бие махбодь, үнэт зүйлсэд учирсан хохирлыг арилгах (ИХ-ийн §497) зорилготой хэм хэмжээг тусгасан. Эдгээрт хамаарах ерөнхий зохицуулалтыг ИХ-ийн §§186–242-т *үүргийн эрх зүйн ерөнхий анги* нэртэй байршуулсан ба эдгээрийн дийлэнх нь зөвхөн тодорхой нэг үүргийн харилцаанд бус харин бүх төрлийн, эсвэл хэд хэдэн үүргийн харилцаанд, түүнчлэн хуулиас үүдэх үүргийн хувьд нийтлэг үйлчилнэ.

### **Үүргийн эрх зүйн ерөнхий ангид тусгасан үүргийн нийтлэг зохицуулалт, агуулга**

- ◆ үүргийн харилцаа хэрхэн үүсэх
- ◆ ямар агуулгатай байх
- ◆ үүргийг хэдийд хаана гүйцэтгэх тухай
- ◆ үүргийн харилцаа хэдийд дуусгавар болох
- ◆ хэд хэдэн оролцогч буй бол асуудлыг хэрхэн шийдэх
- ◆ үүргийн зөрчилтэй холбогдон үүсэх нийтлэг эрхүүд
- ◆ хохирлын хэмжээ тогтоох тухай

Иргэний Хууль нь ерөнхийгөөс тусгай руу шилжсэн бүтэцтэй бөгөөд энэ тогтолцоо үүргийн эрх зүйн салбарын хувьд ч нэгэн адил хэрэгжсэн. Тиймээс үүргийн эрх зүйн нийтлэг зохицуулалтыг хувийн эрх зүйн бусад салбарт буй болсон үүргийн харилцаанд тухайлбал ИХ-ийн ерөнхий ангид тусгагдсан цөөн тооны үүргийн харилцаанд эсвэл гэр бүлийн эрх зүйн асран тэтгэх харилцаанд, өвийн эрх зүйн гагцхүү үүрэг үүсгэхэд чиглэсэн зохицуулалтын хүрээнд тус тус үүргийн ерөнхий зохицуулалтыг хэрэглэнэ.

### **Үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүрэг**

Үүргийн харилцаа нь төрөл бүрийн үүргийг араасаа дагуулах боловч эдгээрийг тодорхой шалгуураар ангилж болно. Нэг талаас үндсэн үүрэг, нөгөө талаас дагавар, нэмэлт, онцгой үүрэг, анхаарал болгоомжтой байх ерөнхий үүрэг хэмээн ангилсан байдаг<sup>22</sup>. ИХ-ийн §186-г авч үзвэл гүйцэтгэлд

<sup>22</sup> Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, 2006 он, 617 дахь тал.

чиглэсэн үүрэг болон бусад үүрэг хэмээн ангилах нь зүйтэй. Бусад үүрэгт нэмэлт, дагавар, онцгой үүргийг хамруулна.

**Гүйцэтгэлд чиглэсэн үүрэг** гэдэгт эсрэг талдаа шаардах эрх үүсгэж байдаг бүх үүргийг ойлгоно. Эдгээр нь тус бүрдээ нэхэмжлэлийн зүйл болох ба үйлдэл, эс үйлдэхүйн аль аль нь байх боломжтой, ИХ-ийн §186.

♦ Үүнд юуны өмнө үндсэн үүрэг хамрагдана. **Үндсэн үүрэг** гэдэгт тодорхой үүргийн харилцааг тодорхойлж байдаг гол цөм болох гүйцэтгэлд чиглэсэн үүргүүд багтдаг. Гэрээний үндсэн дээр үүсэх үүргийн харилцаанд эдгээр нь хоёр талын тохиролцооны гол агуулгаар тодорхойлогдох ба энэ тухай аливаа гэрээний хамгийн эхний зохицуулалтад тусгасан байдаг, ИХ-ийн §195.2.

♦ Үндсэн үүргийг дотор нь **гол үүрэг, хариу үүрэг** хэмээн ангилж болно. Хариу үүрэг нь ихэвчлэн мөнгөн төлбөр ба үүнийг орлуулж болох зүйл байдаг бол гол үүрэг нь тус гэрээний мөн чанарыг тодорхойлох, бусдаас ялгах шалгуур болдог. ИХ-ийн §225-ын дээд гарчигт хоёр талт гэрээнд үйлчлэх зохицуулалт гэснээс үзвэл зарим гэрээ нь хоёр талт гэрээ байх ба эдгээрийн хувьд үндсэн үүрэг нь хоорондоо нягт харилцан хамааралтай байдаг (**Сюналагма**<sup>23</sup>).

♦ Үүргийн гүйцэтгэлтэй холбоотой **нэмэлт, дагавар үүрэг** гэдэгт бусад бүхий л гүйцэтгэлийг дэмжих зорилго бүхий *бие даан нэхэмжилж* болох үүргийг хамруулж үзнэ. Үүнд үндсэн үүргийг шударгаар биелүүлэхтэй холбоотой, үүргийн зүйлийг зүй зохистой ашиглах зэрэг үүрэг гүйцэтгүүлэгчийн гүйцэтгэлд чиглэсэн ашиг сонирхол эсвэл өөр бусад бие даасан хувийн ашиг сонирхолд үйлчлэх зорилго бүхий үүргүүд багтана. Ийм төрлийн үүрэг үүссэн эсэх нь тухайн тухайн үүргийн харилцааны онцлогоос хамаарах ба талууд энэ талаар гэрээндээ тусгах боломжтой.

♦ Үүргийн харилцаанд эсрэг талын ашиг сонирхлыг **хамгаалах үүрэг** үүсэх нь бий бөгөөд үүнийг **онцгой үүрэг** хэмээн ИХ-ийн §186.2-т дурьдсан байна. Онцгой үүрэг нь үүргийн агуулга, шинж чанараас хамаарах ба нөгөө талын эрх, эд хөрөнгийг хамгаалах зорилготой.

Гүйцэтгэлд чиглэсэн үндсэн ба нэмэлт үүргүүдээс тодорхой тохиолдолд үүсч болох **хоёрдогч шинжтэй үүргийг** ялгах нь зүйтэй. Эдгээр нь үүргийн харилцаанаас шууд, анхдагч маягаар үүсэхгүй, харин ихэвчлэн эдгээрийн зөрчлийн үр дагавар байдгаараа онцлогтой. Хоёрдогч үүрэг нь зарим тохиолдолд гүйцэтгэлд чиглэсэн үүрэгтэй хамт хэрэгждэг (хугацаа хоцорсноос үүсэх хохирлыг арилгах үүрэг) эсвэл түүнийг орлох чигтэй байж болно.

Дээрх үүргүүдээс гадна үүргийн харилцааны талууд нь өөрсдийн тусын тулд тодорхой үйлдэл хийх үүрэг хүлээж байдаг. Үүнийг “өөрийнхөө өмнө хүлээх үүрэг” гэж үзэж болно. Ийм үүрэг нь зөвхөн холбогдох этгээдийн тусын тулд буй болох бөгөөд нөгөө тал нь үүнийг нэхэмжлэх аргагүй, мөн үүнийг зөрчсөн бол хоёрдогч шаардах эрх үүсэхгүй. Холбогдох этгээд энэ үүргийг

<sup>23</sup> МУ-ын Иргэний эрх зүйн тайлбар толь: 2010 он, 410 дахь тал.



орхигдуулснаар түүнтэй холбоотой эрх зүйн сөрөг үр дагаврыг үүрдэг цорын ганц үр дагавартай.

Үүргийн харилцаа нь хэлцлийн үндсэн дээр, ажил хэргийн харьцаанд эсвэл хуулийн дагуу үүсэх боломжтой.



### Хоёр. Хяналтын асуулт:

- Үүрэг, түүний төрлийг жишээн дээр тайлбарлана уу.
- Үүргийн эрх зүйн харилцаа ба иргэний эрх зүйн бусад төрлийн харилцааны уялдаа холбоог тайлбарлана уу.
- Үүргийг хамтран гүйцэтгэх, үүргийг хэсгээр гүйцэтгэхийн хууль зүйн үр дагаврыг тодорхой тохиолдол дээр тайлбарлана уу.
- Үүрэгт олон этгээд оролцох талаар тохиолдол /кейс/ ажиллаарай

### Гурав. Сорилго:

1. Ямар 3 аргаар үүргийн харилцаа үүсэх боломжтой вэ?
  - a. Гэрээ байгуулах, гэм хор үйлдэх, хэлцэл хийх
  - b. Нэг ба олон талт хэлцэл хийх, хуульд заасан тохиолдлыг биелүүлэх, хэлцэл хийх бэлтгэл үе шатыг эхлүүлснээр
  - c. Гэрээ хэлцэл хийх, гэм хор учруулах, үндэслэлгүй хөрөнгөжих
  - d. Гэрээ байгуулах, хэлэлцээр хийх, гэм хор учруулах

2. Үндсэн үүргийн дагавар, нэмэлт ялгагдах онцлог юу вэ?
  - a. Агуулга, эрх зүйн үр дагаврын хувьд ялгагдана
  - b. Үндсэн үүрэг нь гэрээний гол нөхцөлийг болон үүргийн харилцаа үүсэх зорилгыг тодорхойлдог бол дагавар, нэмэлт үүрэг түүний биелэлтийг хангахад чиглэнэ.
  - c. Үндсэн үүрэг иргэний эрх зүйн тусгай ангид, нэмэлт, дагавар үүргийг үүргийн эрх зүйн ерөнхийангид зохицуулсан байдаг.
  - d. b, c хариулт зөв.
3. Үүргийн харилцаанд тодорхой байх зарчим үйлчлэх үү?
  - a. Тийм, учир нь шаардах эрх нь иргэний эрх зүйн харилцааны объект тул үүний агуулга болж буй үүрэг тодорхой байх ёстой
  - b. Шаардах эрх үүсэх үед аливаа гуравдагч этгээдийн зүгээс агуулгыг төвөггүй тодорхойлох боломжтой байх нь шийдвэр гүйцэтгэлийн үндэс болох тул үүргийн харилцаанд үүсч буй үүрэг нь тодорхой эсвэл тодорхойлох боломжтой байх ёстой
  - c. Тодорхой байх зарчим нь өмчийн эрх зүйн суурь зарчим бөгөөд үүргийн харилцаанд хамаагүй
4. Үүргийн агуулга, хэв шинжийг хэрхэн тодорхойлох вэ?
  - a. Зайлшгүй үйлчлэх хуулийн зохицуулалтыг баримтлах ба ийм зохицуулалт байхгүй бол үүнийг талуудын тохиролцоогоор тодорхойлно
  - b. Дээрхийн аль аль нь байхгүй бол үүргийн ерөнхий ангийн үүрэг гүйцэтгэх арга хэлбэрийг тусгасан диспозитив шинжийн зохицуулалтыг хэрэглэнэ
  - c. Талуудын хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлах замаар
  - d. Дээрх бүгд зөв
5. Үүргийн гүйцэтгэл явагдах болон үүргээ гүйцэтгэх газар гэсэн нэр томъёоны ялгаа?
  - a. Үүргийн гүйцэтгэл явагдах газар гэдэгт үүрэг гүйцэтгэгчийн зүгээс үүргийн гүйцэтгэлд чиглэсэн үйлдэл хийх газрыг ойлгох бол үүрэг гүйцэтгэх газар эцсийн үр дүн гарах тул үүргийг дуусгавар болсон гэж үзэх гол шалгуур болно
  - b. Үүрэг биелүүлэх газар гэдэгт үүрэг гүйцэтгэгчийн зүгээс үүргийн гүйцэтгэлд чиглэсэн үйлдэл хийх газрыг ойлгох бол үүрэг гүйцэтгэх газар нь үүргийг дуусгавар болсон гэж үзэх гол шалгуур болно
  - c. Яг ижил ухагдахуун
  - d. Хуулинд ийнхүү ялган тодорхойлоогүй
6. Үүрэг гүйцэтгэх газрыг хэрхэн тодорхойлохоос шалтгаалан үүргийг ангилна уу.



- a. Илгээх үүрэг, хүргэх үүрэг, очиж хүлээн авах үүрэг
  - b. Нийлүүлэх үүрэг, илгээх үүрэг, тээвэрлэх үүрэг
  - c. Хүлээн авах үүрэг, нийлүүлэх болон илгээх үүрэг
  - d. Дээрх бүгд зөв
7. Үүрэг гүйцэтгэх газрыг тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ?
- a. Эрсдэл шилжих болон үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хэтрүүлэх тохиолдолд, мөн илгээх үүрэг үүссэн нөхцөлд хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг тодорхойлоход
  - b. Эрсдэл шилжих болон хугацаа хэтрүүлсэн гэдгийг тогтооход
  - c. Үүрэг гүйцэтгэх арга хэлбэр, зарчмыг тодорхойлоход
  - d. Үүргийн гүйцэтгэл зохих ёсоор явагдсан эсэхийг дүгнэхэд
8. Үүрэг гүйцэтгэх хугацаа гэдэгт юуг ойлгох вэ?
- a. Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ гүйцэтгэж болох, мөн үүрэг гүйцэтгүүлэгч ийнхүү шаардаж болох мөчийг хэлнэ
  - b. Хууль буюу гэрээнд зааснаар үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээлгэн өгвөл зохих хугацааг ойлгоно
  - c. Гэрээгээр тогтоосон хугацаа
  - d. ИХ-ийн §208-д заасан хугацааг хэлнэ

### Дөрөв. Хэрэглэгдэхүүн:

#### Сурах бичиг:

1. Б.Буянхишиг: Үүргийн эрх зүйн ерөнхий анги, 2013 он.
2. Б.Тэмүүлэн/Д.Энхзул/Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2010 он.
3. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн тусгай анги, УБ хот 2011 он, Анхны хэвлэл
4. О.Жамбалдорж/Ж.Амарсайхан/ Ж.Ариунзаяа: Монгол Улсын Иргэний эрх зүй (Үүргийн эрх зүй, Гэрээний эрх зүй, Үүргийн эрх зүйн зарим тусгай төрөл), III дэвтэр, 2011 он

#### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.
2. Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн бодлогын хураамж, II дэвтэр, 2011 он
3. Д.Энхзул: Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.

#### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он.

## Сэдэв 7.2: Үүргийн гүйцэтгэх зарчим, үүргийн гүйцэтгэлийг хангах арга

**Сэдвийн зорилго:** Үүргийн гүйцэтгэл буюу үүрэг гүйцэтгэх зарчим, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, үүрэг зөрчигдсөнөөс үүсэх хариуцлагын талаар онолын мэдлэг олж авах, үүний үндсэн дээр тэдгээрийг үүргийн тусгай төрлүүдэд тохируулан хэрэглэх дадал эзэмших, үүрэг зөрчигдсөнөөс үүсэх хариуцлагыг хууль зүйн үндэслэлтэй тодорхойлж, хууль хэрэглэх чадвартай болоход оршино.

### Нэг. Лекц

#### Үүргээ шударгаар биелүүлэх зарчим

ИХ-ийн §206-д тусгасан үүрэг гүйцэтгэх зарчмын дагуу зөв үүрэг гүйцэтгэгч нь зөв үүрэг гүйцэтгүүлэгчид тохирсон үүргээ тогтоосон газар, хугацаанд хүлээлгэн өгөх ёстой. Ингэсэн нөхцөлд түүнийг үүргээ зохих ёсоор биелүүлсэн хэмээн үзэх ба тухайн үүрэг нь ИХ-ийн §236.1.1-ийн дагуу дуусгавар болно. Эдгээр нөхцөлийн аль нэг нь биелээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахаас татгалзах боломжтой бөгөөд түүнийг хүлээн авах үүргийн хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй, ИХ-ийн §223.1; энэ тохиолдолд харин үүрэг гүйцэтгэгч өөрөө үүргээ биелүүлэх хугацаа хэтрүүлэх нь элбэг, ИХ-ийн §222.1.

#### Үүргийн гүйцэтгэл

ИХ-ийн §236-д зааснаар үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ биелүүлэхийг *гүйцэтгэл* гэнэ. Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ гүйцэтгэлээ гэж үзэхийн тулд тэрээр өөрийн зүгээс шаардлагатай бүх үйлдлийг хийсэн байх нь чухал биш; тухайлбал, худалдан авагчид эд зүйлийг илгээх зэрэг үүргийн гүйцэтгэлд чиглэсэн *үйлдэл хийсэн эсэх нь гол бус*, харин худалдан авагч эд зүйлийг эзэмших, өмчлөх болсон явдал буюу гэрээгээр хүлээсэн үүрэгт нь дүйцэх тодорхой **эцсийн үр дүн** чухал байдаг. Зөвхөн эл эцсийн үр дүн л үүрэг гүйцэтгүүлэгчийн ашиг сонирхолд нийцнэ.

Үндсэндээ зөв үүрэг гүйцэтгэгч нь зохих үүргийг зөв газар зөв үүрэг гүйцэтгүүлэгчид санал болгосон бол энэ нь үүргээ зохих ёсоор биелүүлсэнд тооцогдож, ИХ-ийн §236-д заасан үр дагавар бий болох ба тэрээр үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэнд тооцогдоно. Үүргийг ИХ-ийн §206-д заасны дагуу шударгаар гүйцэтгэж биелүүлнэ.

Өнөө үед үүргийн гүйцэтгэл бол **зөвхөн бодит үйлдэл** гэж үзэх болсон ба хүлээсэн үүрэгтэй дүйцэх нь илт байх тийм үр дүнг нийлүүлэх явдал чухалд тооцогдох болсон тул гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрсөн тухай хоёр талын тохиролцоог шаардахгүй ба гүйцэтгэлийг явуулахад үүрэг гүйцэтгэгч заавал



иргэний эрх зүйн чадамжтай байх шаардлагагүй.

### **Үүрэг гүйцэтгэх газар**

Үүрэг гүйцэтгэгч үүргийг зөвхөн тогтсон газар гүйцэтгэж байж ИХ-ийн §236-д зааснаар үүргээс чөлөөлөгдөнө. Хэрэв буруу газар гүйцэтгэвэл энэ нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зүгээс үүргийг хүлээн авахаас татгалзах бүрэн эрх олгоно, ИХ-ийн §213.2. Энэ нөхцөлд татгалзсан үүрэг гүйцэтгүүлэгч биш, харин зохих газар гүйцэтгээгүй үүрэг гүйцэтгэгч нь хугацаа хэтрүүлсэнд тооцогдоно.

Үүрэг гүйцэтгэх газрыг хэрхэн тодорхойлох тухай ИХ-ийн §207-д тусгасан бөгөөд энд үүрэг гүйцэтгэхэд чиглэсэн тодорхой **үйлдэл** хийгдэж буй газар чухал биш, зөвхөн эцсийн гүйцэтгэлийн **үр дүн** гарч буй газар нь л гол ач холбогдолтой юм. Эдгээр нь практикт ихэвчлэн нэг газар явагдаж болох ч үүргийн мөн чанараас шалтгаалан хоёр өөр газар явагдах тохиолдол байдаг.

Иргэний Хуульд тусгайлан үүрэг гүйцэтгэх газрыг тогтоож өгөөгүй бол үүнийг талууд ихэвчлэн *гэрээний тохиролцоо*нд тусгах эсвэл нөхцөл байдлаас нь тухайлбал, *үүргийн мөн чанараас* тодорхойлж болно. Үүргийн мөн чанартай холбогдуулан хууль тогтоогч ИХ-ийн §207.1.1-д үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой үүргийг тухайн хөрөнгийн оршин байгаа газарт; ИХ-ийн §207.1.2-т тээвэрлэх үүргийг анхны тээвэрлэгчид хүлээлгэн өгөх газар; ИХ-ийн §207.1.3-т мөнгөн төлбөрийн үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа газар тус тус гүйцэтгэхээр заажээ. Дээрхэд хамаарахгүй үүргийн тухайд гэрээний тохиролцоог авч үзэх ба талууд энэ тухай тохироогүй бол ИХ-ийн §207.1.4-ийг хамгийн сүүлд шалгана.

### **Мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх газар:**

Талууд өөрөөр тохиролцоогүй нөхцөлд мөнгөн төлбөрийг үүрэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа газар гүйцэтгэнэ, ИХ-ийн §207.1.3. Тиймээс эл үүрэг нь *хүргэж өгвөл зохих* үүргийн төрөлд хамаарч байна. Хэрэв үүрэг гүйцэтгэгч мөнгийг шилжүүлсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид очих хүртэлх эрсдэлийг үүрэг гүйцэтгэгч хүлээнэ. Учир нь энд ИХ-ийн §215.2-т зааснаар мөнгөн төлбөрийн үүрэг боломжгүй болно гэсэн ойлголт үгүй.

### **Үүрэг гүйцэтгэх хугацаа**

Үүрэг гүйцэтгэх хугацаа гэдэгт үүрэг гүйцэтгэгч үүргээ *гүйцэтгэж болох хугацаа*наас гадна үүрэг гүйцэтгэвэл зохих *эцсийн хугацаа* гэсэн хоёр ойлголтыг хамруулан ойлгодог. Үүрэг гүйцэтгэх хугацаа нь үүргийн харилцаанд голлох үүрэгтэй байхаар талууд тохирч, үүнээс хойш үүргийг гүйцэтгэх нь үүргийг бүхэлд нь боломжгүй болгож байвал үүнийг **fix гэрээ, хэлцэл** хэмээн тэмдэглэсэн байдаг.

Гэрээгээр талууд ямар хугацаа тохирсон болохыг тохиролцооноос эсвэл тухайн харилцааны нөхцөл байдлаас нь тогтоож болно. Ийнхүү тогтоох боломжгүй нөхцөлд үүрэг гүйцэтгүүлэгч хэдийд ч гүйцэтгэлийг шаардаж болох ба үүрэг гүйцэтгэгч нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй, ИХ-ийн §208.2.

### **Үүрэг гүйцэтгэх арга хэлбэр**

**Биечлэн гүйцэтгэх:** Тухайн гэрээний онцлогоос хамааран үүрэг гүйцэтгэгч үүргээ заавал биечлэн гүйцэтгэх ёсгүй бол тэрээр гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно, ИХ-ийн §210.1. Үүрэг гүйцэтгэгч үүргээ биечлэн гүйцэтгэх ёстой эсэхийг тухайн гэрээний тохиролцоо болон хуулиар зохицуулсан байж болно. Жишээ нь, ИХ-ийн §361. Нөгөө талаас үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд биечлэн гүйцэтгэвэл зохих үүрэг байсан ч оронд нь гуравдагч этгээдийн гүйцэтгэлийг сайн дураараа хүлээн авах боломж бий.

**Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх:** Ихэнх нөхцөлд үүрэг гүйцэтгүүлэгчид хэн гүйцэтгэлийг явуулах нь хамаагүй байх ба ийм тохиолдолд гуравдагч этгээд гүйцэтгэгчээр оролцох боломжтой. Гэхдээ гүйцэтгэлд чиглэсэн үйлдэл хийж буй гуравдагч этгээд бусдын үүргийг гүйцэтгэж байна гэдгээ ил болгох ёстой. Үүнд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардлагагүй. ИХ-д гуравдагч этгээдийн эрх үүргийг янз янзаар тодорхойлжээ.

**Үүрэг гүйцэтгүүлэгчид хандан нийлүүлэх:** Ердийн тохиолдолд үүрэг гүйцэтгэгч нь үүргээ үүрэг гүйцэтгүүлэгчид эсвэл хууль буюу гэрээнд заасан эрх бүхий этгээдэд хандан гүйцэтгэнэ, ИХ-ийн §211.1. Ийнхүү үүргийг хүлээлгэн өгснөөр үүрэг дуусгавар болох ба үүнээс татгалзсан (ИХ-ийн §213.2) эсвэл хүлээн аваагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хэтрүүлсэнд тооцогддог.

**Гуравдагч этгээдэд хандан гүйцэтгэх:** Хэрэв үүрэг гүйцэтгэгч үүргийг гуравдагч этгээдэд хүлээлгэн өгсөн бол гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгч үүнийг зөвшөөрсөн<sup>24</sup> эсвэл эндээс ашиг олсон нөхцөлд үүргийг биелсэнд тооцож, дуусгавар болгоно, ИХ-ийн §236.

**Хэсэгчлэн гүйцэтгэх:** Үүрэг гүйцэтгүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс ИХ-ийн §213-ын дагуу гэрээнд заасан болон үүрэг гүйцэтгүүлэгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх ёсгүй, харин бүхэлд нь гүйцэтгэх ёстой. Бусад тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь хэсэгчилсэн гүйцэтгэлийг хүлээн авахаас татгалзах эрхтэй, ИХ-ийн §213.2.

**Хуурамч гүйцэтгэл:** Үндсэндээ ИХ-ийн §236 нь үүрэг гүйцэтгэгч үүргээ зөвхөн зохих ёсоор биелүүлсэн нөхцөлд үүргээс чөлөөлөгдөхийг заасан бөгөөд тэрээр өөр зүйлийг нийлүүлсэн бол үүрэг гүйцэтгүүлэгч үүнийг зөвшөөрөн хүлээн авсан нөхцөлд л үүрэг дуусгавар болно, ИХ-ийн §236.1.2.

<sup>24</sup> Зөвшөөрлийг урьдчилан эсвэл хожим олгох тухай Б.Буянхишиг: Иргэний эрх зүйн удиртгал, 2012 он, **56-161 дэх тал**.



### **Үүргийн гүйцэтгэлийг хангах аргад аргууд:**

- Анз /торгууль, алданги/ нь гэрээний харилцаанд нийтлэг, түгээмэл ордог үүргийн гүйцэтгэлийг хангах арга.

- Дэнчин - гэрээнд оролцогч тал нь гэрээ байгуулсны нотолгоо болгож нөгөө талдаа төлбөл зохих төлбөрт оролцуулан урьчилан өгсөн мөнгө

- Баталгаа-үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээдээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээж буй, үл маргах журмаар биелүүлэх үүргийг хэлдэг. Баталгаа нь үндсэн үүргээс хамааралгүй бие даасан байдалтай байдаг ба үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсон нь баталгааг дуусгавар болгох үндэслэл болдоггүйгээрээ батлан даалт болон бусад үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудаас ялгагдана. ИХ-ийн §457-д зохицуулсан банкны баталгаа нь холбогдох банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүрэг гүйцэтгэгчийн өрийг үндсэн өр, шаардлага буй эсэхээс үл хамааран үүргийг хүлээхээр амлаж буй нэг талын гэрээ байдаг. Энэ нь ИХ-ийн §231.1.3-т тусгагдсан үүргийн гүйцэтгэлийг хангах нэг арга мөн. Баталгаа гаргаж буй этгээд нь банк биш нөхцөлд ИХ-ийн §234-т заасан ердийн баталгааны гэрээ байгуулагдана.

- Барьцаа - үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдсан үүргийг хууль буюу гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчээс тэргүүн ээлжинд барьцааны зүйлийг борлуулах замаар шаардлагаа хангуулдаг. Барьцаа нь бусад үүргийн гүйцэтгэлийг хангах аргатай харьцуулахад барьцаалуулагч ба эд хөрөнгийн харилцаанд тулгуурлах тул өмчийн эрх зүйн шинжтэй.

- Батлан даалтын гэрээ нь зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах хэрэгсэл болно, ИХ-ийн §227.1.5. Энэ гэрээний зорилго нь батлан даагчийн амлалтаар гуравдагч этгээдэд зээл олгох тэр боломжийг нээх явдал. Батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үндсэн үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй нөхцөлд түүний өмнөөс хариуцлага хүлээхээр амладаг ажээ, ИХ-ийн §458.1.

- Фидуци нь ИХ-ийн §231.1.6-д заасан үүргийн гүйцэтгэлийг хангах арга бөгөөд үүрэг гүйцэтгэгч нь өөрийн өмчлөлийн зүйлээ өр, зээлийн баталгаа болгож, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх нөхцөлд хэрэглэгдэнэ. Фидуцийн гэрээгээр талууд үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож, эд хөрөнгө өмчлөх эрхийг үүрэг гүйцэтгүүлэгчид ямарваа нэг болзолгүйгээр шилжүүлэх ба үүрэг гүйцэтгэгчид өмчөө буцаан шилжүүлэн авах эрхийг олгосон.

### **Хоёр. Хяналтын асуулт:**

- Өгөгдсөн тохиолдол дээр ажиллан үүргийн эрх зүйн ямар, ямар зарчим баримтлан ажиллах ёстой, ямар зарчмыг зөрчсөн болохыг тайлбарлана уу.

- Үүрэг гүйцэтгэх арга, газар, хугацаа сэдвээр тодорхой тохиолдол /кейс/ ажиллаарай.
- Үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудын нийтлэг онцлог, шинжийг тайлбарлана уу.
- Үүргийн гүйцэтгэлийг хангах хуульд заасан бусад аргуудыг тодорхойлж, хэрэглэх тохиолдлыг нэрлэнэ үү.
- Үүргийн тусгай төрлүүдэд үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудыг хэргэлэх, тохиолдол /кейс/ ажиллаарай
- Үүрэг зөрчигдсөнөөс үүсэх хариуцлага, хүлээлгэх үндэслэлээр тохиолдол /кейс/ ажиллаарай

## Дөрөв. Хэрэглэгдэхүүн:

### Сурах бичиг, тайлбар толь, өгүүлэл:

5. О.Жамбалдорж. /Ж.Амарсайхан/ Ж.Ариунзаяа: Монгол Улсын Иргэний эрх зүй (Үүргийн эрх зүй, Гэрээний эрх зүй, Үүргийн эрх зүйн зарим тусгай төрөл), III дэвтэр, 2011 он
6. Б.Буянхишиг. Үүргийн эрх зүйн ерөнхий анги, 2013 он.
7. ГТХН-ээс эрхлэн гаргасан Иргэний Хуулийн тайлбар толь: Гэрээний эрх зүй, Улаанбаатар хот 2009 он
8. Баттуяа.Ж. “Англо- Саксоны эрх зүй дэх хөрөнгийн барьцааны ойлголт, төрөл, баталгаажуулалт” “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. ХЗҮТ. 2003 он. №2

### Гарын авлага, бодлогын хураамж:

4. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.
5. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, II дэвтэр, 2011 он
6. Д.Энхзул. Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.

### Хууль тогтоомж, шүүхийн практик:

5. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
6. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
8. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн
10. бүртгэлийн тухай хууль 2002 он
11. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2003 он
12. Компаний тухай хууль 1999 он
13. Нөхөрлөлийн тухай хууль 1994 он
14. Хоршооны тухай хууль 1999 он



### Сэдэв 7.3.: Гэрээний бус үүрэг, түүний төрөл

**Сэдвийн зорилго:** Гэрээний бус үүргийн ойлголт, ангилалтын талаар онолын мэдлэг олж авах, гэрээний болон гэрээний бус үүрэг, гэрээний бус үүргийн тодорхой төрлүүд болох хуульд зааснаар үүсэх үүрэг, зөрчлийн улмаас үүсэх үүргийг харьцуулж дүгнэх, энэ үндсэн дээр тодорхой тохиолдол дээр хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах дадал, хууль хэрэглэх чадвар эзэмшинэ.

#### Нэг. Тойм лекц

##### Гэрээний бус үүргийн харилцаа

Гэрээний бус үүргийн харилцаа нь хуульд заасан бүрэлдэхүүн биелсэн тохиолдолд үүсэх ба хууль тогтоогч Иргэний Хуулийн §§487-514-т эрх зүйн үр дагаврыг тусгасан. Талуудын хүсэл зоригоос буюу хэлцэл хийсэн эсэхээс үл хамааран дээрх харилцаа үүсдэгээрээ гэрээний үүргээс ялгаатай.

Тухайлбал, ИХ-ийн §8.1.1-д заасан хэлцэл суурьтай буюу гэрээний эрх зүйн харилцаа үүсээгүй нөхцөлд аливаа этгээдийн тодорхой эрх, үнэт зүйлсэд халдсаны улмаас учирсан хохирлыг гэм хорын эрх зүйн зохицуулалтаар арилгана. Гэм хорын эрх зүй нь нийт зургаан хэсгээс бүрдэх уг хуулийн **IV хэсэг** буюу **Гэрээний бус үүрэг** (хуулинд заасан нөхцөл бүрдсэнээр үүрэг үүсэх) гэсэн бүлэгт хамрагдах бөгөөд дээрх бүлгийн **II дэд хэсэгт** зохицуулагдсан байна.

Ийнхүү бусдын эрхэнд халдсан нөхцөлд холбогдох этгээд хуульд зааснаар хохирол арилгах үүрэг хүлээх буюу түүний үйлдэл **гэм хорын нийтлэг** болон *тусгай* зохицуулалтын урьдчилсан нөхцөлүүдийг бүрдүүлж буй тохиолдолд талуудын хооронд ИХ-ийн §8.1.5-д зааснаар гэрээний бус үүргийн шинжтэй иргэний эрх зүйн харилцаа үүснэ.

Дээрхээс гадна бусдын өмчлөх эрхийг хуулиар хамгаалах тул аль ч хөрөнгийн шилжүүлэг өмчлөгчийн зөвшөөрлөөр явагдах ёстой. Харин холбогдох эд хөрөнгө, эрхийн эзний зөвшөөрөлгүй, хууль бусаар шилжсэн хөрөнгийг хууль тогтоогч буцааж эзэнд нь олгохоор ИХ-ийн §§492-496-д заасан тул энд ИХ-ийн §8.1.6-д дурьдсан *үндэслэлгүй хөрөнгөжсөнтэй* холбоотой гэрээний бус үүргийн шинжтэй иргэний эрх зүйн харилцаа үүснэ.

Түүнчлэн хэн нэгэн өөр этгээдийн даалгавар, захиалгагүйгээр өмнөөс нь ямар нэг үйлдэл хийсэн бол тэдний хооронд мөн ИХ-ийн §491.1-д заасан *бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэсэнтэй холбоотой* гэрээний бус үүргийн харилцаа үүснэ. Мөн иргэний эрх зүйн харилцаанд оролцогсдын үйл ажиллагааны улмаас дундын өмч бий болсон бол уг өмчийг удирдан зохицуулахтай холбоотой гэрээний бус үүргийн харилцаа үүснэ. Эдгээр нь иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд заасан бусад үндэслэл гэдэгт хамаарна, ИХ-ийн §8.1.8.

### **Дундаа хэсгээр өмчлөх нөхцөлд үүсэх үүрэг**

ИХ-ийн §§487-490 нь хэд хэдэн этгээдүүд тодорхой хөрөнгийг хамтдаа эзэмших нэгдмэл эрх эдлэх нөхцөлд хэрэглэгдэнэ. Дундаа хамтран өмчлөх эрх зүйн харилцаа үүсдэг иргэний эрх зүйн тусгай салбар гэдэгт хамтран ажиллах гэрээ, гэр бүлийн дундын өмч үүссэн тохиолдол болон өв залгамжлагчид хоорондын хөрөнгийн харилцаа бий болохыг ойлгоно.

Хэд хэдэн этгээд тодорхой эд хөрөнгө, эрх, тэдгээрийн нэгдлийг хамтран өмчлөхөөс бусад тохиолдолд дундаа хэсгээр өмчлөх эрх зүйн харилцаа үүснэ. Зарим тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дундаа хамтран өмчлөх харилцаа үүсгэх боломжтой тул эхлээд дээрх 3 тохиолдол, мөн бусад хэлцлийн үндсэн дээр хамтран өмчлөх хэлбэр бий эсэхийг шалгана. Эдгээр нөхцөл бүрдээгүй бол хэд хэдэн этгээдийн зүгээс нэг эрх, эд хөрөнгө эзэмших процессын ИХ-ийн §§487-д тусгагдсан дундаа хэсгээр өмчлөх харилцаа хэмээн дүгнэх боломжтой.

Үндсэн жишээ нь ИХ-ийн §§119, 120, 121-д тусгагдсан эд зүйлийг холих, нийлэх, дахин боловсруулах замаар хэд хэдэн этгээдийн өмч хөрөнгө нэгдэх үзэгдэл болдог. Түүнчлэн энд бусдын өмчийн газар нутгаас дарагдмал үнэт зүйл олох, шинээр эд зүйлийг хамтран бүтээх зэргийг хамруулна. Харин хэд хэдэн этгээд нэгдэж, хэлцлийн үндсэн дээр хөрөнгө олж авах нөхцөлд тодорхой хамтын зорилго тохироогүй бол дундаа хэсгээр өмчлөх харилцаа үүснэ.

Дундын өмчийг хуульд заасан хэлбэрээр олж авсан (ИХ-ийн §§119, 120, 121) эсвэл хэлцлийн үндсэн дээр шилжүүлж авсан эсэхээс үл хамааран дундаа хэсгээр өмчлөгсөд хоорондын **үүргийн харилцаа** ИХ-ийн §487-р тодорхойлогдоно. Харин өмчийн эрх зүйн үүднээс ИХ-ийн §108-ыг анхаарах нь зүйтэй. Хамтын өмч бий болох процесс нь өөрөө хуулиас үүдэх үүргийн харилцааны эх болдог. Гэхдээ талууд энэхүү үүргийн харилцаанд ноогдох эрх үүргийг гэрээндээ өөрөөр тохирсон байх боломжтой.

### **Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх**

Үүрэг гүйцэтгэгч нь бусдын үүргийг даалгаваргүйгээр өөрөөр хэлбэл, оролцогсдын хооронд ИХ-ийн §8-д заасан ямар нэг иргэний *эрх зүйн харилцаа үүсээгүй* тохиолдолд гүйцэтгэсэн бол ИХ-ийн §491.6-ийн дагуу гарсан зардлаа нэхэмжлэх нь шударга билээ.

Энэхүү зохицуулалтыг хуульд оруулснаар аливаа этгээд бусдын эрх зүйн хариуцлагын хүрээнд багтах үйлдлийг хийсэн онцгой нөхцөлд үйлдэл хийгчийн ашиг сонирхлыг нь хамгаалах боломж бүрдэнэ. Энэ тохиолдолд туслалцаа үзүүлсэн этгээдийг харж үзэх, зардал, эрсдлийг эрх ашиг нь хамгаалагдсан этгээдэд оноох нь зүйтэй. Гэхдээ нөгөө талаас мэдээж хүний хүсэл зоригийн эсрэг дур мэдэн түүний ашиг сонирхлын төлөө гэж үзсэн үйлдэл бүхэнд нөхөн олговор олгох боломжгүй юм. Үндсэндээ хүн бүр өөрийн асуудлыг өөрөө шийдэх боловч онцгой нөхцөл бүрдсэн тохиолдолд бусдын үүргийг гүйцэтгэх, ингэхдээ



гарсан зардлаа төлүүлэх нь шударга бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн байна.

ИХ-ийн §491-д бусдын төлөө гүйцэтгэсэн үйлдэл нь түүний ашиг сонирхолд нийцэх, үл нийцэх хоёр тохиолдлыг зохицуулсан байна. Өөр этгээдийн ашиг сонирхолд нийцсэн үйлдлийг даалгаваргүйгээр гүйцэтгэсэн ба энэ нь холбогдох этгээдийн бодит хүсэл зоригт нийцэх нь тогтоогдсон, нөхцөлд ИХ-ийн §§491.2/6, 186.1.-д заасан гэрээний бус үүргийн харилцаа үүснэ. Энэ нь ИХ-ийн §492-ын хувьд хөрөнгийг авч үлдэх зөвшөөрлийг орлох эрх зүйн үндэслэл болно.

ИХ-ийн §491.7-д үүргийн гүйцэтгэл ашиг сонирхлоо хамгаалуулсан этгээдийн хүсэл зориг, ашиг сонирхолд нийцэхгүй байх тохиолдлыг зохицуулсан бөгөөд тухайн үйлдэл хийсэн этгээд сайн мэдсэн хирнээ өөр бусад шалтгааны улмаас уг үйлдлийг гүйцэтгэсэн бол тэрээр өөрөө учирсан хохирлыг арилгах үүрэгтэй болно.

Харин үйлдэл хийсэн этгээд *андуурч* өөрийнхөө үүргийг гүйцэтгэсэн бол ИХ-ийн §491-г хэрэглэхгүй. Дур зоргоороо аашилж өөрийн үүргийг гүйцэтгэсэн ч гэсэн бусдын үүргийг давхар гүйцэтгэж байгаа тухайгаа мэдэж уг үйлдлийг хийсэн тохиолдолд ИХ-ийн §491-г хэрэглэх боломжтой.

#### ♦ Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх ердийн тохиолдол

Ердийн тохиолдолд бусдын үүргийг холбогдох этгээдээс ямар нэг даалгавар, хүсэлт, захиалгагүйгээр гүйцэтгэсэн ба эл үйлдэл нь нөгөө талын ашиг сонирхолд нийцсэн бол тэдгээр этгээдүүдийн хооронд ИХ-ийн §491.1-6-д заасан хуулиас үүдэх үүрэг үүснэ. Энэхүү хуулиас үүдэх үүргийн харилцаанд үүрэг гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Гүйцэтгэлийн тайлан гаргах, ИХ-ийн §491.5
- Боломж гармагц эрх ашгийг нь хамгаалж буй этгээдэд өөрийн үйлдлийн талаар мэдэгдэх, ИХ-ийн §491.4
- Бусдын үүргийг зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх үүрэг, ИХ-ийн §491.1 тус тус хамаарна.

Эдгээр хуульд заасан үүрэг нь үүрэг гүйцэтгэгчийн зүгээс эрхийн эзэнд хандан зайлшгүй зардлаа нөхөн төлүүлэх эрхийг (ИХ-ийн §491.6) баталгаажуулах, мөн ашиг сонирхлоо хамгаалуулж буй этгээдийг зүй бус гүйцэтгэлээс сэргийлэх зорилготой. Эрхийн эзэн буюу үүрэг гүйцэтгүүлэгч нь олсон бүх ашгийг шаардах эрхтэй, ИХ-ийн §491.5.

#### ♦ Бусдын хүсэл зоригт үл нийцэх тохиолдол

Аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүй нь бусдын хүсэл зоригт үл нийцэх тохиолдолд тус үйлдлийг хийх эрх зүйн үндэслэл үгүй байсан хэмээн үзнэ. Жинхэнэ эзний бодит хүсэл зориг, ашиг сонирхолд үл нийцэх тохиолдолд эсвэл тэрээр ИХ-ийн §491.4-т зааснаар зөвшөөрөл олгохоос татгалзсан нөхцөл нь эрх зүйн үндэслэлгүй үйлдэл болсон гэж үзэхэд хүргэнэ. Энэ тохиолдолд үйлдэл хийсэн этгээд болон нөгөө талын хооронд ИХ-ийн §491-д заасан хуулиас үүдэх үүргийн харилцаа үүсэхгүй.

Гагцхүү учирсан хохирлыг ИХ-ийн §491.7-д зааснаар нөгөө этгээдээ гаргуулах бөгөөд өөрийн үйл ажиллагааны зардлыг нөхөн төлүүлэх эрхгүй. Мэдээж энэхүү хохирол шаардах эрхийн зэрэгцээ гэм хорын эрх зүйгээр хамгаалагдсан эрхийн зөрчил буй бол ИХ-ийн §497-г тусад нь шалгах бүрэн боломжтой.

## Гэм хорын эрх зүй

Бусдын эрхийг зөрчсөн гэм буруутай үйлдлийн улмаас хохирол амссан этгээд үр дагаврыг гэм хорын эрх зүйн зохицуулалтын дагуу арилгуулах эрхтэй байх ба үүнийг зөрчлийн улмаас үүсэх үүрэг хэмээн нэрлэх нь бий. Эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлага нь ихэвчлэн хууль бус гэм буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэхэд чиглэнэ. Зөрчлийн улмаас үүсэх үүргийг үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой эрх зүйн зохицуулалттай харьцуулахад аливаа хөрөнгийн шилжүүлгийг буцаах бус, харин гэм хор учруулсан үйлдлийн улмаас үүссэн хохирлыг арилгуулах зорилготой.

Харин гэрээ, хэлцлийн хүрээнд хүлээсэн үүргээ зөрчсөн нөхцөлд гэрээнээс үүдэлтэй хохирол нөхөн төлөх үүрэг (ИХ-ийн §219 г.м.) үүснэ. Гэрээний үүргийн зөрчил давхар гэм хорын шинжтэй бол ИХ-ийн §497-г зэрэгцүүлэн шалгах бүрэн боломжтой. Ийнхүү нэг нэхэмжлэлийг эрх зүйн хувьд хоёр шаардах эрхээр үндэслэхийг *шаардах эрхийн өрсөлдөөн* гэсэн ойлголтоор тэмдэглэдэг.

Эрх зүйн тогтолцоонд хэн ч халдаж үл болох эрхүүдийг төгс хамгаалах зорилгоор хууль тогтоогч эдгээрт халдахыг хувийн болон нийтийн эрх зүйн хууль тогтоомжоор тал бүрээс нь хориглосон байх ба энэ хоригийг давсан үйлдлийг эрх зүйн **зөрчил** гэнэ. ИХ-нд ийм зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох тогтолцоог тусгасан байх ба зөрчлөөс үүдэн хохирол бий болох явдлыг **гэм хор учруулах** хэмээн нэрлэсэн. Зөрчил нь холбогдох этгээдийн гэм буруутай үйлдлээр нөхцөлдсөн байхаас гадна **гэм буруугаас үл хамааран** бусдыг аюулд оруулсан нөхцөлд ч яригдах тул гэм хорын эрх зүй нь бусдад аюул учруулсан үйлдлээс үүсэх үүргийг хамарна.

Тухайлбал, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулсан боловч үйл ажиллагаа нь бусдад аюул учруулж болохуйц байсан, үр дүнд нь хохирол үүссэн бол үүнийг эрхэлж буй этгээд гэм хорыг арилгах нөхөн төлөх үүрэгтэй. Жишээ нь, атомын цахилгаан станц ажиллуулах, агаарын тээврийн хэрэгсэл ашиглах зэрэг аюултай үйл ажиллагаа эрхлэх үед гарсан хохирлыг холбогдох этгээд хариуцах тухай зүйл заалт гэм хорын эрх зүйд бий.

## Гэм хорын эрх зүйн шаардах эрх

ИХ-ийн §497.1 нь гэм хорын эрх зүйн нийтлэг хэрэглэх ерөнхий зохицуулалт бөгөөд үүнээс гадна ИХ-ийн §§498-514-д тодорхой тохиолдолд сонгож хэрэглэх тусгай зохицуулалтыг нэг бүрчлэн тусгасан. Тиймээс гэм хорын эрх зүйн



шаардах эрхүүд нь нилээд хэдэн тусгай зохицуулалт, нэг ерөнхий хэм хэмжээнээс бүрдэнэ гэж үздэг.

Ерөнхий шаардах эрх нь бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд гэм хор учруулсан нөхцөлд хэрэглэх **ерөнхий үндэслэл** болох ИХ-ийн §497.1; **тусгай** шаардах эрхүүдэд ажил олгогчийн хариуцлага - ИХ-ийн §498; тээврийн хэрэгсэл ашигласнаас үүдэх хариуцлага - ИХ-ийн §499; барилга, байгууламжийн өмчлөгч, эзэмшигчийн хариуцлага - ИХ-ийн §500; амьтны учруулсан гэм хорыг өмчлөгч, эзэмшигч хариуцах - ИХ-ийн §501; аюултай үйл ажиллагаанаас үүдэх хариуцлага - ИХ-ийн §502; үйлдвэрлэгчийн болон ажил үйлчилгээ санал болгогчийн хариуцлага - ИХ-ийн §512 зэрэг багтана.

### **Үндэслэлгүй хөрөнгөжих**

ИХ-ийн §§492-496 нь холбогдох эзний зөвшөөрөлгүй, хууль бусаар олж авсан хөрөнгийг буцааж эзэнд нь олгох зорилготой бөгөөд Ромын эрх зүйн **“condictio”** хэмээх эрх зүйн арга хэрэглүүрээс үүдэлтэй. Энэ зарчмын дагуу аливаа хөрөнгийн эрх зөвхөн түүний эзний зөвшөөрлийн үндсэн дээр л бусдад шилжих боломжтой бөгөөд ингээгүй тохиолдолд шилжүүлгийг эрх зүйн үндэслэлгүй гэж үзэх тул тус хөрөнгийг эзэнд нь буцаан олгох ёстой болдог. Энэхүү зарчмын үзэл баримтлалыг өнөө үед дэлхийн дийлэнх улс орон иргэний хуулиндаа тусгаад байгаа<sup>25</sup> бөгөөд эрх зүйн шинжлэх ухаанд **“condictio”** хэмээн тэмдэглэгдсээр байна.

Дээрх зарчим шууд тусгалаа олсон үндсэн зохицуулалт нь ИХ-ийн §492 болох бөгөөд түүхэн хөгжлийнхөө явцад талуудын эрх ашгийг илүү нарийн тусгасан бусад хэм хэмжээгээр баяжиж иржээ. Үндсэндээ бусдын хөрөнгийг шилжүүлж авсан этгээд нь хөрөнгийн эзний зөвшөөрлийг **үүргийн суурь хэлцлийн** хэлбэрээр аваагүй, зөвшөөрөл олгосон ч энэ нь хүчин төгөлдөр бус бол тэрээр хөрөнгийг эзэнд нь буцааж өгөх үүрэгтэй хэмээн энд тусгасан. Энэ нь **шууд утгаараа** оролцогчдын хооронд хийгдсэн хэлцэл ИХ-ийн §56-д заасан үндэслэлээр анхнаасаа хүчингүй (үүрэг үүсээгүй); эсвэл талууд харилцан тохиролцож үүргээс чөлөөлсөн (дуусгавар болсон<sup>26</sup>) болон хэлцэл ИХ-ийн §§58-60, 57.2-т зааснаар хүчин төгөлдөр бус болсон **гурван** тохиолдлыг хамарч байна. Мөн эдгээрээс гадна ИХ-ийн §492.1.1-д буй **“үүрэг үүсээгүй”, “хөрөнгө олж авсан”** гэсэн хэсгийг утга зүйн үүднээс нь **тайлбарлавал** хөрөнгийг хэлцлийн үндсэн дээр шилжүүлснээс гадна бусад байдлаар шилжсэн тохиолдлыг хамрах нь харагддаг.

Хүчингүй гэрээг хүчинтэй гэж итгэсний үндсэн дээр хөрөнгө шилжүүлсэн болон ерөөсөө хэлэлцээр хийгдээгүй, хоёр тал уулзаагүй байхад хөрөнгө нь

<sup>25</sup> Австрийн Иргэний Хуулийн 62-р зүйл; ХБНГУ-ын Иргэний Хуулийн §§812-822, ОХУ-ын Иргэний кодексийн §§1102-1109.

<sup>26</sup> Энд үүргийн ерөнхий ангийн үүрэг дуусгавар болохтой холбоотой ИХ-ийн §§236-240 хамаарахгүй.

ямар нэг байдлаар бусдад шилжсэн хоёр тохиолдол практик амьдралд ялгаагүй; эрх зүйн үүднээс ч ИХ-ийн §492-ын үг хэллэгт тусгагдсан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэх нэг тохиолдол юм. Тиймээс ИХ-ийн §492-т тусгагдсан үндэслэлүүдийг нэгдүгээрт, үг хэллэг болон утга зүйн хувьд хөрөнгийн эзний ухамсартай үйлдлээр хөрөнгөө шилжүүлсэн тохиолдол (**шилжүүлгийн улмаас хөрөнгөжсөн**), хоёрдугаарт, өөр этгээд хөрөнгийг **бусад байдлаар олж авсан** тохиолдол хэмээн хоёр ангилж болно. Ромын эрх зүйд эхнийхийг “**condictio indebiti**”, сүүлчийнхийг “**condictio ob rem**” хэмээн нэрлэж байжээ. Эхний тохиолдолд суурь хэлцэл /causa буюу каузаль хэлцэл/ хүчингүй байх нөхцөлд (ИХ-ийн §§56-60) хөрөнгийг буцаан олгох үндэслэл байх бол хоёр дахь нь ерөөсөө суурь хэлцэл байхгүй тохиолдлыг хамардаг.

### Үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой шаардах эрхийн агуулга

ИХ-ийн §492.1-ийн дагуу бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилгоор хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд нь суурь хэлцэл хүчингүй бол энэхүү хөрөнгөө буцааж авах эрхтэй гэсэн байна. ИХ-ийн §492.1 нь бүлгийн үндсэн зохицуулалт бөгөөд нэхэмжлэгч этгээд (II) хариуцагчийн шилжүүлгийн улмаас (III) үндэслэлгүйгээр (I) хөрөнгө олж авсан байхыг шаардах тул урьдчилсан нөхцөлийг үүний дагуу тодорхойлдог.

ИХ-ийн §493-т хууль тогтоогч ИХ-ийн §492-т заасан хэд хэдэн шаардах эрхийн хэмжээг тодорхойлсон байна. Энд зааснаар үндэслэлгүй хөрөнгөжсөн этгээдийн хариуцлагын хэлбэрийг “хөрөнгө нь нэмэгдсэн” хэвээр бий эсэхийг нотолж чадах эсэхээс хамааран *ердийн* болон *чангатгасан хэлбэр* хэмээн хоёр ангилж болно, §493.4. Хэрэв холбогдох этгээд нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой шаардах эрх хэрэгжүүлэх эрхтэй нь тогтоогдвол хариуцагч хөрөнгийг буцаан шилжүүлэх үүрэгтэй, ИХ-ийн §493.1. Хэрэв уг хөрөнгийг буцаан олгох боломжгүй бол нөхөн төлбөрт авах зүйлийг эсвэл үнийг төлөх гэх мэт өргөтгөсөн хариуцлага хүлээнэ.

Хариуцагч юуны өмнө шилжүүлж эсвэл олж авсан зүйлээ бодитоор нь буцаан олгох үүрэг хүлээнэ. Энэ зарчим нь ИХ-ийн §§492, 494-т хамааралтай ч ИХ-ийн §§495, 496-ийн хувьд шаардах эрх нь анхнаасаа орыг нь олгоход чиглэсэн байдаг тул хэрэглэгдэхгүй. Тухайлбал, эрх зүйн үндэслэлгүй олж авсан эд хөрөнгийг нэхэмжлэгчид буцаан өгөх, шаардах эрхийг буцаан шилжүүлэх үүрэгтэй нь тогтоогдвол тэдгээрийн өмчлөх эрхийг, эзэмшлийн хамт бүхэлд нь шилжүүлэх замаар гүйцэтгэнэ. Харин шууд эзэмшлийг буцаах үүрэгтэй нь тогтоогдвол зөвхөн бодит эзэмшлийг шилжүүлэх г.м. Түүнээс гадна ИХ-ийн §493.1-д шилжүүлсэн эд хөрөнгөөс олсон орлого, үр шимийг мөн адил буцаан шилжүүлнэ гэсэн байна. Эдгээрийг ИХ-ийн §88.2-ыг баримтлан тогтооно.



### Хоёр. Хяналтын асуулт:

- Гэм хорын эрх зүйн зохицуулалтын зорилгыг тодорхойлно уу.
- Хуульд зааснаар үүсэх үүрэг, үр дагаврыг тодорхойлно уу.
- Дундын өмчөөс үүсэх үүрэг, бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнөөс үүсэх үүрэг сэдвээр тохиолдол /кейс/ ажиллаарай.
- Үүргийн тусгай төрлийг ангилах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно уу.
- Гэрээний болон гэрээний бус үүргийн онцлогийг тайлбарлана уу.
- Гэрээний болон гэрээний бус үүргийг ангилах хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг тайлбарлана уу.
- Өгөгдсөн тохиолдол дээр ажиллан гэрээний болон гэрээний бус үүргийг ялган тайлбарлаж, маргааныг шийдвэрлэж хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргана уу.
- Гэрээний болон гэрээний бус үүргийг харьцуулан бүдүүвчээр харуулна уу.

### Гурав. Сорилго

1. МУ-ын ИХ дахь гэм хорын эрх зүйд тоочих зарчмыг эрхэм болгосон уу эсвэл ерөнхий зохицуулалтаар гэм хор учруулсан бүх тохиолдлыг хамруулан зохицуулсан уу?
  - a. Тодорхой тохиолдолд хариуцлага хүлээлгэх тусгай зохицуулалтыг тоочих замаар тусгасан.
  - b. Ерөнхий зохицуулалтаар гэм хор учруулсан бүх тохиолдлыг хамруулан зохицуулсан.
  - c. Дээрхийг хослуулсан.
2. Гэм хорын эрх зүй дэх гэм буруутай нөхцөлд хариуцлага хүлээх үндсэн зарчим үйлчлэхгүй тохиолдлыг нэрлэнэ үү.
  - a. Бусдад аюултай үйл ажиллагаа эрхэлсэнтэй холбоотой хариуцлага
  - b. Зан суртахууны үүднээс хариуцлага хүлээх нь зүйтэй нөхцөл
  - c. Гэм буруутай нь илт гэж үзэхээр тохиолдол
  - d. Дээрх бүгд зөв
3. Сэтгэл санааны хохирол учруулах нь ИХ-ийн §497-д заасан бусдын бие махбодь, эрүүл мэндэд халдсан гэсэн үг мөн үү?
  - a. Үгүй, энэ бол бие махбодийн гэмтэл биш
  - b. Гэм хор учруулсан үйлдлээс улбаатай сэтгэцийн эмгэг үүссэн бол дээрх зохицуулалтаар хамгаалагдана
4. Үндэслэлгүй хөрөнгөжих гэдэгт юуг ойлгох вэ?
  - a. Бусдын хөрөнгийг шилжүүлэн авсан боловч ингэх болсон эрх зүйн үндэслэл үгүй болох нь тогтоогдсон

- b. Суурь хэлцэл хүчингүй эсвэл хүчин төгөлдөр бус хэмээн тооцогдсон
- c. Ямар ч хэлцэл хийгдээгүй
- d. Дээрх бүгд зөв

## Дөрөв. Хэрэглэгдэхүүн

### Сурах бичиг, өгүүлэл:

1. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн тусгай анги, УБ хот 2013 он, Гурав дахь хэвлэл.
2. О.Жамбалдорж/Ж.Амарсайхан/ Ж.Ариунзаяа. Монгол Улсын Иргэний эрх зүй (Үүргийн эрх зүй, Гэрээний эрх зүй, Үүргийн эрх зүйн зарим тусгай төрөл), III дэвтэр, 2011 он
3. Ш.Сүхбаатар. Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он.
4. Дарьжав.Ц. “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бодитойгоор барагдуулах асуудалд”, “Монголын төр, эрх зүй” сэтгүүл. УДШ. 2003 он.№3
5. Бямбаа.Л. “Нэр, нэр төр, ажил хэргийн нэр хүндийн хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа нь” “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. ХЗҮТ. 2004 он. №2

### Гарын авлага, бодлогын хураамж:

1. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж I дэвтэр, УБ хот 2010 он.
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн бодлогын хураамж, II дэвтэр, 2011 он
3. Д.Энхзул. Иргэний эрх зүйн 40 бодлого, 2009 он.

### Хууль тогтоомж, шүүхийн практик:

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.




## НАЙМДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА

### 8.1.: Иргэний эрх зүйн хариуцлага, ойлголт хүлээлгэх үндэслэл

**Сэдвийн зорилго:** Иргэний эрх зүйн хариуцлага, түүний онцлог хүлээлгэх үндэслэлийн талаар онолын мэдлэг олж авах, иргэний эрх зүйн хариуцлагыг хууль зүйн бусад хариуцлагаас ялгах чадвар эзэмших, цаашид иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлж сонгон хэрэглэх хандлага төлөвшинө.

#### Нэг. Семинар

Иргэний эрх зүйн хариуцлага нь аливаа нийгэм дэх эрх зүйн хариуцлагын нэг төрөл боловч зарим талаараа бусад хариуцлагын төрлөөс эрс ялгарч байдаг. Хариуцлага хэмээх үгийн хэлзүйн утгыг авч үзвэл **зөрчил гаргагчид ноогдуулах шийтгэл** гэсэн утгатай бөгөөд энэ үүднээсээ иргэний эрх зүйн хариуцлага нь бусад хариуцлагын тогтолцоо, шинжийг агуулсан гэж хэлж болно.



Аливаа нийгэм дэх хариуцлагын тогтолцоог судлах, ангилал, төрлийг тодорхойлохын тулд хариуцлага хүлээж буй этгээд ямар зөрчил гаргасныг тогтоох нь чухал.

### **Эрх зүйн зөрчлийн тухай ойлголт**

Эрх зүйн онолын үүднээс авч үзвэл *эрх зүйн зөрчил* гэсэн ухагдахуун нь гэм хор учруулсан үйлдэл, гэмт хэрэг, захиргааны зөрчил зэрэг тухайн салбар эрх зүйн хэвшмэл ойлголтыг хамарсан нийтлэг нэр томъёо билээ. Мөн эрх зүйг позитив эсвэл жам ёсны онолын үүднээс авч үзсэнээс хамааран зөрчил гэдгийг илүү өргөн хүрээтэй тайлбарлах боломж нээгдэнэ. Бодит байдал дээр тодорхой эрх, үнэт зүйлсэд халдсаны улмаас холбогдох этгээдэд гэм хорын буюу иргэний эсвэл эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн аль нь зүйтэй болохыг тодорхойлох шаардлага гардаг.

♦ Эрүүгийн Хуулийн §16-д “Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ” хэмээн заасан тул эндээс Эрүүгийн Хуулиар хориглосон хэм хэмжээний бүрэлдэхүүнийг хангаж буй эрх зүйн зөрчлийг гэмт хэрэг гэж ойлгож болох нь харагдаж байна.

♦ Гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаагүй боловч нийтийн эрх зүйн хууль тогтоомжоор хориглосон эрх зүйн зөрчлийг захиргааны эрх зүйн зөрчил гэх бол тодорхой байгуулла, хамт олны дотоод дүрэм, журамд харш үйлдлийг захиргааны зөрчил гэнэ.

♦ Иргэний эрх зүйн хүрээнд бусдын хуулиар хамгаалагдсан эрх, үнэт зүйлсэд халдаж, хохирол учруулсан зөрчлийг гэм хор хэмээн үздэг. Үүнээс үүдээд гэм хорын эрх зүйн хариуцлага хэмээх ухагдахуун хэвшсэн. Харин гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн этгээдэд гэрээний хариуцлага ноогдуулдаг.

Практикт эрх зүйн тогтолцоонд тал бүрээс нь хамгаалсан эрхийг зөрчих нөхцөлд иргэний болон нийтийн эрх зүйн, ялангуяа эрүүгийн эрх зүйн салбарын хэм хэмжээний аль алиныг нь хэрэглэж, хариуцлага ноогдуулах боломжтой. Захиргаа болон эрүүгийн хариуцлага нь нийтийн эрх зүйн салбарт хамаарах тул нийгмээс тухайн зөрчилд оноох ял шийтгэл эсвэл торгуулийн асуудлыг хөндөх ба үндсэн зорилгын хүрээнд өөр хоорондоо хамт хэрэглэгдэхгүй. Харин зорилго агуулгын хүрээнд өөр өөр бол нэг зөрчлийн аль алиныг нь баримтлан шийтгэх явдал бий.

### **Иргэний эрх зүйн хариуцлага**

Нийгэмд үл зөвшөөрөгдөх эрх зүйн зөрчил гаргасан этгээд иргэн, хуулийн этгээдэд учруулсан гэм хор, хохирлыг нийтийн эрх зүйн хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран ямар ч нөхцөлд нөхөн төлөх үүрэгтэй. Тогтолцооны хувьд нэг этгээдээс нөгөөд гаргуулах хохирлыг хувь этгээд хоорондын тэгш эрхийн харилцааг хамарсан иргэний эрх зүйн салбарт хамааруулж үздэг. Үүнийг иргэний эрх зүйд гэм хор арилгах хэмээн тэмдэглэх ба энд гэм хорын эрх зүйн хариуцлага хөндөгдөнө.



Иргэний эрх зүйн хариуцлагыг тухайн зөрчилд хэрэглэгдэж буй хэм хэмжээний актаар нь салбар эрх зүйд хувааж болох ч гол төлөв гэрээний болон гэм хорын эрх зүй, мөн хөдөлмөрийн эрх зүйн хариуцлагын асуудал яригддаг. Гэрээний эрх зүйд гэрээний шийтгэл, анз, дэнчин, торгууль зэрэг үүргийн гүйцэтгэлийг хангуулах механизмыг ашиглан санкц ноогдуулах зохицуулалтыг гэрээнд тусгасанчлан хариуцлага хүлээлгэж, хор хохирлыг арилгуулдаг. Гэм хорын эрх зүйн хариуцлага нь гагцхүү хуулиар хориглосон эрхэнд халдсан нөхцөлд үүснэ. Эдгээрийн нийтлэг тал нь голчлон эдийн болон эдийн бус хохирлыг арилгуулахад чиглэдэгт оршино. Харин хөдөлмөрийн эрх зүйн хариуцлага нь явцуу утгаараа ажил олгогч, ажилтан хоорондын сахилгын шийтгэл болон бусад нөхөн төлбөрийн асуудлыг хамарч болно.

### **Иргэний эрх зүйн хариуцлага хүлээх хэлбэр, хязгаарлалт**

Холбогдох этгээдэд ноогдох хариуцлагын агуулга нь түүний хүлээсэн үүргээс хамаарах бол хөрөнгийн хэмжээг хэрхэн хамарч буйгаар хариуцлага хүлээх хэлбэр нь тодорхойлогдоно. **Үүрэг** гэдэгт үүрэг гүйцэтгэгчийн зүгээс ямарваа нэг үйлдэл, эс үйлдэхүйг хийх ёстой байх явдлыг ойлгох бол **хариуцлага** хүлээх гэдэгт үүрэг гүйцэтгүүлэгчийн зүгээс хүчээр гүйцэтгэлийг явуулахыг хүлцэн тэвчих гэсэн үг юм. Хэрэв үүрэг гүйцэтгэгч өөрт ноогдох үүрэгтээ хариуцлага хүлээх юм бол энэ хариуцлагын агуулга, объект нь юу байх вэ гэсэн асуулт тавигдана. Иргэний эрх зүйн салбарт хариуцлагын дараах хэлбэрийг ажиглаж болно. Үүнд:

#### **♦ Бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээх зарчим**

Рдийн тохиолдолд үүрэг гүйцэтгэгч нь бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ. Үүнийг бүрэн эсвэл хязгаарлагдмал бус, хөрөнгийн хариуцлага гэнэ. Энэхүү бүрэн хариуцлага нь үүрэг гүйцэтгэгч битүүмжлэх хөрөнгөгүй нөхцөлд төдийлөн ач холбогдолгүй байдаг. Тиймээс энэ тохиолдлоос сэргийлэн үүрэг гүйцэтгүүлэгчид тодорхой эд хөрөнгийг барьцаалах явдал илүү ашигтай байх талтай. Ингэснээр үүрэг гүйцэтгэгч тодорхой эд хөрөнгийн хариуцлага хүлээж байна гэж ойлгоно.

#### **♦ Хөрөнгийн хэсгээр хариуцлага хүлээх**

Онцгой тохиолдолд үүрэг гүйцэтгэгч нь бүх хөрөнгөөрөө бус харин бие даасан хөрөнгийн хэсгээр хариуцлага хүлээхээр байж болно. Үүнийг хязгаарлагдмал, хөрөнгийн хариуцлага гэнэ. Жишээ нь, өв залгамжлагч өв залгамжлуулсан этгээдийн өрийг зөвхөн өвийн хэмжээгээр хариуцна.

#### **♦ Биеэрээ хариуцлага хүлээх**

Үүрэг гүйцэтгэгч нь мэдээлэл зааварчилгаа өгөх, бичиг баримт үйлдэх зэрэг зөвхөн түүний хүсэл зоригоос хамаарах үйлдэл хийхээр амласан бол


үүнийг гүйцэтгүүлэхийн тулд торгууль, ноогдуулах, баривчлах асуудал яригддаг. Ховорхон тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийг баривчлах зэргээр биеэр нь хариуцлага хүлээлгэх нь бий.

## ♦ Хариуцлага хүлээдэггүй үүрэг

Хариуцлага араасаа дагуулдаггүй үүрэг гэдэгт үүрэг гүйцэтгэгч биелүүлж болох ч үүрэг гүйцэтгүүлэгч үүнийг хууль сахиулах байгууллагаар албадан гүйцэтгүүлж үл болох үүргийг ойлгоно. Эл үүргийг нэхэмжлэх боломжгүй эсвэл шийдвэр гүйцэтгэлийн замаар гүйцэтгүүлж болохгүй тул үүнийг бүрэн бус үүргийн төрөл буюу жам ёсны үүрэг гэж нэрлэх нь бий. Харин үүрэг гүйцэтгэгч энэ үүргийг биелүүлсэн бол шилжүүлгийг үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой зүйл заалтаар буцаан шаардах эрхгүй. Учир нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зүгээс нэхэмжилж үл болох хэдий ч холбогдох шаардлага үүссэн байгаа билээ. Өнөөгийн нөхцөлд ийм жам ёсны үүрэг гэдэгт хэрэгжүүлэх боломжгүй үүргүүдийг хамруулан ойлгоно.

Жишээ нь, тоглоом мөрий, гэр бүл зуучлах тохиолдлуудад эдгээр гэрээнд тусгасан үүргийг хэрэгжүүлэх албадан хэрэгжүүлэх боломжгүй. Мөн үүрэг гүйцэтгэгч энэ үүргийг гүйцэтгэсэн бол буцаан шаардах эрхийг шүүхээр хэрэгжүүлэхгүй хэмээн хууль тогтогч шийдвэрлэсэн байна.

## Иргэний эрх зүйн хариуцлагын төрөл хэлбэр:



## Хоёр. Дасгал

а). А замын хөдөлгөөний осол гаргасан бөгөөд үүний улмаас Б-ийн бие махбодь хүнд гэмтэж, машин нь эвдэрсэн байна. Замын цагдаа ослын газар ирж түүнд торгууль ноогдуулсан ба удалгүй түүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх асуудал яригдаж, мөн Б иргэний журмаар хохирлоо нэхэмжилсэн байна.

б). Б залилангийн бүрэлдэхүүн бүхий үйлдлийг улмаас А-ийн мөнгийг авч ашигласан бөгөөд эрүүгийн процессын явцад А мөнгийг эргүүлж өгөлгүй удсантай холбоотой эдийн засгийн хохирлоо нэхэмжилсэн байна. Үүнийг эрүүгийн хэргийг хариуцаж байсан шүүгч шийдвэрлэж болох уу?



в). Дээрх тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгээгүй байсан ба А шууд гэм хорын нэхэмжлэлийг шүүхэд гаргасан бол хэрхэх вэ? Шүүгч эрүүгийн хэрэг үүсгэж болох уу?

### **Гурав. Хяналтын асуулт :**

1. Иргэний эрх зүйн хариуцлагын онцлог, шинжийг тайлбарлана уу.
2. Иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлно уу.
3. Иргэний эрх зүйн хариуцлагын төрөл, хэлбэрийг тодорхойлно уу.
4. Иргэний эрх зүйн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлийг тайлбарлана уу.

### **Дөрөв. Хэрэглэгдэхүүн**

1. Б.Улаанбаатар. “Иргэний эрх зүй: тайлбар толь” 2005 он
2. Ш.Сүхбаатар. Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он.
3. Т.Мөнхжаргал. МУ-ын Иргэний эрх зүй, УБ хот 2007 он.
4. Наранчимэг Д. “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ, 1999 он
5. Б.Баттөмөр. МУ-ын Иргэний эрх зүйн зарим асуудал, УБ хот 2005 он.
6. Баярсайхан. Д. “Ромын иргэний эрх зүйн үнэт зүйлс” хуульчдын номлол, сонгодог ойлголт. Шихихутуг УБ.2000 №1
7. Цолмон. Ц. Иргэний эрх зүйн хариуцлага ба хамгаалалтын арга хэмжээг тодорхойлоход. “Эрх зүй” УБ. 2000 №2-3
8. Сугар. Д. “Монгол Улсын иргэний хуулийн шинэтгэл” Монголын төр, эрх зүй” УБ. 2002 № 2

### **Хууль тогтоомж, шүүхийн практик:**

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он.
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он.

